

**“ДОРНОД МОНГОЛЫН ХУУРАЙ ХЭЭРИЙН ТОГТВОРТОЙ
ЛАНДШАФТ, БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ХАМГААЛАЛ
ТӨСӨЛ”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

2021-2026

МОНГОЛ ОРНОД ХУУРАЙ, ГАНДУУ БҮС НУТГИЙН ТОГТВОРТОЙ МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ТААТАЙ ОРЧИН БҮРДҮҮЛЭХ 5

- Байгаль орчны асуудлыг харгалзсан шинэлэг аргачлалаар аймаг, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө 6

ДОРНОД МОНГОЛЫН ХУУРАЙ ХЭЭРИЙН БҮСЭД ГАЗРЫН ТОГТВОРТОЙ МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ 12

- Бэлчээр нөхөн сэргээсэн үр дүн 17
- Нүүдлийн зүйлийн чухал амьдрах орчин, холбоос нутаг, өвөрмөц экосистем 19
- Мал сүргийн эдийн засгийн эргэлтийг түргэтгэх, ашиг шимийг нэмэгдүүлэх, сүлжээ 25
- Сүүний үйлдвэрлэл, нэмүү өртгийн сүлжээ 28
- Махны нэмүү өртгийн сүлжээ 31
- Бага хүчин чадлын мал нядалгаа, дайвар боловсруулах үйлдвэр 35
- Ноолуурын нэмүү өртгийн сүлжээ 38
- Хонины ноосны үнэ цэнийг нэмэгдүүлэх шинэлэг арга 39
- Хадгаламж зээлийн хоршоо 42
- Тэжээл үйлдвэрлэл, даван туулах, дасан зохицох чадавх . . 45
- Мал аж ахуйн эрсдэлийг бууруулах, даван туулах чадавхыг бэхжүүлэх загвар 53

БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, ГАЗАР НУТГИЙН НЭГДМЭЛ БАЙДЛЫГ ХАНГАХ 66

- Цагаан зээрийн судалгаа, амьдрах орчны хамгаалал 66
- Цэн тогорууны судалгаа, амьдрах орчны хамгаалал 69
- Байгалийн нөөц, газрын менежмент 73
- Байгалийн нөөц газарт түшиглэсэн, зөгийн балны өртгийн сүлжээ 78
- Ургамалжлын судалгааны үр дүн 82
- Байгаль хамгааллын боловсрол – мэдлэгээс үйлдэлд 84

МЭДЛЭГ, МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГААНЫ БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД . . 97



Ц.УРАНЧИМЭГ,
БОУАӨЯ-ны Тусгай
хамгаалалттай
газар нутгийн
бодлогын газрын
дарга, Төслийн
Үндэсний захирал

Дэлхийн хэмжээний хамгааллын үнэ цэнтэй, хүний нөлөөнд бага өртөж унаган төрхөө харьцангуй хадгалсан Дорнод Монголын хуурай хээрийн бүсэд газрын доройтлыг бууруулах, биологийн олон янз байдлыг хамгаалах төслийг 2021 оноос эхлэн амжилттай хэрэгжүүлээ.

Даян дэлхийн байгаль орчны сан (GEF)-гийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр “Ойн тогтвортой менежмент” уриан доор хэрэгжиж буй Даян дэлхийн нөлөөллийн 11 орны нэгд Монгол улс багтсан нь Монголын хөдөө аж ахуй, хүнсний томоохон үүц даац, хялганат хээрт уламжлалт бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг нутгийн зон олон, Монгол цагаан зээр зэрэгцэн орших дэлхийн хэмжээнд үлдэж хоцорсон сүүлчийн үргэлжилсэн тал хээрийг хамгаалахын ач холбогдлыг харуулж байгаа биз ээ.

Байгалийн нөөцийн ашиглалтад суурилсан хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих болон байгаль орчин, байгалийн нөөц, нүүдлийн зүйлийг хамгаалах эрс тэс мандатыг хэрэгжүүлдэг байгууллагууд хэдий ч НҮБ-ын ХХААБ, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн манлайлал дор газрын нэгдмэл түвшинд байгаль орчны асуудлыг харгалзан боловсруулсан сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газрын доройтлыг бууруулах, байгаль орчин, экосистемийн нөхөн сэргээлтийн арга хэмжээг амжилттай хэрэгжүүлсэн нь олон улсын төдийгүй үндэсний түвшинд бас нэгэн сайн туршлага боллоо.

Байгаль орчны хамгаалал, хүнс, хөдөө аж ахуй, газрын харилцааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг яам, агентлаг, аймаг, сумын удирдлагууд, малчид, тариаланчид, нутгийн иргэдийн идэвх санаачилга, хамтын ажиллагаа, хамтарсан санхүүжилтээр Дорнод хээрийн бүсэд бэлчээрийн газрын засаглал бэхжиж, малчдын орлогыг бууруулахгүйгээр малын тоо толгойг бууруулахад чиглэсэн шинэлэг, загвар бий болсон, нүүдлийн зүйлүүдийн чухал амьдрах орчныг хамгаалсан, байгалийн нөөцийн хамтын менежмент сайжирсан зэрэг эерэг үр дүн, сайн туршлагыг цаашид бусад аймаг, сум, тусгай хамгаалалттай газруудад түгээн дэлгэрүүлэхэд яамны зүгээс анхааран ажиллах болно.

Түүнчлэн эдгээр сайн туршлага нь Бэлчээр ба нүүдлийн мал аж ахуйг эрхлэгчдийн Олон Улсын жил, Цөлжилттэй тэмцэх конвенцийн талуудын 17-р бага хурлын хүрээнд Монгол Улсын гаргасан санаачилгыг ахиулах, манлайллыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

Энэхүү чухал ач холбогдолтой төслийг санхүүжүүлж буй Даян дэлхийн байгаль орчны сан, төслийг хамтран хэрэгжүүлсэн НҮБ-ийн Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF), төслийн баг, хамтран ажилласан төрийн болон орон нутгийн байгууллагууд, хувийн хэвшил, ТББ, бүлэг, хоршоо, нутгийн иргэд, малчдад чин сэтгэлийн талархал илэрхийлж улам их амжилт хүсье.

ТӨСЛИЙН ОНЦЛОГ Даян дэлхийн байгаль орчны сан (GEF)-гийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр "Ойн тогтвортой менежмент" Даян дэлхийн нөлөөллийн хөтөлбөрт хамрагдсан 11 оронд хэрэгжиж буй төслийн нэг юм.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО Дэлхийн хэмжээний хамгааллын үнэ цэнтэй, хүний нөлөөнд бага өртөж, унаган төрхөө харьцангуй хадгалж үлдсэн үргэлжилсэн тал хээр болох Дорнод Монголын хуурай хээрийн бүсэд талуудын оролцоо, газар нутгийн нэгдмэл түвшин, зах зээл-өртгийн сүлжээнд тулгуурлан, байгаль хамгаалал, нутгийн иргэдийн тогтвортой, дасан зохицсон амьжиргааг дэмжих замаар хуурай, гандуу бүс нутгийн экосистемийн доройтлыг бууруулж, биологийн олон янз байдлыг хомсдохоос урьдчилан сэргийлэхэд оршино.

ЗОРИЛТ:

1. Газрын тогтвортой менежментийг хэрэгжүүлэх эрх зүйн таатай орчин бүрдүүлэх,
2. Газрын тогтвортой менежментийг сайжруулах,
3. Биологийн олон янз байдлын хамгаалал, газар нутгийн нэгдмэл байдлыг сайжруулах,
4. Төслийн үр дүнд бий болсон мэдлэг, сайн туршлагыг түгээх

САНХҮҮЖИЛТ

- Даян дэлхийн байгаль орчны сан (GEF): 5,354,586 ам.доллар
- Хамтарсан санхүүжилт: 50,945,000 ам.доллар
- Нийт төсөв: 56,299,586 ам.доллар

ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА

- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
- НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага
- Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар

ТӨСӨЛ ХЭРЭГЖСЭН ГАЗАР

Аймаг: 3

- Дорнод, Хэнтий, Сүхбаатар

Сум: 9

- Дорнод аймгийн Хөлөнбуйр, Матад, Булган,
- Хэнтий аймгийн Баян-Адарга, Баян-Овоо, Норовлин,
- Сүхбаатар аймгийн Түмэнцогт, Сүхбаатар, Мөнххаан сумд болон

Байгалийн нөөц газар: 6

- Тосон хулстай,
- Хар ямаат,
- Баянцагааны тал,
- Жаран тогооны тал,
- Мэнэнгийн цагаан хоолой,
- Улз голын эх

ЗОРИЛТ

МОНГОЛ ОРОНД ХУУРАЙ, ГАНДУУ БҮС НУТГИЙН ТОГТВОРТОЙ МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ТААТАЙ ОРЧИН БҮРДҮҮЛЭХ

Оролцоонд суурилсан газар зохион байгуулалтын нэгдмэл төлөвлөлт хийх институцийн чадавх сайжрав.


- Зөвхөн төрийн байгууллагын төлөөллөөс бүрддэг байсан газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий аймаг, сумын Ажлын хэсэгт малчид, тариаланчдын холбоо, байгаль хамгааллын нөхөрлөл зэрэг газар ашиглагчдын төлөөлөл, иргэдийн Хурлын Төлөөлөгчдийг оруулсанаар олон талт, салбар дундын байнгын ажиллагаатай механизм бий болсон. Мөн аймгийн Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд сумдын Засаг дарга нар орсноор аймаг болон сумын түвшний газар зохион байгуулалтын төлөвлөгөө хоорондын уялдаа бэхжсэн.
- Уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтол, биологийн олон янз байдлын хамгаалал, жендэрийн тэгш оролцоотой газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулахад оролцоог жигд хангахад чиглэсэн цуврал сургалтад Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хамруулж институцийн чадавхыг бэхжүүлсэн.
- Сургалтын үр дүнд Ажлын хэсэг нь газрын мэргэжлийн байгууллагыг шаардлагатай мэдээллээр ханган, хамтран ажилласнаар газрыг тогтвортой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг түлхүү тусгасан газар нутгийн хувьд нэгдмэл төлөвлөгөө боловсруулдаг боллоо.
- Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг газрын нэгдмэл сангийн удирдлагын цахим систем (www.egazar.gov.mn) болон аймаг, сумдын албан ёсны цахим сүлжээнд нээлттэй байршуулж, иргэд саналаа өгөх боломж бүрдсэн.
- Сумын Ажлын хэсгийн манлайлал дор газрын мэргэжлийн байгууллага багийн иргэдийн Нийтийн Хурлаар төлөвлөгөөний төслийг хэлэлцүүлэхдээ жендэрийн тэгш оролцоог ханган ажилласан.

БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДЛЫГ ХАРГАЛЗСАН ШИНЭЛЭГ АРГАЧЛАЛААР АЙМАГ, СУМЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛАВ

- Аймаг, сумын газар зохион байгуулалтын урт болон дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулахдаа газрын доройтлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, биологийн олон янз байдлыг хамгаалах асуудлыг тусгадаг болов.
- Ингэхдээ газрын доройтол, бүтээмж, уур амьсгалын өөрчлөлт, түүний цаашдын чиг хандлагыг шинжлэх ухаан, технологийн дэвшилд суурилсан зайнаас тандан судлалын нээлттэй мэдээллийн эх сурвалж болох QGIS-Trends Earth болон IPCC WGI интерактив атлас ашиглан дүн шинжилгээ хийх арга зүйг газрын мэргэжлийн байгууллагууд эзэмшсэнээр газрыг хамгаалах, нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, даван туулах арга хэмжээг нарийвчлан төлөвлөдөг болсон.
- Цагаан зээрийн холбоос нутаг, чухал амьдрах орчин, төллөх газрын суурь судалгаанд үндэслэн шинээр төлөвлөж буй авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан стандартад нийцсэн гарц, гарам байгуулах байршил, цагаан зээр төллөх үеэр мал бэлчээх, хадлан авахыг хориглох зэрэг арга хэмжээг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан.
- Цэн тогорууны мониторинг судалгаанд үндэслэн үрждэг, олноор цуглардаг чухал амьдрах орчныг байгаль орчин, мал, амьтдад хал багатай хашааны загвар ашиглаж хашиж хамгаалах арга хэмжээг төлөвлөсөн.
- Атаршсан тариалангийн газрын хил заагийг тодорхойлж, нөхөн сэргээх технологи ашиглан эдийн засгийн эргэлтэд оруулах, салхины хамгаалалтын ойн зурвас байгуулах, хөдөө аж ахуйн хоршоодод 5 хүртэлх газарт малын тэжээл тариалах зориулалтаар эзэмшүүлэх зэрэг арга хэмжээг төлөвлөсөн нь хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх замаар эрүүл хүнс үйлдвэрлэхэд чухал ач холбогдолтой ажил болсон.
- Бэлчээрийн сэргэх чадавхийг харгалзан доройтсон бэлчээрийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг нийт 1,768,520 га буюу зорилтот 9 сумын газар нутгийн 26 хувийг хамруулан төлөвлөсөн нь бэлчээрийг засаглах уламжлалаа сэргээх, газрын доройтлыг бууруулах, тэглэх зорилтыг хэрэгжүүлэх үндэс суурь болов.
- Төлөвлөгөө боловсруулах явцад Сүхбаатар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг баталсан нь Зүүн бүсийн хэмжээнд усны нөөц, ундны усны эх үүсвэрийг хамгаалах нэгдсэн менежмент хэрэгжүүлэх замаар Усны тухай хуулийн хэрэгжилтийг хангах боломжийг бүрдүүлсэн.

- Зүүн бүсийн 27 тусгай хамгаалалттай газар нутгийг хамруулан анх удаа Тусгай хамгаалалттай газар нутаг дахь газар ашиглалтаас үүдэлтэй нөлөөллийг зурагласан нь Монгол Улсын газрын сан нэгдмэл байх зарчмыг хангасан төдийгүй орон зайн хувьд тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөлтийг боловсронгуй болгоход хувь нэмэр оруулсан.
- Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн урт хугацааны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг шинэлэг аргачлалаар боловсруулахдаа бэлчээр, нүүдлийн зүйл, өвөрмөц экосистемийн хамгаалал, усны нэгдсэн менежмент зэрэг бүсийн хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээг нэгдмэл байдлаар төлөвлөсөн нь Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын Зүүн бүсийн хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх орон зайн төлөвлөлт болсон.

Зураг 1.
Уур амьсгалын өөрчлөлтийн хандлага IPCC интерактив атлас



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЦАХИМ СИСТЕМ ИЙН НЭМЭЛТ ХӨГЖҮҮЛЭЛТ




Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын (ГЗБГЗЗЕГ) 2014 оноос хөгжүүлж буй бүх шатны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг дагалдах газрын зургийн хамт нээлттэй, ил тод байршуулсан “Газрын нэгдмэл сангийн удирдлагын үндэсний цахим систем (www.egazag.gov.mn)”-д төслийн дэмжлэгтэй дараах нэмэлт хөгжүүлэлт хийснээр төлөвлөгөөний ашиглалт, хэрэглээ, мониторинг сайжрах боломж бүрдэв. Үүнд:


- Газар ашиглагч, шийдвэр гаргагчид цахим орчинд бүх шатны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, ялангуяа газрын доройтлыг бууруулах, нөхөн сэргээхтэй холбоотой төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг дашбоардаар дамжуулан нээлттэй хянах;
- Нүүдлийн зүйлүүдийн тархац нутаг, холбоос нутаг, төллөдөг газар, чухал амьдрах орчны тоон мэдээллийг “Биологийн олон янз байдлын статистик” дэд цэсээс нээлттэй татаж авах, газрын төлөвлөлтөд ашиглах;
- Бэлчээрийн фотомониторингийн судалгааны үр дүнг 5 жилээр харьцуулан гаргасан тайлантай танилцах, татаж авах, улмаар сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд доройтсон бэлчээрийг сэлгэж өнжүүлэх, сэргэх чадавхыг сайжруулах арга хэмжээг төлөвлөх, өөрсдийн ажлын үр дүнд үнэлэлт дүгнэлт өгөхөд ашиглах;

- 2024 онд ГЗБГЗЗЕГ-аас баталсан “Бэлчээрийн фотомониторингийн цэгийн төлөөлөх талбайг зураглах арга зүй”-г ашиглан улсын хэмжээний 5314 цэгийн төлөөлөх талбайг зурагласан нь бэлчээрийн даацыг 3.4 дахин нарийвчлалтайгаар тодорхойлох, мал аж ахуйн үйлдвэрлэлийн эрсдлийг бууруулах арга хэмжээг оновчтой төлөвлөхөд чухал ач холбогдолтой ажил болсон;
- “Belcheer” гар утасны аппликейшнийг шинээр хөгжүүлж, үндэсний хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлсэн нь газрын даамал, бэлчээрийн мэргэжилтний ажлын ачааллыг бууруулах, ажлын гүйцэтгэлийг хянах, бэлчээрийн фото мониторингийн судалгааны үр дүнг чанаржуулахад хувь нэмэр оруулсанаас гадна малчид, нутгийн иргэд газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд санал өгөх, аймаг, сумын түвшинд шинжлэх ухаанд суурилсан шийдвэр гаргах хэрэгсэл болсон.
- Нэгдмэл газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах, газрын мониторингийн үндэсний тогтолцоог бэхжүүлэх, салбар дундын мэдээлэл солилцох сайжруулах чиглэлээр 2022, 2025 онуудад зохион байгуулсан арга хэмжээ, хамтын ажиллагааны үр дүнд тариалангийн газрын 300 мониторингийн цэг, хөрсний бохирдлын болон агаарын чанарын мэдээллийг багтаасан үндэсний хэмжээний дундын мэдээллийн санг үүсгэв.

Зураг 2. Цахим хөгжүүлэлт




Биологийн олон янз байдлын статистик дэд цэс



Belcheer гар утасны аппликейшн

ГЗБТ-ны төлөвлөгөөний хэрэгжилт хянах самбар




Бэлчээрийн фотомониторингийн үр дүнгийн тайлан 5 жилээр

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХ БЭХЖИВ.



- Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалт, Засгийн газрын 2020 оны “Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай” 60-р тогтоолын дагуу ГЗБГЗЗЕГ нээлттэй сонгон шалгаруулалтаар аймаг, сумын газар зохион байгуулалтын нэгдсэн төлөвлөгөө боловсруулах шинэлэг аргыг эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулах, салбарын мэргэжилтнийг давтан сургах, мэргэшлийн зэрэг олгох, сунгах эрхийг “Монголын газар зохион байгуулалтын холбоо” ТББ-д олгосон. Үүний дагуу тус ТББ нь “Газрын доройтол, биологийн олон янз байдал, уур амьсгалын өөрчлөлт, оролцоо, жөндөрийн асуудлуудыг харгалзсан газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах сургалтын хөтөлбөр”-ийг холбогдох мэргэжлийн байгууллага, их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудын оролцоотой шинэчлэн боловсруулж ГЗБГЗЗЕГ-аар 2025 оны 12-р сард батлуулсан.
- Хөтөлбөрийн дагуу газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах шинэлэг арга зүй эзэмшсэн 40 газрын зөвлөх болон мэргэшсэн инженерүүд мэргэшлийн зэрэг авав.
- “Монголын газар зохион байгуулалтын холбоо” ТББ, “Монголын газрын менежментийн нэгдсэн эвсэл” ТББ хамтран жил бүр батлагдсан хөтөлбөрөөр сургалт зохион байгуулж, ГЗБГЗЗЕГ мэргэжлийн зэрэг олгох тул цаашдын тогтвортой байдал хангагдах нөхцөл бүрдэв.

“Шинэ төгсөгчөөс шийдвэр гаргагч руу: Бэлчээрийн менежментийн шинэ үе”



Б.Анхтуяа
Дорнод аймгийн
Хөлөнбуйр сумын
ЗДТГ-ын газрын
даамал

Би 2024 онд Хөдөө аж ахуйн их сургуулийг төгсөөд, 2025 оны 5 сараас төрөлх Хөлөнбуйр сумандаа газрын даамлаар ажиллаж эхэлсэн. Шинэ төгссөн залуу мэргэжилтний хувьд онолын мэдлэг байсан ч бодит ажил дээр гараад ирэхэд туршлага, арга зүй маш их хэрэг болдог юм билээ.

Яг энэ үед манай суманд “Дорнод Монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янз байдлын хамгаалал” төсөл хэрэгжиж байсан нь миний хувьд хамгийн том боломж болсон. Миний ажлын гол цөм бол бэлчээрийн менежмент. Харин энэ төсөл надад бэлчээрийг зөвхөн “хараад үнэлэх” биш, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судалж, баримтад тулгуурлан дүгнэх

арга барилыг суулгаж өгсөн.

Төслийн хүрээнд бэлчээрийн даац тодорхойлох, фото мониторинг хийх зэрэг мэргэжлийн сургалтуудад тогтмол хамрагдсан. Сургалтаар сурсан зүйлээ маргааш нь шууд ажил дээрээ туршиж, бодит судалгаа болгон хэрэгжүүлж байсан. Залуу хүний хувьд “би чадна” гэсэн итгэл тэндээс л эхэлсэн гэж боддог.

Мөн судалгаанд зайлшгүй хэрэгтэй GPS, фото мониторингийн багаж хэрэгсэл, гарын авлагаар хангаж өгсөн нь миний ажлыг огт өөр түвшинд гаргасан. Өмнө нь ерөнхий ажиглалтаар ярьдаг байсан бол одоо би тоон мэдээлэл, зураг, харьцуулсан судалгаанд тулгуурлаж тайлан гаргаж, удирдлагад танилцуулж байна. Энэ бол миний мэргэжлийн хамгийн том ахиц.

Манай сум 360,787 га бэлчээрийн талбайтай, нийт 17 фотомониторингийн цэгтэй. 2025 оны судалгаагаар 5 цэг унаган төрхөөрөө, 8 цэг бага зэрэг доройтсон, 2 цэг нэлээд өөрчлөгдсөн, 1 цэг хүчтэй, 1 цэг маш хүчтэй доройтсон гэсэн дүн гарсан. Энэ тоо бол зүгээр нэг статистик биш бид хаана анхаарах, хаана яаралтай арга хэмжээ авах ёстойг зааж өгсөн чиглэл юм.

Бид ажлын хэсгээрээ хуралдаж, доройтсон бэлчээрийг өнжөөх, амраах, сэргээх тодорхой шийдлүүдийг боловсруулсан. Эдгээрийг 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, батлуулан хэрэгжүүлж эхлээд байна. Өөрөөр хэлбэл судалгааны дүн маань бодит шийдвэр, бодит ажил болж хэрэгжиж байна.

Миний хувьд хамгийн их бахархдаг зүйл бол - би зүгээр нэг албан тушаал хашиж байгаа биш, нутаг орныхоо бэлчээрийн ирээдүйд хувь нэмэр оруулж байна гэдгээ мэдэрч байгаа явдал. Шинэ төгсөгчөөс богино хугацаанд бие даан судалгаа хийж, дүн шинжилгээ гаргаж, төлөвлөгөөнд тусгуулдаг мэргэжилтэн болж төлөвшихөд энэ төсөл маш их нөлөөлсөн.

Цаашдаа доройтсон цэгүүдийн зэрэглэл буурч, бэлчээр сэргэж эхлэхэд “энэ ажилд миний хөдөлмөр шингэсэн” гэж хэлэх боломжтой болно. Тэр үед л жинхэнэ амжилтаа илүү тод мэдэрнэ гэж бодож байна. Гэхдээ өнөөдрийн хувьд шинжлэх ухаанд суурилсан, бодит мэдээлэлд тулгуурласан төлөвлөлтийг сумандаа нутагшуулж чадсан нь миний хамгийн том амжилт гэж хэлмээр байна.

🔍 ҮНДЭСНИЙ ТҮВШНИЙ ҮР ДҮН

- Газрын тогтвортой ашиглалтын гурван зарчмыг хэрэгжүүлэх замаар газрын доройтлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулав.
- Төсөл болон орон нутгийн хамтарсан санхүүжилтээр Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн **нийт 28,954,153 га** нутаг дэвсгэрийг хамарсан **12-16** жилийн хугацаатай “Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө”, түүнд уялдсан зорилтот 9 сумын **6,863,380 га** нутаг дэвсгэрийг хамарсан **5-7** жилийн хугацаатай “Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө” 2024 оноос эхлэн хэрэгжиж байна.
- Төсөл хэрэгжсэн аймаг, сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах явцад гарсан амжилт, сургамжид тулгуурлан 2024 онд “Газар зохион байгуулалт хийх журам”-ыг Монгол Улсын Засгийн газар, “Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний аргачлал” болон “Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний аргачлал”-ыг ГЗБГЗЗЕГ тус тус шинэчлэн баталж, үндэсний хэмжээнд мөрдөж байна.
- Үүний үр дүнд 2026 оны 02 дугаар сарын байдлаар орон нутгийн төсөв, олон улсын төсөл, хөтөлбөрийн дэмжлэгээр боловсруулсан Монгол Улсын газар нутгийн 52.8%-ийг хамарсан 9 аймаг, 39 сумын газар зохион байгуулалтын нэгдсэн төлөвлөгөө хэрэгжиж байна.
- 2026 онд Монгол Улсын нийт нутгийн 26%-ийг хамарсан 8 аймгийн 71 сумын 33,535,136 га талбайд сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулж байна.

ЗОРИЛТ

ДОРНОД МОНГОЛЫН ХУУРАЙ ХЭЭРИЙН БҮСЭД ГАЗРЫН ТОГТВОРТОЙ МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ

БЭЛЧЭЭРИЙН ДОРОЙТЛЫГ БУУРУУЛАХ ТОГТВОРТОЙ МЕНЕЖМЕНТ



Зураг 3. Төслөөс хэрэгжүүлсэн цогц үйл ажиллагаа

ОРОН НУТАГТ БЭЛЧЭЭРИЙН ЗАСАГЛАЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН САЙЖРАВ.



- Газрын тухай хуулийн 20.1.6-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам манлайлан Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтнүүд аймгийн түвшинд бэлчээрийн газрыг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх жишиг журмын төслийг боловсруулахад дэмжлэг үзүүлэн ажиллав. Үүний дүнд Дорнод, Сүхбаатар аймгийн 17,202,431 га бэлчээр, хадлангийн газрыг зохистой ашиглах, хамгаалах журмыг аймгийн ИТХ-аар баталсан нь сумдын бэлчээрийн журмын хэм хэмжээ ижил болгохын зэрэгцээ шаардлагатай тохиолдолд болон гамшгийн нөхцөл байдалд сум дундын бэлчээрийн менежмент хийх, зохистой ашиглах, өнжүүлж сэлгэх эрх зүйн орчин бий болов.
- Төслийн дэмжлэгээр Сүхбаатар аймгийн Мөнххаан, Сүхбаатар, Түмэнцогт, Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын нийт 2,065,466 га бэлчээр, хадлангийн газрыг хамруулан хэрэгжүүлэх “Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах” журмыг сумын ИТХ-аар батлуулан хэрэгжүүлж байна.

СУМЫН ТУХАЙН ЖИЛИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД СУУРИЛСАН БЭЛЧЭЭРИЙН ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭВ.

- Аймаг, сумын удирдлагууд, мэргэжилтнүүд, ИТХ-ын төлөөлөгчдийг оролцуулан зохион байгуулсан чадавх бэхжүүлэх үйл ажиллагааны үр дүнд Байгалийн нөөц ашигласны төлбөр, Малын тоо толгойн албан татвар зэрэг орон нутгийн төсвийн эх үүсвэрийг байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээхэд арга хэмжээнд үр дүнтэй ашигладаг боллоо.
- Төслийн хүрээнд хийсэн судалгаагаар малын тоо толгойн албан татвар нь бэлчээрийн доройтлыг бууруулахад нөлөө үзүүлэхгүй байгааг харгалзан татварын бодлогыг чангатгах, экосистемийн үйлчилгээний үнэлгээ болон Байгалийн нөөц газар (БНГ)-ын горимд тулгуурласан татварын шинэ тогтолцоог хөгжүүлж бэлчээр хамгаалах арга хэмжээнд түлхүү зарцуулах зэрэг саналыг НҮБ-ын ХХААБ-аас гаргаж буй “Малын тоо толгойн албан татварын хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах бодлогын зөвлөмж”-д тусгуулав.

- Төслийн зорилтот сумдын 6,863,380 га газар нутгийг хамарсан “Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө (НДХТ)”-нд бэлчээрийн төлөв байдлыг (ТХГН багтсан) харгалзан хамгаалах, нөхөн сэргээх бэлчээрийн байршил, хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчлан төлөвлөсөн.
- 2022-2024 онд сумдад талбайн сургалтын үзүүлэн болгох зорилгоор 0.5-1 га доройтсон бэлчээрийг хашиж хамгаалан ургамлын сэргэн ургалтын эхний 2-3 сар ашиглалтаас чөлөөлсөн туршилт судалгааг хийхэд ургамлын тусгаг бүрхэц 18-45%, зүйлийн баялаг 2-8 зүйлээр тус тус нэмэгдсэн.



Зураг 4. Доройтсон бэлчээрийг хашаалж, сэргээх чадавхийг тодорхойлох, үр дүнг талбайн сургалтанд ашигласан. Дорнод аймгийн Булган сум.

- Дээрх туршилт судалгаанд үндэслэн төслийн санал болгосон шийдлийн дагуу сумын газрын даамал, бэлчээрийн мэргэжилтэн, багийн даргын манлайлал доор багийн малчдын шийдвэрээр өнжөөх, сэлгэх, даацад тохируулан ашиглах арга хэмжээг хамтран төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах дасгал ажлуудыг ашиглан, бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг тухайн жилийн ГЗБТ-нд тусган бүх шатанд хамтран хэрэгжүүлдэг болсноор бэлчээрийн засаглал сайжирсан.
- 2022-2025 онуудад 20 удаагийн танхимын сургалт, уулзалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөн болон туршилтын талбайд дадлагажуулах сургалтад аймаг, сумын газар зохион байгуулалтын ажлын хэсэг, тухайлбал ЗД-ын орлогч, газрын даамал, бэлчээрийн мэргэжилтэн,

байгаль орчны байцаагч, багийн дарга болон малчдын төлөөлөл 11,664 (47% эрэгтэй, 53% эмэгтэй) хүнийг хамруулснаар бэлчээрийг өнжөөж сэлгэхийн ач холбогдол, үр нөлөөний талаарх ойлголт, мэдлэг, хандлага сайжрах нөхцөл бүрдсэн.

Зураг 5.
Бэлчээрийн засаглалыг оновчтой хэрэгжүүлэх бүдүүвч зураг



Зорилтот сумдын хэмжээнд нийт 168 фотомониторингийн цэгт жил бүр хээрийн судалгаа, боловсруулалт хийж бэлчээрийн төлөв байдлын өөрчлөлтийн судалгааг 6,390,392 га (бэлчээр, хадлан, ТХГН) талбайг хамруулан гүйцэтгэж байна.

Зураг 6.
Бэлчээрийн менежментийн арга хэмжээ, Дорнод аймгийн Хөлөнбуйр сум.




2024 онд МУИС-ийн судалгааны баг Тосон Хулстайн БНГ-ын фото мониторингийн 15 цэгт судалгаа хийж, судалгааны үр дүнгээ дээрх сумын газрын даамлуудын бэлчээрийн фотомониторингийн судалгааны үр дүнтэй харьцуулан үзэхэд статистикийн бодит ялгаа байхгүй гэсэн дүгнэлт гарсан.

Мөн дискметр багажаар бэлчээрийн биомассыг тодорхойлон NDVI сансрын зураглал, ургамлын биомасс хайчлах уламжлалт аргуудтай харьцуулахад ижил үр дүн гарсан нь цаашид бэлчээрийн фотомониторингийн хээрийн судалгаанд уг багажийг ашиглах нь ажил хөнгөвчлөх, дата мэдээллийн чанарыг сайжруулах боломжтой болохыг нотолсон.

Хүснэгт 1.
Үндэсний фотомониторингийн цэгүүдэд хийсэн хяналтын үнэлгээ

Ургамлын бүрхэц, %		Ургац, кг/га	
www.egazar.gov.mn	МУИС-ийн багийн судалгаа	www.egazar.gov.mn	МУИС-ийн багийн судалгаа
77.4±2.5	56.4±3.3	1816.7±366.9	1228.6±71.5
p<0.001***		p=0.12	

Зураг 7.
Тосон хулстайн бэлчээрийн фотомониторингийн цэгүүд дэх зүйлийн баялагийн үзүүлэлт



Эх сурвалж: Тосон Хулстай байгалийн нөөц газрын ургамлын аймаг, бэлчээрийн судалгааны тайлан. 2024 он.



“Хамтын хариуцлага — Бэлчээр хамгааллын шинэ тогтолцоо”



А.Баттогтох
Дорнод аймаг,
Хөлөнбуйр
сумын ЗДТГ-ын
Хөдөө аж ахуйн
мэргэжилтэн

Би хөдөө аж ахуйн мэргэжилтнээр ажиллаад нэлээд хэдэн жил болж байна. Сүүлийн жилүүдэд бэлчээрийн байдал нүдэнд илт өөрчлөгдөж байгааг анзаарч эхэлсэн. Уур амьсгалын өөрчлөлт, ган зудын давтамж, ой хээрийн түймэр, малчдын бэлчээр сэлгээ хийхгүй байх, хэт их малын шилжилт хөдөлгөөн, үйлдвэрлэлийн хадлан бэлтгэл гээд олон хүчин зүйл давхацсаар бэлчээрийн ургамлын бүтэц өөрчлөгдөж, доройтох хандлага ажиглагдаж байгаа. Зарим газарт урьд нь ургадаг байсан шимт ургамлууд багасаж, оронд нь тэсвэр муутай, ашиг шим багатай ургамал давамгайлах болсон нь бидэнд бодит дохио өгсөн.

Тиймээс манай Хөлөнбуйр сум 2023 онд “Бэлчээр хариуцлагажуулах журам”-ыг боловсруулсан. Энэ ажилд би өөрөө идэвхтэй оролцсон. Бид бэлчээрийн экологийн даац, улирлын хил заагийг илүү тодорхой болгож, цаасан дээр биш, газрын зураг дээр нарийвчлан тогтоосон. Журмаа багийн Иргэдийн Нийтийн Хурал, сумын ИТХ-аар хэлэлцүүлж, эцэст нь Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамаар баталгаажуулж авсан. Ингэж эрх зүйн үндэслэлтэй болгосноор бидний ажил илүү бат бөх суурьтай болсон гэж боддог.

Одоо суманд маань байгаль хамгаалах 9 нөхөрлөл байгуулагдсан. Малчидтайгаа бэлчээр ашиглах гэрээ байгуулж, хариуцлагатайгаар ашиглах тогтолцоонд шилжээд байна. Өмнө нь “нийтийнх” гэдэг ойлголтоор ханддаг байсан бол одоо “хамтын хариуцлага” гэдэг ойлголт илүү сууж байна. Энэ бол бидний хувьд хамгийн том өөрчлөлт.

Мөн үлийн цагаан оготно ихэссэн бэлчээрүүдэд төр, малчидтайгаа хамтраад шувууны суултуур байршуулсан. Би хувьдаа химийн хор цацахаас илүү байгалийн тэнцвэрт тулгуурласан ийм арга хэмжээг дэмждэг. Эхний үр дүн гарч, оготнын нягтаршил буурч эхэлж байгаа нь бидний итгэлийг улам нэмэгдүүлж байна.

Мөн төслийн хүрээнд ногоон тэжээл тарих, дарш бэлтгэх сургалтууд зохион байгуулагдсан. Анх малчид “манайд ургах болов уу” гэж эргэлзэж байсан. Гэхдээ 2023 оноос манайхан тариалж, дарш хийж, 2024 оны зуднаар зарим малчид маш бага хохиролтой давсан. Би очиж үзэхэд хүмүүс “энэ хавар бэлчээрт эрт гарахгүй, малаа бэлэн тэжээлээрээ тэнхрүүлнэ” гэж ярьж байсан. Тэр үед л хийж байгаа ажил маань утга учиртай санагдсан.

Миний хувьд энэ бүх ажлын үр дүнг харах хамгийн урамтай. Бэлчээр гэдэг бол зүгээр нэг газар нутаг биш, бидний амьдралын суурь. Хэрвээ бид өнөөдөр зөв менежмент хийж чадвал маргаашийн эрсдэлийг бууруулж чадна. Малчид маань ч үүнийг ойлгож, хамтран ажиллаж эхэлсэн нь хамгийн том амжилт.

Цаашдаа илүү олон өрх ногоон тэжээл тарьж, нөхөрлөлийн үйл ажиллагаа бэхжиж, бэлчээрийн доройтол буурна гэдэгт би хувьдаа итгэлтэй байна. Энэ бол зөвхөн нэг мэргэжилтний ажил биш, харин сум даяараа хамтдаа хийж байгаа өөрчлөлт юм.

🔍 БЭЛЧЭЭР НӨХӨН СЭРГЭЭСЭН ҮР ДҮН

- 2022-2025 онд сумын дунд хугацааны газар зохион байгуулалтын төлөвлөгөөн дэх нөхөн сэргээх арга хэмжээг харгалзан зорилтот 8 сумын 25 багийн 1,768,502 га талбайд бэлчээр нөхөн сэргээх, хортон мэрэгчтэй тэмцэх, булаг усны эх хаших зэрэг 9 төрлийн 146 арга хэмжээг тухайн жилийн төлөвлөгөөнд тусган баталсан. Үүнээс 1,435,689 га буюу төлөвлөсөн арга хэмжээний 81% нь хэрэгжсэн нь (улсын дундаж 0.01%) харьцангуй өндөр үзүүлэлт болж нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө хэрэгжиж, бэлчээрийн засаглал сайжирч байна.
- Нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлсэн 1,435,689 га бүхий 68 фотомониторингийн цэгийн **22 цэгийн 835,502 га** төлөөлөх талбайн бэлчээрийн сэргэх чадавхын ангилал сүүлийн дөрвөн жилд 1-2 ангиллаар дээшилсэн бол **27 цэгт буюу 1,881,578 га** (38%) бэлчээрийн төлөв байдал (сэргэх чадавхийн ангилал) тогтвортой байснаараа нийт **19.2 сая** тонн нүүрсхүчлийн хийг шингээж Даян дэлхийн байгаль орчинд эерэг нөлөөлөл авчрахаас гадна Монгол Улсын хүлэмжийн хийг бууруулах үндэсний зорилтын хэрэгжилтийг хангахад хувь нэмэр оруулав.
- Цахим системд суурилсан бэлчээрийн газрын мониторинг нь MRV байх боломжтой юм. Тиймээс Олон улсын ногоон санхүүжилт, карбоны зах зээлээс санхүүжилт авах суурь хэрэгсэл тул цаашид боловсронгуй болгон хөгжүүлэх шаардлагатай.

“Бэлчээрийг зөв зохистой ашиглах, хамгаалах асуудал бол бидний ирээдүйн амин судас”



Ч.Батбаяр
Дорнод аймгийн
Хөлөнбуйр сумын
ЗДТГ-ын Байгаль
орчны хяналтын
улсын байцаагч

Хөлөнбуйр сум нь 3 аймгийн 7 сумтай хил залгадаг, тал хээрийн бүсэд оршдог онцлог нутаг. Нийт 600 гаруй өрхтэй, үүнээс 476 нь малчин, мал бүхий өрх. Тэгэхээр эдийн засгийн гол тулгуур бол яах аргагүй мал аж ахуй. Тийм учраас бэлчээрийг зөв зохистой ашиглах, хамгаалах асуудал нь манай сумын хувьд амин чухал асуудал юм.

Төслийн хүрээнд бид долоон жил хэрэгжүүлэх “Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө”-тэй болж үүндээ бэлчээр хамгаалах, доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх, байгаль орчноо хамгаалах олон арга хэмжээг төлөвлөхөд оролцсон, түүнийхээ хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах үр чадвартай болсон.

Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө зүгээр нэг шүүгээнд хадгалагдах бичиг баримт бус, харин бидний өдөр тутмын ажлын “гарын авлага” болгон ашигладаг болсон. Сумын Газар зохион байгуулалтын ажлын хэсэг төлөвлөгөөндөө тулгуурлаад аль багт ямар хэмжээний бэлчээрийн газрыг өнжөөж амраах вэ, аль хэсгийг ашиглалтаас чөлөөлөх вэ, хаана уст цэг гаргах вэ, хаана хортон мэрэгчидтэй тэмцэх вэ, бэлчээрээ хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглахад чиглэсэн бүх арга хэмжээг жил бүр нарийвчлан төлөвлөдөг болсон.


Хамгийн чухал нь энэ бүхнийг бид багийн Иргэдийн Нийтийн Хурлаар малчдадаа танилцуулж, хамтдаа хэлэлцэж, саналыг нь тусгаж бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг боловсруулдаг болсон. Үүнийгээ сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөндөө оруулаад, ИТХ-аар батлуулж хангах зохион байгуулалтаа хийдэг, бодитоор хэрэгжүүлдэг болсон. Ингэснээр малчдын оролцоо, хяналт эрс сайжирсан. Өөрсдөө оролцож баталсан учраас малчид илүү хариуцлагатай болж, хэрэгжилт ч хөрсөн дээрээ бууж байна.

Сүүлийн 10-аад жилд манай сумын малын тоо тогтмол өсч байсан бол сүүлийн хоёр жилд энэ өсөлт тогтворжиж эхэллээ. 2025 оны жилийн эцсийн тооллогоор 141,000 толгой мал тоологдсон. Энэ бол зүгээр нэг тоо биш, харин малчдын сэтгэлгээ, хандлага өөрчлөгдөж буйн илрэл гэж харж байна. “Тооны араас биш, чанарын төлөө” гэсэн ойлголт бодитоор хэрэгжиж эхэлсний жишээ. Мөн сумын Тосон хулстайн БНГ-т хамаарах хэсгээс хадлан авахыг хориглосон шийдвэр гаргуулсан.

Үүнд төслийн зүгээс зохион байгуулсан сургалт, соён гэгээрүүлэх ажлууд ч маш их нөлөөлсөн. Малчид маань бэлчээрээ хамгаалахгүй бол ирээдүй байхгүй гэдгийг илүү сайн ойлгож, хамтын зохион байгуулалттай бэлчээр өнжүүлэх, хамгаалах арга хэмжээнд идэвхи, санаачилгатай оролцдог болсон. Энэ бол бидний хувьд хамгийн том үр дүн, бодит амжилт юм.

НҮҮДЛИЙН ЗҮЙЛИЙН ЧУХАЛ АМЬДРАХ ОРЧИН, ХОЛБООС НУТАГ, ӨВӨРМӨЦ ЭКОСИСТЕМИЙГ ГАЗРЫН НЭГДМЭЛ ТҮВШИНД ХАМГААЛЖ БАЙНА

- Цагаан зээрийн холбоос нутгийн судалгааны үр дүнд үндэслэн бэлчээр өнжөөх төлөвлөгөөг гаргасан. Үүний дүнд 2022-2025 онуудад зорилтот сумдын нутаг дэвсгэрт бэлчээр хамгаалах, өнжүүлж сэлгэх арга хэмжээг хэрэгжүүлэв.



- Газрын сан нэгдмэл байх зарчмын дагуу байгалийн нөөц газрын менежментийн төлөвлөгөө болон хамгааллын горим, дэглэмийг харгалзан сумын НДХТ-нд тусгасан БНГ-т хамаарч буй бэлчээр сайжруулах арга хэмжээг тухайн жилийн ГЗБТ-өөр дамжуулан хэрэгжүүлж байна. Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын 2023-2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Баянцагааны тал БНГ-т доройтсон бэлчээрийг сэлгэн ашиглах, өнжүүлэх арга хэмжээг тусган хэрэгжүүлсэн. 2025 онд Баянцагааны тал БНГ-т хамаарах Сүхбаатар суманд 149,963 га, Мөнххаан суманд 56,000 га бэлчээрийг сэлгэн ашиглах арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг хангаж ажилласан.

Зураг 8.
Мөнххаан,
Сүхбаатар сумын
2023-2025 оны ГЗБТ-
ний хэрэгжилт

БЭЛЧЭЭР НӨХӨН СЭРГЭЭХ, ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ
Баянцагааны тал БНГ




- Сүхбаатар суманд 149,963 га
- Мөнххаан суманд 56,000 га

Аймаг	Сум	Төлөвлөсөн арга хэмжээ	2022	2023	2024	2025	Нийт
Сүхбаатар	Мөнххаан	Ойжуулалт, нөхөн сэргээлт, мод тарих				13	13
		Өнжөөж амраах бэлчээр			23	98267	98279
Сүхбаатар	Сүхбаатар	Сэтгэж ашиглах бэлчээр			133767	223590	357358
		Тордон сайжруулах бэлчээр			128950		128950
		Усны эх булаг, эрэг орчмын газрыг хашиж хамгаалах			54	0	54
		Хөв цөөрөм байгуулж ашиглалтыг нэмэгдүүлэх бэлчээрийн газрын төлөвлөлт				10	10
		Ойжуулалт, нөхөн сэргээлт, мод тарих		198		198	198
		Өнжөөж амраах бэлчээр		21606			21606
		Сэтгэж ашиглах бэлчээр		17288	271958		289246
		Нийт		39092	534752	661352	1235196

Эх сурвалж: Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем

Зураг 9.
Норовлин сумын
2023-2025 оны
ГЗБТ-нд бэлчээр
чөлөөлөхөөр
батлагдаж, www.
egazar.gov.mn
газрын нэгдсэн
санд бүртгэгдсэн
бэлчээрийн
байршил.



Зураг 10.
Улз голын эх БНГ-т
бэлчээр өнжүүлсэн
арга хэмжээний
хэрэгжилт

2023 оны Норовлин сумын ГЗБТ-нд Улзын эх БНГ-ын орчмын 17,230 га, 2024 онд 6,921 га, 2025 онд 6,138 га бэлчээрийг тус тус давтан өнжөөх арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн нь хүлэрт намгийн хамгааллыг сайжруулахад хувь нэмэр оруулсан.

Норовлин сумын 2023 ГЗБТ-ний хэрэгжилтийн нотолгоо:
1. Онон баг Улзын эх 17,230 га бэлчээрийг,
2. Ангирт баг 11,806 га бэлчээрийг өнжөөх ИТХ-ын тогтоол, ЗД-ын захирамж

№	Төлөвлөгөөний агуулга	Газрын нэгдсэн сангийн үйлчилгээний газрын талбай	Газрын талбай	Газрын талбай	Газрын талбай	Газрын талбай	Газрын талбай
1	1183 Сүм дунд-ойрын бэлчээр	3-р баг, Онон	17233553	17233553	17233553	17233553	17233553
2	1183 Сүм дунд-ойрын бэлчээр	2-р баг, Ангирт	11806789	11806789	11806789	11806789	11806789

2023.06.06-2023.09.20-ны хооронд 2.5 сарын хугацаанд төлөвлөсөн бэлчээрээ чөлөөлсөн.

Хэрлэн голын татмын ой малын хөл, сүүлийн жилүүдэд болсон үерийн улмаас доройтож сэргэн ургах чадавхи муудсан байгааг ойн мэргэжлийн байгууллага болон байгаль орчны газруудтай хамтран тогтоосон.

Тиймээс байгалийн сэргэн ургах чадавхыг дэмжих зорилгоор Хэнтий аймгийн Баян-Овоо, Дорнод аймгийн Булган сумдад тус бүр нэг га татам хашаалсан. Хашаалсан татамд бэлчээрийн ургамал болон бургасны хожуул 1.5-2 м хүртэл өндөр болж сэргэн ургасан. Энэ нь татмын ой, бэлчээрийн сэргэн ургах чадавх маш сайн боловч оновчтой менежмент байхгүй байгаа нь доройтлын үндсэн шалтгаан гэдгийг нотолж байна. Энэ туршлагад үндэслэн 2025 онд Дорнод аймгийн Булган суманд Хэрлэн голын татамд 17 га газар хашиж хамгаалсан.

Зураг 11.
Татмын ой,
бэлчээрийн сэргэх
чадавх, Дорнод
аймгийн Булган сум.



Мөн ойн мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар Хэрлэн голын дагуу татмын ойг эрүүл болгох, ойн нөхөн сэргэх, хэвийн өсөх чадавхыг дэмжих зорилгоор 230 га талбайд арчилгаа, цэвэрлэгээ хийх ажлыг зохион байгуулав.

“Миний ногоон мөрөөдөл”



Д.Сэргэлэнбаатар
Дорнод аймгийн
Булган сумын
иргэн, “Хэрлэн
голын алим”
төслийн
санаачлагч

Би нийгмийн ажилтан, төрийн захиргаа удирдлагын менежер мэргэжилтэй. Одоогоор Дорнод аймаг дахь Политехник коллежид Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүлхуйнахлахажилтнаараажиллаж байна. Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарт 13 дахь жилдээ тасралтгүй ажиллаж, олон залуучуудад мэргэжлийн ур чадвар эзэмшихэд хувь нэмрээ оруулж байгаадаа баяртай явдаг.

Гэхдээ миний амьдрал зөвхөн ажлын өрөөнд өнгөрдөггүй. Байгаль орчин, мод ургамал, жимсний аж ахуйд дурлах сонирхол маань намайг өөр нэгэн зам руу хөтөлсөн. Энэ бол жимсний мод тарьж нутагшуулан, ирээдүй хойч үедээ ногоон өв үлдээх хүсэл мөрөөдөл юм.

2017 оноос эхлэн өөрийн сонирхлоор өрхийн хэмжээнд 1100 м² газартаа жимсний мод тарьж эхэлсэн. Анх туршилт, судалгааны байдлаар цөөн хэдэн мод тарьж байсан бол удалгүй энэ ажил маань илүү том зорилготой болж эхэлсэн. Би ОХУ-ын Буриад улсын Селенгинскийн “Бурятия Селенгинский” компанийн мод үржүүлгийн талбайгаас жимсний модны суулгац авчирч, Дорнод аймагт нутагшуулах ажлыг эхлүүлсэн.

Ингэж торниун алимны 3 сорт, бэсрэг алимны 6 сорт, давжаа алимны 3 сорт, чавганы 4 сорт, тоорын 2 сорт зэрэг нийт 300 гаруй эх модыг тарьж ургуулсан юм.

Миний тарьсан моднууд 2022 оноос эхлэн үр жимсээ өгч эхэлсэн нь надад асар их урам зориг өгсөн. Одоогоор жилдээ 300–500 кг орчим жимс хураан авч байна. Үүнээс илүү чухал нь манай нутагт аль сортын жимсний мод илүү сайн нутагшиж, ургац өгч байгааг судлан тогтоох боломж бүрдсэн явдал юм.

Монгол Улс тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах зэрэг томоохон бодлогыг хэрэгжүүлж эхэлсэнтэй зэрэгцэн би өөрийн хийж байсан ажлаа илүү өргөжүүлэхээр шийдсэн. Ингэж 2022 оноос “Хэрлэн голын алим - 5000” төслийг санаачлан хэрэгжүүлж эхэлсэн.

Энэхүү төслийн хүрээнд Дорнод аймгийн Булган суманд жимсний мод тарих, үржүүлэх зориулалтаар 10 га газрыг батлуулж, эхний ээлжинд 3 га талбайд эх цэцэрлэг болон агро-ойн аж ахуйн суурийг тавьсан. Тус талбайд хамгаалалтын зурвас мод тарьж, жимсний модны эх цэцэрлэг байгуулан тарьц суулгац үржүүлэх ажлыг эхлүүлсэн.

2022 онд ойн зурвас хамгаалалтаар улиангар, бургас, буйлс зэрэг мод тарьж, мөн алим, чавганы эх моддыг суулгасан. 2023 онд “Мод тарих үндэсний өдөр”-үүдээр хамгаалалтын зурвасыг өргөтгөж, алим, чавганы олон сортын модоор эх цэцэрлэгээ баяжуулсан. Харин 2024 онд гүйлс, буйлс, монос, бургас, улиас зэрэг моддыг үр болон тайрдасаар үржүүлж нийт 25 мянга орчим мод тарьсан бөгөөд ургалтын хувь 80-аас дээш байсан. 2025 онд бойжуулалтын талбайд буйлс, улиасны 10 мянган тарьц суулгацыг шилжүүлэн тарьсан.

Мөн Дорнод хээрийн төслийн дэмжлэгтэйгээр тарьц суулгац бойжуулах хүлэмж, усалгааны систем, ус нөөцлөх байгууламж, сэргээгдэх эрчим хүчний шийдлийг ашиглалтад оруулсан нь мод үржүүлгийн ажлыг илүү тогтвортой, үр ашигтай явуулах боломжийг бүрдүүлсэн. Тухайлбал, дуслын усалгааны систем болон гүний худгийг 10 кВт хүчин чадалтай нарны эрчим хүчээр хангах шийдлийг нэвтрүүлснээр тарьсан мод, бут сөөгийг тогтвортой усалгаатай байлгах нөхцөл бүрдсэн.

“Хэрлэн голын алим – 5000” төслийн гол зорилго нь 2030 он гэхэд 5000 гаруй алим, чавганы мод бүхий агро-ойн аж ахуйг бий болгож, дагалдах хамгаалалтын 40–45 мянган мод бүхий ой төгөл байгуулах явдал юм. Мөн жимсний модны тарьц суулгацын үржүүлгийн талбай бий болгож, мэргэжлийн боловсролын байгууллагын оюутан, суралцагчдад дадлага хийх орчин бүрдүүлэх, иргэдийг нутагшсан сортын жимсний модоор хангах, орон нутгийн зах зээлд эко жимс нийлүүлэх зорилготой.

Миний санаачилсан энэхүү төсөл олон улсын болон улсын хэмжээний уралдаан, хөтөлбөрүүдэд амжилттай оролцож, хэд хэдэн удаа шилдэгт шалгарсан нь надад улам их урам өгсөн. Тухайлбал:

- 2020 онд Дорнод аймгийн залуучуудын **START-UP** хөтөлбөрт шалгарч 10 сая төгрөгийн дэмжлэг авсан.
- 2021 онд улсын **START-UP аварга шалгаруулах тэмцээнд** тэргүүн байр эзэлж 15 сая төгрөгийн санхүүжилт хүртсэн.
- 2022 онд “**Шинэ сэргэлт: NEXTGEN**” төслийн уралдаанд шилдэг төслөөр шалгарч 20 сая төгрөгийн санхүүжилт авсан.
- 2023 онд боловсролын салбарын **MON-X инновацийн уралдаанд** улсын шилдэг 40 санаачилгын нэг болж, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын **Agripreneurship Challenge** тэмцээний финалд шалгарч ХХАА салбарын шилдэг 15 төслийн нэг болсон. Миний хувьд “Хэрлэн голын алим” төсөл бол зөвхөн жимсний мод тарих ажил биш. Энэ бол нутаг орныхоо байгаль орчныг хамгаалах, иргэдийг эрүүл хүнсээр хангах, ирээдүй хойч үедээ ногоон өв үлдээх гэсэн миний мөрөөдөл юм. Хэрвээ олон хүн өөрийн нутагтаа мод тарьж, байгаль дэлхийгээ хайрлаж эхэлбэл Монгол орон маань улам ногоон, улам сайхан болно гэдэгт би итгэдэг.

- Татмын ойн үнэ цэнийг сурталчлан таниулах, татмын бургасыг цэвэрлэх замаар сэргэн ургалтыг дэмжих арга хэмжээ, өдөрлөг зохион байгуулах, хүүхдүүдээр дамжуулан хамгааллын арга хэмжээг сайжруулахын зорилгоор сумдын эко бүлгийн багш нар зориулсан татмын ойн сургалтын гарын авлагын дагуу багш нар 2024-2025 онд 240 хүүхдэд танхимын болон хээрийн аялал сургалтад хамруулсан.
- Хэнтий аймгийн Норовлин сумын ойн менежментийн төлөвлөгөөг талуудын оролцоотойгоор шинэчлэн боловсруулахад дэмжлэг үзүүлсэн. Энэ төлөвлөгөө нь уур амьсгалын өөрчлөлт, ойн зам, зэрлэг амьтны байршил, орон нутгийн хөгжлийн бусад төлөвлөгөөнүүдийг харгалзахын зэрэгцээ анх удаа Тусгай хамгаалалттай газар нутгийн ойн менежментийг нэгтгэн тусгаснаараа онцлог болсон. Төлөвлөгөөг Хэнтий аймгийн ИТХ-аар хэлэлцэн Засаг дарга баталсан. Төлөвлөгөө боловсруулах явцад сумын ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах аргыг шинэчлэн боловсруулж Ойн газарт санал хүргүүлсэн.
- Мөн ой, хээрийн түймэртэй тэмцэх орон нутгийн болон Зүүн бүсийн тусгай хамгаалалттай газрууд, Байгаль орчны газруудын хүний нөөцийн болон техник, тоног төхөөрөмжийн чадавхыг бэхжүүлэхэд 100 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн нь ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулав.

🔍 ҮР ДҮН

- Бэлчээрийн менежментийн арга хэмжээ нь сумын тухайн жилийн ГЗБТ-нд тусгагдан оролцогч талуудын чармайлт, хамтын ажиллагааны үр дүнд өвөрмөц экосистем болох хүлэрт намаг, цэн тогорууны амьдрах орчныг хамгаалахад бодит ахиц гарсан.
- Хэрлэн голын татмын бэлчээр, татмын бургасан шугуй бүхий өвөрмөц экосистемийг хамгаалах, нөхөн сэргээхэд чиглэсэн цогц арга хэмжээ нь нийт 20,000 га татмын болон төгөл ойг менежменттэй болгох, 200 га татмын ойг бодитоор нөхөн сэргээх төслийн дэд зорилтын хэрэгжилтийг хангахаас гадна Тэрбум модны үндэсний хөдөлгөөнийг Зүүн бүст хэрэгжүүлэхэд бодит хувь нэмэр оруулав.

МАЛ СҮРГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТИЙГ ТҮРГЭТГЭХ, АШИГ ШИМИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ, ӨРТГИЙН СҮЛЖЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ

НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН АСУУДАЛ



- Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн төслийн зорилтот сумдын малчин өрхийн орлогын гол эх үүсвэр нь ноолуур болон мал борлуулалтаас хамаарч байна. Ноолуур бэлтгэл, мах үйлдвэрлэл нь улирлын чанартай тул малчин өрхүүд бэлэн мөнгөний хомсдлоо малчны зээлээр нөхөхийн тулд олон тооны эр, сувай малыг эдийн засгийн эргэлтэнд оруулалгүй зээлийн барьцаа болгон бэлчээрт хадгалах хандлагатай байдаг. Мөн усны эх үүсвэр бараадах, зам харгуй, зах зээл, хүүхдийн сургууль болон нийгмийн бусад үйлчилгээг авахад ойр газруудад малчид олноороо нутаглаж, ургамал сэргэн ургах хугацаа олгохгүй даац хэтрүүлэн бэлчээр ашиглах нь түгээмэл байна.
- Малын тоо толгойн өсөлтийг даацад тохируулах, бэлчээрийн менежментийн цогц арга хэмжээг бодитоор хэрэгжүүлэхийн тулд сүргийн чанарыг сайжруулж, эдийн засгийн эргэлтийн хурдасгаж, сүү, мах, ноолуур, ноосны өртгийн сүлжээний доголдлыг арилгах боломжит хувилбаруудыг хөгжүүлэх замаар малчдын орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, төрөлжүүлэхэд чиглэн ажиллав.

ХУВИЙН МАЛ ҮРЖЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИН МАЛ СҮРГИЙН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАВ



- Мал үржлийн үйлчилгээг эрхлэх ажахуйн нэгжийн боловсон хүчнийг чадавхжуулах, гарааны бизнесийн хөгжлийг дэмжих, материаллаг баазыг бэхжүүлэх, малчдын сүрэгт чанартай хээлтүүлэгчээр түрээсийн үйлчилгээ үзүүлэх бизнесийн харилцааг дэмжих замаар хуулийн хэрэгжилтийг хангуулах боломж, шийдлийг танилцуулав.
- Малын үржүүлгийн үйлчилгээ, аж ахуйн үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөний загвар боловсруулж, сумын Засаг дарга, аймгийн ХХААГ-тай төслийн 6 сумын "Малын үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж" (МҮТАҮН) гурвалсан гэрээ байгуулснаар Малын генетик нөөцийн хуулинд ерөнхийлөн заасан харилцааг орон нутагт нарийвчлан зохион байгуулах, хянах боломж бүрдсэн.
- Монгол Улсын Малын үржлийн стратеги төлөвлөгөө, Зүүн бүсэд ашиглах сайжруулагчийн тухай зөвлөмжийн дагуу зорилтот зургаан сумын МҮТАҮН-д Барга, Үзэмчин үүлдрийн хонь, Баяндэлгэрийн улаан үүлдрийн ямааны нийт 600 толгой шилмэл хээлтүүлэгч, мал ангилалтын хашаа, багаж хэрэгслийг нийлүүлж сургалт, зөвлөн туслах үйл ажиллагаагаар дамжуулан чадавх бэхжүүлэв.
- Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Дорнод Монголын мухар улаан үүлдрийн цөм сүргийн аж ахуйд шилмэл 5 бух нийлүүлсэн.
- Төслөөс хэрэгжүүлсэн малын үржүүлэг, селекцийн чиглэлээр хийсэн ажилд хөндлөнгийн үнэлгээ 2024 онд хийсэн бөгөөд тайланд

Баян-Адарга, Баян-Овоо, Түмэнцогт, Мөнххаан сумын МҮТАҮН нь хангалттай материаллаг нөөц, чадварлаг боловсон хүчин, зах зээл болон хэрэглэгчийн сүлжээг бүрдүүлсэн гэж үнэлсэн байна.

Зураг 12.
Төслөөс нийлүүлсэн
шилмэл хээлтүүлэгч



- 2022–2023 онд 5 сумын 90 гаруй малчин өрхийн 600 үнээнд Алатау, Симменталь зэрэг мах-сүүний хосолмол үүдрээр зохиомол хээлтүүлэг хийж, хээл авалт 80%, F1 тугалын бойжилт 60%-д хүрч үхрийн генетик чадавхыг сайжруулав. Энэхүү үйл ажиллагаа нь сүү ба махны өртгийн сүлжээтэй нягт уялдаатай ажил юм
- Шилмэл хээлтүүлэгчийг нийлүүлгийн улиралд МҮТАҮН-ээс малчид түрээсээр авч ашиглах бизнесийн шинэ харилцаа дээрх сумдад бий болсноор шинжлэх ухааны үндэслэлтэйгээр, мэргэжлийн үйлчилгээ авч сум, орон нутгийн түвшинд малын ашиг шимийн гарц ба чанарыг сайжруулах, улмаар Малын генетик нөөцийн хуулийн хэрэгжилтийг хангах загвар бий болов. Малчид дур мэдэн хээлтүүлэгчээ сонгож сүргийн ашиг шимийн гарц, чанарыг бууруулдаг байдлыг өөрчилж зах зээлийн эрэлт хэрэгцээ, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох малын ашиг шимийн эдийн засгийн гол үзүүлэлтүүдээр МҮТАҮН-үүд шилэлт хийж, шилмэл-эрүүл-хангалттай тоо толгой хээлтүүлэгчийг бойжуулан, баг-сумын малчдын малын ашиг шимийн гарц, чанарыг хяналтад байлгах нөхцөл бүрдэв.

“Туршиж үзээд итгэл төрсөн”



Т.Даваахүү
Баян-Адарга
сумын малчин,
малын Их эмч

Би малын Их эмч мэргэжилтэй хүн л дээ, гэхдээ малчин байхыг илүүд үзээд сумандаа мал маллаж байна. Сүүлийн жилүүдэд махны чиглэлийн үүлдэр, тэр дундаа суффолк хонь манай орны нөхцөлд хэр тохирох вэ гэдгийг сонирхож, бодитоор туршиж үзэхийг зорьсон. Энэ хүрээнд Дорнод хээрийн төслийн дэмжлэгтэйгээр 2024 оны намар нутгийн 200 толгой эм хонинд суффолк хуцны зохиомол хээлтүүлэг хийлгэсэн.

Юуны өмнө, зохиомол хээлтүүлгийн үйл ажиллагаа өөрөө маш үр дүнтэй, малд хүндрэл багатай байсныг онцолмоор байна. Хээлтүүлэг хийлгэсэн эм хонинууд төллөхдөө монгол хонины хурга шигээ хүндрэлгүй, жигд сайхан төллөсөн. “Гадаад үүлдэр учраас том толгойтой, хүндрэлтэй гарна” гэсэн болгоомжлол байсан, гэхдээ бодит байдал дээр тийм асуудал огт гараагүй.

Хурга гарснаас хойших торнилт нь хамгийн их анхаарал татсан. Монгол хургыг бодвол өсөлт илүү хурдан, махан тарга сайн авч байна. Сүүл нь гожгор тул өөх нь сүүлэндээ бус, дал, сэрвээ, гуя хэсгээр жигд сайхан тарж байгааг нүдээрээ харж, гараараа тэмтрэн мэдэрч байна. Энэ нь зах зээлд махны чанар, гулуузны гарцын хувьд их давуу тал гэж боддог.

Би хургаа бойжуулахдаа тэжээл, маллагаанд онцгой анхаарсан. Хаврын улиралд хургандаа төслөөс өгсөн зориулалтын гүзээ хөгжүүлэх хорголжин тэжээл өгсөн. Мөн хавар, намартаа хониндоо гадна, дотно паразитаас сэргийлэх зорилгоор ивормектиний туулгалтыг тогтмол хийж хэвшсэн. Хээлтэй эм хонинд хавар селен тарьж байгаа. Учир нь эм хонь ураг тээж байхдаа эрдэс бодисын дутагдалд амархан ордог. Үүнээс шалтгаалж сүү орохгүй удах, хурга давжаа гарах, амьдрах чадвар сул байх эрсдэл нэмэгддэг. Харин селен тарьснаар ийм сөрөг нөлөө багасаж, хурганы өсөлт, биеийн тамир илт ялгаатай болдгийг ажигласан.

2025 оны 10-р сард эрлийз хургануудын гулуузны жинг үзэхэд дунджаар 19–22 кг хүрч байсан. Энэ бол манай нутгийн нөхцөлд хаврынуулиралд нэмэлт тэжээлээр тэжээгээд, зун, намартаа уламжлалт аргаар маллаад зах зээлд шууд нийлүүлэх боломжтой, эдийн засгийн хувьд ашигтай хаана ч байхгүй үзүүлэлт гэж би хувьдаа дүгнэж байна. Тиймээс суффолк хуцны зохиомол хээлтүүлгийг дэмжсэн танай төслийн хамт олонд чин сэтгэлээсээ талархаж байна. Энэ бол малчны хувьд туршиж үзээд итгэл төрсөн, цаашид өргөжүүлэх бүрэн боломжтой ажил гэж бодож байна.

СҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, НЭМҮҮ ӨРТГИЙН СҮЛЖЭЭГ БОДИТООР ДЭМЖИВ

- Уламжлалт мал аж ахуйд суурилсан улирлын чанартай, өрхийн түвшний сүү үйлдвэрлэлээс Зүүн бүсэд жилийн туршид тогтвортой сүү үйлдвэрлэл эрхлэхэд чиглэсэн цогц үйл ажиллагааг төслийн хүрээнд хэрэгжүүлэв.

СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТГИЙН СҮЛЖЭЭ (УЛАМЖЛАЛТ МАЛЧНААС ШИНЭ ФЕРМЕР)



- Боловсон хүчнийг бэлтгэх:** УБ хотын Аргүнт, Партизан тосгоны фермерүүдтэй хамтран 65 малчныг 5 хоногийн дадлага сургалтад хамруулж, 16 малчин сүүний аж ахуйд шилжин сумын төвд байршин тогтвортой орлоготой болсон. Энэ нь бэлчээрийн дарамтыг бууруулж, уламжлалт мал аж ахуйгаас хагас эрчимжсэн сүү үйлдвэрлэл рүү шилжих жишиг болсон.
- Тэжээх аргыг сайжруулах:** Хөлөнбуйр, Мөнххаан, Түмэнцогт, Сүхбаатар сумдын 6 айлтай хамтран хаврын тэжээлд уураг, энерги, эрдсийн нэмэлттэй туршилт хийж, 45 хоногийн дотор сүүний гарц 2.8 дахин, орлого 2.7 дахин өссөн. Үүний үр дүнд 9 сумын 232 малчинд сүүний үхрийн аж ахуйн технологи, тэжээл үйлдвэрлэл, тэжээллэгийн сургалт зохион байгуулж, малын тоог өсгөх биш, авах ашиг шимийг нэмэгдүүлэх замаар орлогоо өсгөх хандлага бий болсон. Жишээлбэл, Сүхбаатар сумын малчин Ц.Сүхболд 700 гаруй толгой малаа цөөлж, 10 үнээтэй сүүний аж ахуй байгуулан орлогоо 2.3 дахин нэмэгдүүлж, 2024 оны хүнд өвлийг нэг ч малын гарзгүйн зэрэгцээ өдөр тутмын орлоготой давсан байна.
- Сүүний үйлдвэрлэлийг тогтвортой байлгахад тэжээл үйлдвэрлэл маш чухал бөгөөд ‘Малчдын байгууллагын тэжээл үйлдвэрлэл’, ‘Захиалгат тариалан’ загварыг шинээр хөгжүүлсэн.
- Дундын зуучлалын үе шатанд:** Дорнод аймгийн Булган сум нь аймгийн төв Хэрлэн суманд ойрхон бөгөөд малчид сүү цагаан идээгээ аймгийн төвийн зах зээлд борлуулах боломжийг үндэслэн төсөл Булган суманд 1 тонн сүүний хөргөлтийн төв байгуулснаар

малчид өдөр бүр сүүгээ аймгийн төвийн сүү боловсруулах үйлдвэрт нийлүүлж орлогоо нэмэгдүүлэх боломжтой болсон. Сүхбаатар аймгийн Сүхбаатар сум, Хэнтий аймгийн Норовлин, Баян-Адарга сумдад сүүний цехийг хоршооны зохион байгуулалтанд оруулж, хоршооны зарим гишүүд сүүгээ нийлүүлж, борлуулалтаас ашиг хүртэх загварыг бий болгосон. Өөрөөр хэлбэл сүү үйлдвэрлэгч ба боловсруулагч нь дундын зуучлалгүйгээр шууд холбогдон хамтран ажилласнаар зардал буурч үр ашиг нь нэмэгдэх нөхцөл бүрдэв.

- Боловсруулалтын үе шатанд:** Төслийн зорилтот 3 сум буюу Хэнтий аймгийн Баян-Адарга, Норовлин, Сүхбаатар аймгийн Сүхбаатар суманд тус бүр өдөрт 1000 литр сүү боловсруулах хүчин чадалтай жижиг үйлдвэр байгуулж, үйлдвэр тус бүр нь жилдээ 130–150 сая төгрөгийн орлого олох боломж бүрдсэн. Сүү боловсруулах үйлдвэрийн эрүүл ахуйн нөхцлийг сайжруулан бохирын системийг стандартын шаардлагад нийцүүлж, ажилтнуудыг шаталсан сургалтад хамруулснаар тэд сумандаа 7–8 төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи эзэмшсэн.
- Төслөөс 3 үйлдвэрт 458 сая төгрөгний тоног төхөөрөмжийг нийлүүлсэн бөгөөд газар, сүү боловсруулах үйлдвэрийн барилга, дэд бүтцийг хоршооноос тус 140-145 сая төгрөг, нийт 425 сая төгрөг зарцуулж байгуулсан байна.

Зураг 13.

Тоног төхөөрөмжийн угсралт, үйлдвэрийн барилга



- Баян-Адарга, Норовлин, Сүхбаатар суманд нийт 9 тн багтаамжтай сүүний хөргүүрийн дэмжлэг үзүүлсэн.
- ‘Шимт тараг’, ‘Шимт цөцгий’ нэртэй орон нутгийн брэндийг хөгжүүлж, сав баглаа боодлыг сайжруулснаар 3 сумын сүүний цехүүд нийтдээ 600-д сая төгрөгийн нэрийн савлагаатай бүтээгдэхүүн борлуулах боломжтой болж, эрэлт эрс нэмэгдсэн. Сумдын ЗДТГ-тай хамтран сургуулийн “Үдийн цай” хөтөлбөр, цэцэрлэг, эмнэлгийн хэрэгцээнд нийлүүлэхээр тохиролцсон. Сүхбаатар суманд тараг савлах, ааруул хатаах, мөхөөлдөс үйлдвэрлэх төхөөрөмж суурилуулснаар хүн амын сүү, цагаан идээний хэрэгцээг эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүнээр хангах нөхцөл бүрдсэн.

Зураг 14.

Сүүн бүтээгдэхүүний савлагаа



“Малын тоо толгойг өсгөхөөс илүүтэй, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх нь илүү өгөөжтэй юм байна.”



С.Энхбаатар
Дорнод аймаг,
Хөлөнбуйр сумын
фермер

Би 2008 онд Хэнтий аймгийн Дадал сумаас саалийн үнээ авчирч, фермийн аж ахуйгаа анх эхлүүлж байлаа. Тэр үед зориг, итгэл хоёр дээрээ тулгуурласан эхлэл байсан даа. Гараа хоосон биш ч гэлээ системтэй мэдлэг, тэжээлийн нарийн технологи дутмаг, ихэнхдээ өөрийн туршлага, бусдаас сонссон зөвлөгөөн дээр л явдаг байв.

Одоо бол Хөлөнбуйр сумандаа Симментал үүлдрийн 17–18 үнээ тогтмол сааж байна. Мөн тугалаагүй 7–8 үнээ бий. Энэ хугацаанд нэг зүйлийг маш сайн ойлгосон. “Малын тоо толгойг хэт өсгөхөөс илүүтэй, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх нь илүү өгөөжтэй” юм байна. Өөрөөр хэлбэл “тооноос чанарт шилжих” нь л жинхэнэ

ашиг авчирдаг.

Сүүлийн жилүүдэд хэрэгжсэн төслийн дэмжлэг миний аж ахуйд маш их нөлөө үзүүлсэн. Ялангуяа нэмэлт тэжээлийн талаар өгсөн зөвлөмж, бодит дэмжлэг их өөрчлөлт авчирсан. Өмнө нь өвлийн улиралд зөвхөн өвс, хивэг л өгдөг байхад хоногт дунджаар 3-4 литр орчим сүү авдаг байсан. Харин төслийн хүрээнд “Мимо”, “Шоколадан бор”, няцалсан будаа зэрэг нэмэлт тэжээлийг хэрэглэж эхэлснээр өвлийн саамны гарц 9-10 литрт хүрч тогтворжсон. Энэ бол надад маш том ахиц.

Зуны улиралд хоногт 20 литрт хүрэх үе ч бий, дунджаар 12-15 литр саадаг. Харин өвөл саалийн гарц нэмэгдсэнээр орлого ч бодитоор өссөн. Одоо өвлийн улиралд сардаа 4 сая орчим төгрөгийн орлоготой ажиллаж байна. Өмнө нь өвөл бол зардал ихтэй, орлого багатай үе байсан бол одоо тогтвортой орлоготой улирал болж өөрчлөгдсөн. Үүнийг би төслийн зөв чиглэл, зөв тэжээлийн бодлоготой шууд холбоотой гэж хардаг.

Зөвхөн гарц нэмэгдээд зогсохгүй сүүний чанар эрс сайжирсан. Сүүгээ халаахад л дээр нь цөцгийн тос нь ялгараад, өтгөн, тослог нь мэдэгдэхүйц нэмэгдсэн нь илт харагддаг. Худалдан авагчид ч чанарын ялгааг анзаарч, үнэлж эхэлсэн.

Мөн тугалууддаа нэмэлт тэжээл өгч байна. Зүгээр өвс, хивэг идсэн тугал болон нэмэлт тэжээлээр тордуулсан тугалын өсөлт, жин нэмэлт үнэхээр тэнгэр газар шиг ялгаатай. Ирээдүйн саалийн үнээний суурь эндээс тавигддаг учраас би энэ хэсэгт их анхаарч байгаа.

Одоо цаашдаа “Шоколадан бор”-оос гадна эрдэнэшишийн болон ногоон тэжээлийн дарш түлхүү ашиглахаар судалж байна. Илүү шинжлэх ухаанч, тооцоотой хандаж эхэлсэн маань өөрөө энэ төслийн нөлөө. Өмнө нь зүгээр л мал маллаж байсан бол одоо би аж ахуйгаа бизнесийн зарчмаар, ашиг шимд суурилж хөгжүүлэх тухай боддог болсон.

Энэ өөрчлөлт, энэ өсөлт миний хувьд маш том амжилт. Тууштай хөдөлмөр чухал ч зөв дэмжлэг, зөв мэдлэг нэмэгдсэнээр үр дүн хэд дахин өсдгийг өөрийн биеэр мэдэрч байна.

МАХНЫ НЭМҮҮ ӨРТГИЙН СҮЛЖЭЭНИЙ ХӨГЖИЛ

Монгол Улс жилдээ 13–15 сая толгой мал нядалж, дотоодын махны хэрэгцээгээ бүрэн хангадаг ч экспортын бүтэц нь тогтворгүй, ихэвчлэн адуу, хонины мах экспортолдог зэрэг махны салбарын судалгаанд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр зорилтот сумдад малын эдийн засгийн эргэлтийг түргэтгэх махны нэмүү өртгийн сүлжээг дэмжсэн төслийн оролцоо, үйл ажиллагааг төлөвлөсөн.

ХУРГАНЫ МАХ ҮЙЛДВЭРЛЭЛ

- ▶ Төслийн зорилтот сумдын нийт малын 50%-ийг хонь эзэлдэг. Хургыг 7–8 сартайд борлуулахад малчдын орлого буурахгүйгээр хонин сүргийн тоог 23%-иар, бэлчээрийн ачааллыг 10%-иар бууруулах боломжтой.
- ▶ 3 сумын 12 малчны 1800 хургыг нэмэлт уураг, эрдсээр баяжуулсан тэжээлээр 1.5–2 сар тэжээж, битүү аргаар хөнгөлж, намар 10-р сард дундаж жин нь 39–43 кг болж, хяналтын хурганаас 5–10 кг-аар илүү гарсан. Гулуузны жин 16-19 кг хүрч экспортын шаардлагад нийцсэн.
- ▶ Нутгийн 600 эм хонийг Суффолк үүлдрийн хуцаар хээлтүүлж, гарсан эрлийз F1 хургыг 10-р сард нядлахад гулуузны жин 19–22 кг хүрсэн, экспортын шаардлагад нийцсэн.
- ▶ Нутгийн монгол хургыг бойжуулах аргаа сайжруулах, мөн хэрэгцээний эрлийзжүүлэг хэрэглэх замаар хурганы мах үйлдвэрлэлд тавих жингийн шаардлагыг хангах боломжтой байна.
- ▶ Хонины махны зэх зээлийн холболтыг сайжруулах нэмүү өртгийн сүлжээний түншлэлийн уулзалтуудыг зохион байгуулснаар 2023 онд 312 хурга, 2024 онд 7000, 2025 онд 6000 гаруй хургыг үйлдвэрт нийлүүлж, экспортод гаргасан. Малчид туршлагаа хуваалцаж, бүх хургаа 36 кг-аас дээш жинд хүргэх, бойжуулсан хурганаас хамгийн шилдэг 30% охин хурга (цөөн тооны төлөг болгож хүнсэнд хэрэглэх эр хурга) авч үлдэж сүргээ сэлбэх, 70%-ийг зах зээлд борлуулах аргачлалыг түгээн дэлгэрүүлж байна.

Зураг 15.
Хурганы мах үйлдвэрлэлийн үе шат

ХУРГАНЫ МАХНЫ ҮНЭ ЦЭНИЙН СҮЛЖЭЭ

Шилдэг хээлтүүлэгч ашиглах (600 бог)	Хонио эрт, бөөн төллүүлэх	Нялх хургыг зориулалтын тэжээлээр тэжээх	Намар 10-р сард махны үйлдвэрүүдэд бөөнөөр нийлүүлэх.	Сумын бойтой хамтрах	Малчдын хоршоод	Ойрхи Дорнодын зах зээл
Зохиомол хээлтүүлэг (600 үнээ)	Хургыг тохиромжтой аргаар хөнгөлөх		Малчдын хоршоод	Мал нялгалгааны үйлдвэрүүд	Тээвэрлэгчид	Дотоодын зах зээл
Малын тэжээл үйлдвэрлэл	Зуны сүүлээр хургыг ялгаж суурилан соргог бэлчээрт оторлох.			Хурганы мах экспортлогч ААН-үүд	Агуулахын АА	



ӨСВӨР ҮХРИЙН МАХ ҮЙЛДВЭРЛЭЛ


Өвлийн тугал, өсвөр үхрийн тэжээллэгийн сургалт зохион байгуулж, 102 хүн хамрагдсан. Малчдад тугалыг өвөл тэжээж онд оруулаад бяруунд нь зах зээлд борлуулах боломжийг танилцуулж, үхэр сүргийн эдийн засгийн үр өгөөжийн хувилбарт загваруудыг танилцуулсан.

Зураг 16.
Үхэр, хонийг эрчимтэй өсгөн бойжуулах технологийн сургалт



Зорилтот сумдын 6 малчин өрхийн 50 гаруй тугал, бярууны өвлийн тэжээлд туршилтаар уураг, эрдсийг нэмэгдүүлснээр 18 сартай Монгол үүлдрийн бяруу 326 кг амьдын жинд хүрч, М Агро ХХК-ны бордох аж ахуйд нийлүүлсэн.

Зураг 17.
Өсвөр үхрийн нэмэгдэл тэжээлийн туршилт



Энэ туршлага нь борлуулалтын хугацааг богиносгож, үхэр сүргийн толгойн тоог 20%-иар бууруулан тогтвортой мах үйлдвэрлэлд шилжих боломжийг харуулсан.

М Агро ХХК нэг удаад 5000 үхэр, жилдээ 10-12 мянган үхэр бордох хүчин чадалтай. Өртгийн сүлжээний энэ тоглогчийг үхрээр хангах нь малчдад тогтвортой зах зээл болно. Хэнтий аймгийн хойд 7 сум зах зээлд жил бүр 16,000 толгой бяруу борлуулах нөөцтэй. Тугалыг өвөл нэмэгдэл тэжээлтэй онд оруулж, ясны өсөлтийг дэмжих тэжээллэгийн аргыг хэрэглэж, маллах тэжээх хугацаагаа багасган бяруугаа 320 кг-аас дээш амьдын жинд хүргэж борлуулах бүрэн боломжтойг төслийн туршилт нотолсон.

Тус компаний бордооны аж ахуй нь Олон улсын хорио цээрийн дэглэмийг баримтлан, мах экспортлох замаар өсвөр үхрийн эрэлтийг орон нутагт бий болгож байгаа. Эрчимтэй өсгөн бойжуулж бяруунд нь нийлүүлэх аргыг малчид эзэмшиж, хэрэгжүүлэх, орлогоо нэмэгдүүлэх эхлэлийг тавьсан.

“Цөөн малаас өндөр ашиг шим авах боломжийг өөрийн туршлагаас харлаа”



Ц.Алтангоо
Хэнтий аймгийн
Баян-Адарга
сумын малчин

Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт, хүний буруутай үйл ажиллагаанаас болж уламжлалт мал аж ахуй эрхлэхэд жил ирэх тусам хүнд болж байгааг өдөр тутамдаа мэдэрч байна. Урьдынх шиг байгальдаа найдаад, малаа зүгээр л бэлчээрт тавиад ашиг шим хүртэх боломж бараг үгүй болжээ.

Нэг үхрийг 6–7 жил маллаж, дээрээс нь малчин цалинжуулаад 300–350 кг амьдын жинд хүргэж зах зээлд борлуулахад дөнгөж 3 сая төгрөгийн орлого олж байна. Гэтэл энэ хугацаанд гарч буй тэжээл, хөдөлмөр, бусад зардлыг бодоход ашиг биш, харин алдагдал л үлддэг. Үүнийг би өөрийн нүдээр харж, тооцоолж үзсэн.

Тиймээс л малаа удаан хугацаанд байлгах биш, богино хугацаанд эдийн засгийн эргэлтэд оруулж ашиг шим хүртэх хэрэгтэй гэж бодож эхэлсэн.

Ингээд 2024 оны 4 сараас махны чиглэлийн 140 үхэртэйгээр үйл ажиллагаагаа эхэлсэн. Миний зорилго тодорхой байсан. Үхрээ бяруу, шүдлэн настайд нь борлуулж, чанартай махнаас бодит ашиг хүртэх. Би 20 жил мал малласан туршлагатай ч шинжлэх ухаанд суурилсан мэдлэг дутмаг байснаа сургалтад суусныхаа дараа л жинхэнэ утгаар нь ойлгосон.

Дорнод хээрийн төслийн хүрээнд зохион байгуулсан сургалтад суухад би үхэр бордох, нэмэлт тэжээл өгөхдөө норм, технологи огт баримталдаггүй байснаа мэдсэн. Будаагаа буруу няцалж, тэжээлийг дутуу, эсвэл хэтрүүлж өгдөг байсан нь малын өсөлтөд сөргөөр нөлөөлдөг байж. Сургалтаар өвлийн улиралд малыг нэмэлт тэжээлээр тэжээхдээ хамгийн гол нь зөв технологиор тэжээх, алдсан эрдсийг нь нөхөх, тарга тэвээргийг алдуулахгүй байлгах, мөн дулаан хашаа, саравч зайлшгүй хэрэгтэй гэдгийг сайн ойлгож авсан. Үүнийхээ дагуу өөрийн аж ахуйд салхи, шуурга нэвтрэхгүй, цас орохгүй байхаар тооцож 20×10 м хэмжээтэй битүү байр, хоёр талдаа 20×6 м хэмжээтэй нүүрэвчтэй саравч барьсан. Материал, ажлын хөлс нийлээд 40 сая төгрөг зарцуулсан. Мөн 20 сая төгрөгөөр гүний худаг гаргуулж, малын усалгааг шийдсэн.

Мөн сургалтаас сурсан мэдлэгээ шууд ажилдаа хэрэгжүүлж, няцалсан улаан буудай, mimo ашиглан үхэр, тугалаа гүзээг нь агшаахгүй, тарга тэвээргийг нь алдуулахгүй тэжээсэн. Би огт шахаж бордоогүй. Нийтдээ 40 гаруй тугал, 20 гаруй бярууг 2024 оны 12 сараас 2025 оны

3 сарын 20 хүртэл тэжээгээд бэлчээрт гаргасан. Намар борлуулсан шүдлэнгийн гулуузны жин 200–210 кг, харин бярууны амьдын жин 326 кг болж, 2 сая 21 мянган төгрөгөөр зарагдсан. Анх удаа бяруугаа 2 сая төгрөгт хүргэж борлуулж үзсэн маань надад маш том урам өгсөн. Тэжээл идсэн мал тэжээл идээгүй малаас үнэхээр тэс өөр байсныг би биеэрээ мэдэрсэн.

Үхрээс гадна бог мал дээр ч туршилт хийж үзсэн. Хурганы тэжээл авч, хургаа тэжээж үзэхэд үр дүн нь маш сайн гарсан. 2025 оны 1 сард 20 хонь хургалахаар тооцож, нутгийн монгол хуц тавьсан. 17 хонь маань нэг сард хургалж, хургаа зориулалтын тэжээлээр тэжээсэн. Намар гэхэд хурганы амьдын жин 44.5 кг хүрч, зах зээлд борлуулсан хоёр хурганы гулуузны жин 22–23 кг болсон. Эр хургыг борлуулаад, эм хургыг цөм сүрэг болгох бүрэн боломжтойг энэ туршилт надад харуулсан. Манайх жилдээ 150 эм хонь хургалдаг байсан энэ жил 100 эм хонио 1 сард төллөхөөр тооцож махны чиглэлийн Эдэлбай хуц тавьсан. Одоо бараг төлөө аваад дуусаж байна.

Би малаа тоогоор нь биш, чанараар нь авч явах зорилготой. Бог малаа 1000 байснаас 400 болгож цөөлсөн. Энэ жил 80 үнээ тугална. Цаашдаа жилдээ 100 үнээ тугалуулж, бяруу, шүдлэн нийлээд 250 орчим үхрийн тоонд барина гэж төлөвлөж байна. Үүнээс жилд 60–70 шүдлэн борлуулж, тогтвортой орлого олох зорилготой. Малаа өвөл эрт төллүүлж, нэмэлт тэжээлээр тэжээгээд намартаа борлуулах нь малчны хөдөлмөрийг хөнгөрүүлээд зогсохгүй байгальд ч ээлтэй гэдгийг би ойлгосон. Дулаан байртай байхад мал ядардаггүй юм байна. Харин дан ганц байгалийн хадлангаар малыг онд оруулах боломж улам бүр багасаж байна. Тиймээс цаашид ногоон тэжээл тарих зорилготой ажиллаж байна.

Миний хувьд уур амьсгалын өөрчлөлттэй нүүр тулж буй өнөө үед цөөн малаас өндөр ашиг шим хүртэх, шинжлэх ухаанд суурилсан эрчимжсэн мал аж ахуй л малчдын ирээдүйн зөв зам гэж бодож байна.

БАГА ХҮЧИН ЧАДЛЫН МАЛ НЯДАЛГАА, ДАЙВАР БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР

- Төслөөс зарласан Эко-бизнесийг дэмжих тэтгэлгийн уралдаанд Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Тэнүүн Дарханхаан хоршоо шалгарч 90 сая төгрөгийн тэтгэлэг авч малын дайвар боловсруулах төслийг эхлүүлсэн. Дайвар боловсруулах цехийг өргөжүүлэн бага оврын мал нядалгааны 206 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг

төслөөс санхүүжүүлсэн. Дарьганга Брэнд болон Тэнүүн Дарханхаан хоршооны түншлэл хамтын ажиллагааны хүрээнд мал нядалгааны үйлдвэрийн газар, барилга, дэд бүтцийг 300 сая орчим төгрөгийг босгож байгуулсан.

- Үйлдвэр ашиглалтад орсноор өмнө нь хаягдаж байгаль орчныг бохирдуулж байсан дайвар бүтээгдэхүүнийг эдийн засгийн эргэлтэд оруулж, залуучуудад шинэ ажлын байр, орон нутагт шинэ орлогын эх үүсвэрийг бий болгосон.

Зураг 18.
Мал нядалгаа,
дайвар
боловсруулах
үйлдвэр, Сүхбаатар
аймгийн Сүхбаатар
сум.



- Мөн Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Ашид Мөнхбаян хоршооны мал нядалгааны үйлдвэрт 22.8 сая төгрөгний 20 тн багтаамжтай гүн хөлдөөгч нийлүүлснээр тус хоршоо тасралтгүй мал хүлээн авч төрөл бүрийн мах, дайвар бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэг болж, хоршоо ба малчдын орлогыг тогтвортой нэмэгдүүлэх боломж бүрдсэн.

Зураг 19.
Гүн хөлдөөх
төхөөрөмж,
Сүхбаатар аймгийн
Мөнххаан сум



Төслийн хүрээнд хурганы болон үхрийн махны үйлдвэрлэлийг эрчимжүүлж, тэжээллэгийн шинэ аргачлал нэвтрүүлэн, дайвар бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэр байгуулснаар малчдын орлого нэмэгдэж, бэлчээрийн дарамт буурч, тогтвортой махны нэмүү өртгийн сүлжээний загвар бий болсон.

АМЖИЛТЫН ТҮҮХ: Хоршоог хөгжүүлсэн туршлага



Х.Эрдэнэбаяр
Сүхбаатар
аймгийн
Сүхбаатар сум

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын удам тал нутагт мал аж ахуй олон үеэрээ амьжиргааны үндэс болсоор ирсэн. Гэвч сүүлийн жилүүдэд зах зээлийн савлагаа, бэлчээрийн доройтол, уур амьсгалын эрсдэл зэрэг олон хүчин зүйл малчдын амьдралд шинэ сорилт авчирчээ. Энэ нөхцөлд "Тэнүүн Дарханхаан" хоршооны үүсгэн байгуулагч Хуягтбаатарын Эрдэнэбаяр нутагтаа шинэ гарц эрэлхийлсэн юм.

Малчин айлд төрж өссөн тэрээр 13 жилийн турш Оюу Толгой, Huawei Technologies зэрэг байгууллагад ажиллаж, менежмент, үйлдвэрлэлийн туршлага хуримтлуулсан ч 2020 онд нутагтаа эргэн ирж махны бизнес эхлүүлжээ.

Ингэхдээ нутгийн малчдаас мал худалдан авч, гарал үүсэл нь тодорхой, эрүүл ахуйн шаардлага хангасан махыг зах зээлд нийлүүлэхийг зорьсон байна. Гэвч ижил нас, ойролцоо үүлдрийн малын махны чанар, гарц ихээхэн ялгаатай байгааг анзаарч, үүний цаана бэлчээрийн доройтол, үржүүлэг, менежмент, зах зээлийн уялдаа зэрэг системийн асуудал байгааг ойлгожээ.

Түүний хувьд Дорнод хээрийн төсөлтэй холбогдсон нь эргэлтийн цэг болов. Төслийн сургалт, зөвлөгөөнөөс тэр малчид хоршиж ажилласнаар бэлчээрээ хамгаалах, чанарт суурилсан үйлдвэрлэл хөгжүүлэх, зах зээлтэй илүү үр ашигтай холбогдох боломжтойг олж харсан байна. Ингээд "Тогтвортой бэлчээрийн төлөө тооноос илүү үнэ цэнэ" гэсэн зарчмаар нутгийн малчидтайгаа хамтран "Тэнүүн Дарханхаан" хоршоог байгуулжээ.

Хоршооны эхний бөгөөд хамгийн том сорилт нь итгэлцэл байв. Эрдэнэбаяр санаагаа тулгасангүй, харин малчдынхаа зовнил, цаг уурын эрсдэл, зах зээлийн тогтворгүй байдал, бэлчээрийн доройтлыг сонсож, хамтын шийдлийг санал болгосон. Үүний үр дүнд хоршоо өргөжин тэлж, өнөөдөр 40 малчин өрхийг нэгтгэн, 34 үүсгэн байгуулагч өрх үйлдвэрлэлд оролцож байна.

Төслөөс өгсөн 206 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмж, сургалтын дэмжлэг, өөрийн болон хоршооны нийт 300 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалтын үр дүнд хөргөлтийн агуулах бүхий нядалгааны болон мах боловсруулах бааз байгуулсан. Мөн 600 сая төгрөгийн зээлээр үйл ажиллагаагаа өргөжүүлсэн.

Өнөөдөр "Тэнүүн Дарханхаан" хоршоо нь малын тоо бус чанар, нэмүү өртөг, хамтын засаглалд түшиглэсэн хөгжлийн бодит жишээ болжээ. Энэ бол зөвхөн нэг хүний амжилт биш, харин бэлчээрээ хамгаалж, орлогоо өсгөж, ирээдүйгээ хамтдаа бүтээхээр нэгдсэн 40 малчин өрхийн хамтын амжилт юм.

НООЛУУРЫН НЭМҮҮ ӨРТГИЙН СҮЛЖЭЭ

Монголын Тогтвортой Ноолуурын Эвсэл ТББ (SFA)-тэй хамтран ажиллаж, ноолуур самнах, малын тавлаг байдал, бэлчээр ашиглах зохистой дадлуудын сургалтууд зохион байгуулж, нийт 10 хоршооны 150 малчин SFA зохистой дадлын гэрчилгээ авч тогтвортой аргаар ноолуур үйлдвэрлэх дадал эзэмшсэн.

Зураг 20.
ТННЭ-ийн зохистой
дадлын сургалт



- Сүхбаатар аймгийн Мөнххаан сум, Дорнод аймгийн Матад, Хөлөнбуйр, Булган сум, Хэнтий аймгийн Баян-Овоо сумын 10 хоршоо тогтвортой ноолуурын бэлтгэн нийлүүлэгч/үйлдвэрлэгчийн SFA Олон улсын гэрчилгээ авсан. Эдгээрээс 3 хоршоо нь эмэгтэйчүүдийн удирдлагатай байна.
- Монгол Улсын ноолуурын зах зээлийн тогтвортой байдлыг хангах, харцангуй давуу талыг хадгалах зорилгоор төслөөс “Чанарт суурилсан үнийн схем”-ийг туршин нэвтрүүлэх ажлыг санаачлан хэрэгжүүлсэн. Энэ нь шинэлэг шийдэл бөгөөд ноолуурын чанар буурах эрсдлээс сэргийлэх ба ноолуурын үнийг өсгөхөд ач холбогдолтой юм. Иймд Сүхбаатар аймгийн Мөнххаан сум, Дорнод аймгийн Матад сум, Хэнтий аймгийн Баян-Овоо сумын гурван хоршоонд ноолуурыг чанар болон өнгөөр нь ангилан

ялгаж, дотоодын SFA гэрчилгээтэй боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлсэн. Туршилт амжилттай хэрэгжиж малчдын хоршооноос өнгөөр ялгасан 1 кг ноолуур тутамд 5,000 төгрөгийн нэмэлт орлого буюу шинэ орлогыг 2024-2025 онд малчдад бий болгосон.

- Ноолуурын чанарт суурилсан үнийн схемийг турших хүрээнд ангилсан ноолуурын 600 уут тарааж 20.3 тонн ноолуурыг өнгөөр ялгаж ялгавартай үнээр тушаасан. Энэ нэмэлт үнээр борлуулсан орлого нь шинээр бий болсон орлого бөгөөд 3%-иар өссөн байна.
- Төслийн хугацаанд хоршоодоос ТННЭ-ийн гэрчилгээтэй 152.6 тонн ноолуурыг бэлтгэн дотоодын үйлдвэрүүдэд тушааснаар 23.7 тэрбум төгрөгийн орлогыг малчдад бий болгосон.

- Мөн нийт давтагдсан тоогоор 4 хоршоо ТННЭ болон Хаан банкны хамтарсан Тогтвортой ноос ноолуур нийлүүлэлтийн ногоон зээлд хамрагдаж 1.5 тэрбум төгрөгийн зээл авч түүхий эд бэлтгэлдээ зарцуулсан.
- Төслийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг Тогтвортой ноос ноолуур эвсэл SFA ТББ бүрэн хариуцан, нийт 2.3 сая фунт стерлингийн санхүүжилт бүхий 4 жилийн “Нэг эрүүл мэнд” төслийг 2026 оноос Сүхбаатар аймагт хэрэгжүүлж эхлээд байна.
- Ноолуурын чанар буурах эрсдлээс сэргийлж, ноолуурын үнийг өсгөх “Чанарт суурилсан үнэ тогтоох” схемийг санаачлан ТННЭ-ийн тогтвортой ширхэгтийн стандартыг нэвтрүүлсэн ноолуурыг Европын зах зээлд зорилтот сумдаас нийлүүлж эхэлснээр цаашид ямааны ноолуурын чанарыг сайжруулах, тооноос чанарт шилжих, малчдын орлогыг нэмэгдүүлэх тогтвортой өсөн нэмэгдэх зах зээлийг бий болгосон.

ХОНИНЫ НООСНЫ ҮНЭ ЦЭНИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ШИНЭЛЭГ АРГЫГ НУТАГШУУЛАВ

- Төслөөс ноос хяргах, ноос бэлтгэлийн үйл ажиллагаанд механикжуулалт нэвтрүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах зорилгын хүрээнд Мон Пеллет ХХК, Shear Mongolia ТББ-тай хамтран ажилласан.
- Цаашид дээрх байгууллагууд тогтвортой эрэлтийг бий болгох, шинэ ажлын байр, ур чадварыг бий болгох замаар залуу малчдыг ажлын байраар хангаж, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэхээр ажиллаж байгаа.
- Сүхбаатар аймгийн Мөнххаан, Сүхбаатар сум, Дорнод аймгийн Булган, Матад сум, Хэнтий аймгийн Норовлин сумын Малчдын

хоршооны гишүүдэд цахилгаан машинаар хонины ноос хяргах, ноос ангилах, пресслэх талбайн сургалт зохион байгуулж, 139 хүнийг сургасан.

- Хонины ноосны үнэ цэнийн сүлжээний зах зээлийн холболт, түншлэлийн уулзалт зохион байгуулж, зорилтот сумдын ХАА-н хоршооны 35 хүнийг хамруулж, боловсруулах үйлдвэрүүдтэй танилцуулсан.
- Төслөөс 126.3 сая төгрөгний 4 цахилгаан хяргагч иж бүрдэл болон 4 пресслэх машин Сүхбаатар аймгийн Мөнххаан, Сүхбаатар, Хэнтий аймгийн Норовлин сум, Дорнод аймгийн Булган сумын 4 хоршоонд нийлүүлсэн.

Зураг 21.

Ноосыг цахилгаан хайчаар хяргах сургалт



Зураг 22.

Пресслэгч машин нь ноосны оврыг багасгаж, ачих буулгах зардал хэмнэж, ачаа даацыг нэмэгдүүлдэг.



- Ноос хяргах ажлыг багийн төв болон мал эмнэлгийн угаалгын цэгийн орчимд зохион байгуулснаар малчид хонио хяргуулж, угаалгах үйлчилгээг нэг дороос авч, зардал, хөдөлмөр, цаг хугацаагаа хэмнэх боломжтой болсон. Мөн хоршоод ноосоо нэг

газар бэлтгэж, пресслэж, зөөвөрлөх боломжтой болж, тээврийн зардлыг 3 дахин бууруулсан.

- Өмнө нь нэг хонийг ~3,000 төгрөгөөр хяргуулж байсан. Цахилгаан хайчаар хяргуулахад 2,000 төгрөгөөр зардал буурч, алдагдал багассан.
- Цаг тухайд нь хяргаж, гадна паразитаас ангижирснаар хонь тарга тэвээргээ сайн авч, намар **2 кг** ахиу гулууз мах үйлдвэрлэх боломжтой болсон.
- Сургалтанд хамрагдсан Мөнххаан, Норовлин сумын хоёр залуу малчин Шинэ Зеланд улсад хонь хяргагчаар ажиллаж, шинэ ажлын байр, шинэ орлого бий болсон.
- Мон Пеллет ХХК зорилтот сумдын хоршоодтой гэрээ байгуулж, 37 тн хонины ноосыг 37.4 сая төгрөгөөр авч, ангилалт хийж, сайн чанарын ноосыг хивсний үйлдвэрт илүү үнээр нийлүүлсэн. Үлдсэн тааруу ноосыг хивсний үйлвэрийн хаягдал ноостой хольж **"ноосон бордоо"** үйлдвэрлэн Герман зэрэг орнуудад экспортолж 226,000 евро орлого олсон.
- Ингэснээр хонины ноосны өртгийн сүлжээг **хаягдалгүй, ашигтай салбар** болгон хөгжүүлэхэд хувь нэмэр оруулж байна.

Зураг 23.

Ноосон бордоо



Ноос хяргах үйл ажиллагаанд механикжуулалт нэвтрүүлж, зардлыг бууруулснаар малчдын бүтээмжийг нэмэгдүүлж, шинэ ажлын байр бий болгосон. Ноосны өртгийн сүлжээг хаягдалгүй, ашигтай салбар болгон хөгжүүлэхэд бодит хувь нэмэр оруулсан.

ОРОН НУТАГТ НООС УГААХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХ

- Орон нутагт гэрийн эсгий эрэлт хэрэгцээтэй байдаг бөгөөд Дорнод аймгийн Булган сумын "Эсгий дулаалга" хоршоо гэрийн эсгий үйлдвэрлэж, тус сумын болон зэргэлдээ сумын эрэлтийг тодорхой хэмжээнд хангадаг.
- Гэвч тус хоршооны үйлдвэрлэлийн байр жижиг, өргөтгөх зай талбай хязгаарлагдмал буюу голын хамгаалалттай бүсэд байрладаг, угаагаагүй ноосоор үйлдвэрлэлээ эрхлэдэг нь байгаль орчинд болон хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад төдийлөн нийцдэггүй.

- Тус хоршоо төслөөс зарласан Эко-бизнесийн 52.6 сая төгрөгний дэмжлэг, хоршооны 37.3 сая төгрөг, болон хүн хүч гарган, зөвшөөрсөн шинэ газар Ноос угаах үйлдвэр байгуулж, хүчин чадлаа нэмэгдүүлсэн.
- Үйлдвэрийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор жижиг хэмжээний нядалгааны газрын барилга нэмж өргөтгөсөн.
- Энэхүү үйл ажиллагааны үр дүнд суманд 6-10 шинэ ажлын байр бий болгож, угаасан ноосны өнгө үзэмж сайжирч, зунгагны үнэргүй эсгий үйлдвэрлэх боломж бүрдсэн.

ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШОО (ХЗХ) БАЙГУУЛАХ, ЧАДАВХЖУУЛСАН ҮР ДҮН

- Төслийн зорилтот сумдад ХЗХ байхгүй, итгэлцэл сул, ихэнх тохиолдолд сөрөг мэдээлэлтэй байсан.
- Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо (МХЗХҮХ)-ны мэргэжил, арга зүйн дэмжлэгтэйгээр "Олон нийтийн оролцоонд суурилсан байгалийн нөөцийн менежментийн санхүүжилт"-ийн загварыг хөгжүүлэх замаар газрын тогтвортой менежментийг дэмжих зорилгоор орон нутгийн санаачилгаар 2023 онд Сүхбаатар аймгийн Сүхбаатар, Хэнтий аймгийн Баян-Адарга суманд, 2024 онд Сүхбаатар аймгийн Түмэнцогт, Хэнтий аймгийн Баян-Овоо суманд ХЗХ тус тус байгуулагдсан.

Зураг 24.
Хэнтий аймгийн
Баян-Овоо сумын
ХЗХ-ны нээлт



- Гишүүдийн итгэлийг бэхжүүлэх, дотоод засаглалыг сайжруулах, хүртээмжтэй санхүүгийн үйлчилгээг өргөжүүлэхийн тулд ХЗХ-ны чадавхыг бэхжүүлэх, орчин үеийн санхүүгийн програм ашиглан санхүүгийн менежментийг сайжруулах, хуримтлалыг нэмэгдүүлэх, хариуцлагатай зээлийн үйл ажиллагааг жигдрүүлэхэд чиглэсэн чадавхи бэхжүүлэх сургалт, зөвлөгөөнд дөрвөн ХЗХ-ны нийт 340 гишүүд хамрагдсан.

Зураг 25.
ХЗХ-ны санхүүгийн
програм
хангамжийн
сургалт



- 2025 оны эцсийн байдлаар:
- Нийт гишүүдийн тоо: Дөрвөн ХЗХ-ны 564
- Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө: 625 сая төгрөг
- Зээлийн багц: 613.5 сая төгрөг
- Хадгаламжийн багц: 483 сая төгрөг
- Хувь хөрөнгө: 166 сая төгрөг
- Ашиг: 41.9 сая төгрөг
- МХЗХҮХ-ноос ХЗХ-ны үйл ажиллагааны найдвартай байдлыг үнэлсний дараа орон нутгийн засаг захиргаа малчдыг тэжээлийн нөөц бүрдүүлэх, амьжиргааны эрсдэлийг бууруулахад дэмжлэг үзүүлэхээр тогтож, Баян-Адарга сумын ИТХ 2024 оны Малын тоо толгойн албан татварын орлогоос 10 сая төгрөгийг "Адарга Баян Дуурлиг" ХЗХ-ны "Тэжээлийн эргэлтийн сан"-д хуваарилсан.
- Малчин гишүүдийн эрсдлийг бууруулах, хурганы мах үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор тус төслөөс Сүхбаатар сумын "Ашид ундран арвижих" ХЗХ, Баян-Адарга сумын "Адарга Баян дуурлиг" ХЗХ, Баян-Овоо сумын ХЗХ-нд нийт 26.6 тн, 60.1 сая төгрөгийн хурганы хорголжин тэжээл нийлүүлж "Тэжээлийн эргэлтийн сан" буюу зээлийн шинэ бүтээгдэхүүн бий болгосон.

“Нэгнийгээ түшиж, хамтдаа өсөх итгэлээс Хадгаламж зээлийн хоршоо маань эхэлсэн”



Ц.Алтанцэцэг
“Адарга Баян
Дуурлиг”
Хадгаламж
зээлийн хоршоо
гүйцэтгэх захирал

Бидний хэдэн нөхөд хоршоогоо байгуулахаас өмнө зөвлөлдсөн юм. “Хэрэв хадгаламж зээлийн хоршоо байгуулбал сумынхаа иргэд, малчдыг хэрхэн хамруулах вэ? Анхны хөрөнгөө хэдэн төгрөгөөр, хэрхэн бүрдүүлэх вэ?” гэж олон талаас нь тооцоолж ярилцсаны эцэст манай суманд иргэдийг нэгтгэсэн, хамт олны мэдрэмж төрүүлдэг байгууллага ховор тул ер нь ийм хоршоо хэрэгтэй, мөн ямар нэгэн төсөлд хамрагдах боломж бий эсэхийг судлахаар санал нэгдсэн.

Энэ үед төслийн зүгээс бидэнд маш том дэмжлэг үзүүлсэн. Төслийн хамт олон бидний бүх зардлыг дааж Дорнод аймгийн Баян-Уул, Хэнтий аймгийн Биндэр

суманд амжилттай ажиллаж буй хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагаатай бодитоор танилцуулан, хоршоо байгуулахын давуу болон бэрхшээлтэй талуудыг нь ойлгуулснаар “энэ ажлыг манай суманд хийж болно, бүр хийх ёстой юм байна” гэсэн итгэл улам батажсан.

Ингээд бид зориг шулуудан хадгаламж зээлийн хоршоогоо албан ёсоор 2023 онд 45 гишүүнтэй, 9 сая төгрөгийн хөрөнгөтэйгөөр эхлүүлж байв. Хоршоо байгуулагдсан даруйд сумын иргэд, ялангуяа малчдаас элсэх хүсэл, сонирхол ихээр ирсэн нь бидэнд урам өгсөн. 2025 оны жилийн эцсийн байдлаар манай хоршоо 297 гишүүнтэй болж, 580 гаруй сая төгрөгийн актив хөрөнгөтэй тогтвортой үйл ажиллагаа явуулж байна. Энэ бол бидний итгэл, хамтын хүч, зөв удирдлагын үр дүн гэж бодож байна.

Манай сум дөрвөн багтай бөгөөд үүний гурав нь хөдөөний баг юм. Дээр хэлсэнчлэн сумын иргэд, малчдын хувьд хоршоонд элсэх сонирхол их байдаг. Учир нь тэднийг хамруулсан нийгэм, соёлын арга хэмжээ харьцангуй ховор. Иймд бид санхүүгийн үйлчилгээ үзүүлэхээс гадна гишүүддээ, мөн олон нийтэд зориулсан арга хэмжээг тогтмол зохион байгуулж ирсэн. Зуны улиралд гишүүдээ хамруулан салхинд гарах, хөгжөөнт тэмцээн зохион байгуулах, шинэ жилийн баярыг хамтдаа тэмдэглэх, хаврын улиралд байгальд ээлтэй, хамтын ажиллагааг дэмжсэн арга хэмжээнүүдийг санаачлан тогтмол явуулдаг. Ийм үйл ажиллагаа тогтворжсоноор хүмүүсийг илүү ойртуулж, “би энэ хамт олны нэг хэсэг” гэсэн мэдрэмж төрүүлдэг. Энэ нь сумын нийт иргэдийн амьдралд эерэг өөрчлөлт авчирч байна гэж үздэг.

Цаашид бид хадгаламж зээлийн хоршоогоо илүү тогтвортой, ил тод, найдвартай болгох зорилт тавин ажиллаж байна. Санхүүгийн чадавхаа бэхжүүлж, гишүүдийн тоог нэмэгдүүлэхийн зэрэгцээ

гишүүдэд чиглэсэн үйлчилгээ, арга хэмжээг илүү чанартай болгох зорилготой. Мөн хоршоо байгуулсан туршлага, түүхээ бусад сум, орон нутагт түгээн хуваалцаж, хамтын хүчээр хөгжих боломж байдгийг харуулах нь дараагийн том алхам юм.

Эргээд харахад, бидний эхлүүлсэн энэ ажил нь зүгээр нэг санхүүгийн байгууллага бус, харин хүмүүсийг нэгтгэж, итгэлцлийг бий болгон, хамтдаа өсөж хөгжих замыг нээсэн хамтын түүх болсон байна.

ТЭЖЭЭЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ДАВАН ТУУЛАХ, ДАСАН ЗОХИЦОХ ЧАДАВХЫГ НЭМЭГДҮҮЛЭВ

Бэлчээр дэх малын хөлийн дарамтыг бууруулах, малчдын амьжиргааны тогтвортой байдлыг хангахын тулд малын тэжээл үйлдвэрлэлийн гурван загварыг малчид, малчдын байгууллага, газар тариалангийн компаниудтай хамтран туршин хөгжүүлэв.


ЗАГВАР I:

Малчин өрх өвөлжөөний бууцандаа овъёос тариалж, түүнийг хураан авч даршлах, малаа тэжээхэд суралцсан. Малчдад тарих үр, даршлахад хэрэгцээтэй уут, гар хэрчигч, цахилгаан хэрчигчийг нийлүүлсэн.

- Хэдийгээр их хэмжээний тэжээл үйлдвэрлэх боломжгүй ч малчид тэжээл тариалах талаар туршлагатай болох нь тариаланчдад хандах, тэжээлийн үнэ цэнийг ойлгох, авсан тэжээлээ зөв зохистой ашиглах, ашиг шим багатай малаа цөөлөх хандлагын өөрчлөлтийг авчрах, мөн богино хугацааны эрсдэлийн үед малаа цөөн хоног тэжээж, дараагийн гарц шийдлээ олоход дөхөм болж, тэдний эрсдэлийг бууруулахад ач холбогдолтой болсон. 2022 онтой харьцуулахад 2025 онд бууцандаа тариалсан малчин өрхийн тоо 8.2 дахин, ургацын хэмжээ 367 дахин, тариалсан талбай 52.6 дахин өссөн байна.

Зураг 26.

Малчдын өвөлжөөний бууцанд ногоон тэжээл тариалалт



- Малчдын энэ бүх мэдлэг, чадвар, хандлагын өөрчлөлт нь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, даван туулах замд хөтөлж, бэлчээрийн хомсдол, байгалийн элдэв үзэгдлийг сөрөн тэсвэрлэх чадамжийг нэмэгдүүлэх боломжийг олгох юм.

“Дарш бэлтгэл өвөл, хаврын эрсдэлийг бууруулах бүрэн боломжтой”



А.Одбаяр
Баян-Адарга
сумын Жаргалант
багийн малчин

Манай гэр бүл 2020 оноос эхлэн 1 га талбайд царгас тариалж эхэлсэн нь бидний аж ахуйд томоохон өөрчлөлт авчирсан үйл явдал болсон. Царгасаа жил бүр тогтмол арчилж, ургацаас нь өвс бэлтгэхээс гадна багахан хэсгээр нь дарш хийж сурсан. Олон жил тариалсан царгас маань одоо дарш бэлтгэхэд хангалттай хэмжээнд хүрч, жилдээ ойролцоогоор 5 тонн орчим дарш хийх бололцоотой болсон. Энэ нь өвөл, хаврын тэжээлийн гол үүсвэр болж байна.

Бид энэхүү төслөөс зохион байгуулсан ногоон тэжээлийн дарш бэлтгэх сургалтад хамрагдаж, мөн ногоон тэжээлийн үр авч тарьсан. Энэ нь бидэнд “ямар тэжээл өгөх вэ” гэдгээс гадна “ямар үед, яаж, хэрхэн нөөцлөх вэ” гэдгийг системтэй ойлгоход их тус болсон. Төсөлд хамрагдсанаар орлого, малын тоо толгой шууд огцом нэмэгдсэн гэхээсээ илүү малдаа ашиг шим сайтай тэжээл тогтмол бэлтгэж, намар эртнээс тэжээлд оруулах нь малчин бидэнд ямар чухал болохыг ухаарсан.

Өмнө нь бид зөвхөн царгасны дарш бэлтгэж, үнээндээ өгдөг байсан. Харин сүүлийн жилүүдэд нэмэлтээр ногоон тэжээлийн дарш хийж эхэлснээр үр дүн нь илүү тодорхой харагдсан. Ногоон тэжээлийн дарш өгч эхэлснээс хойш өвөл, хаврын улиралд сүүний гарц нэмэгдэж, малын тарга тэвээрэг илт сайжирсан. Ялангуяа хаврын сүүлээр тэжээлийн хомсдол үүсэх үед дарш ихээхэн дэм болдог. Сүүлийн арван жил бид 20–40 тооны саалийн үнээтэй байсан бөгөөд тоо толгойноос илүү чанар, ашиг шимийг чухалчилж ирсэн нь зөв шийдвэр байсныг одоо улам ойлгож байна.

Манайх зуны улиралд 40 орчим үнээ тогтмол сааж, нэг үнээнээс өдөрт дунджаар 3–8 литр сүү авдаг. Сүүгээ түүхийгээр нь зарахаас илүү боловсруулж, ааруул, эзгий, өрөм, бяслаг, цөцгий цохин борлуулж байна. Ингэснээр сүүний үнэ цэнийг нэмэгдүүлж, улирлын хэлбэлзлээс бага хамаарах боломжтой болсон. Сүү боловсруулахад ч тэжээлийн чанар шууд нөлөөлдөг. Сүү тослог сайтай, өтгөн байх нь бүтээгдэхүүний гарц, амт чанарт илт мэдэгддэг.

Манайх царгасны даршийг 2023 онд 800 кг, 2024 онд царгас, ногоон тэжээлийн даршийг 2 тонн, 2025 онд 3 тонн царгас, ногоон тэжээлийн дарш бэлтгэсэн. Өнгөрсөн жилийн 3 тонн даршаа 40 саалийн үнээ, 40 бяруу, шинээр тугалах гунжнууддаа өгч байна. Цаашид жил бүр тогтмол 4–5 тонн дарш бэлтгэж, нөөцлөх зорилготой байгаа.

Одоогоор ногоон тэжээлээ өвөлжөөнийхөө хашаанд тарьж байгаа ч цаашид тусгайлан тариалах талбайтай болох бодол бий. Хэрэв Монгол Улсын Засгийн газраас малчдад олгох 5 га газрын асуудал бүрэн шийдэгдвэл бидэн шиг олон малчин тэжээлийнхээ асуудлыг илүү урт хугацаанд, тогтвортой шийдэх боломжтой болно гэж найдаж байна. Миний хувьд энэ туршлагаа бусад малчидтайгаа хуваалцаж, малын чанар, ашиг шимийг нэмэгдүүлэхэд тэжээлийн зөв менежмент хамгийн чухал гэдгийг онцлон хэлмээр байна.

ЗАГВАР II: Малчдын бүлэг, нөхөрлөл, хоршоод өөрсдийн хөдөлмөр, хөрөнгөөр нэгдэж тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлсэн сайн туршлага

Булган сумын Баян эрхтийн бүрд нөхөрлөл нь тус төслийн сургалтанд хамрагдаж, 18.3 сая төгрөгний 9.4 тн хурганы тэжээл 2023 оны хавар авч төлөө тэжээж, “Тэжээлийн эргэлтийн сан” байгуулсан. Тухайн жилээ атаршсан 104 га талбайг бусад 3 нөхөрлөл, компанитай хамтран сумаасаа давуу эрхээр эзэмшихээр авч, Тэжээлийн эргэлтийн сангийн хуримтлагдсан мөнгө болон бусад нөхөрлөлийн малчдын хөрөнгөөр хашаалж, 80 сая төгрөгний үнэтэй хавагч, анжис, үрлэгч, өвс хэрчигчийг худалдан авсан. ХХААХҮЯ-наас нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг дэмжиж 85 морины чадалтай трактор нийлүүлсэн.

Зураг 27.
Дорнод аймгийн
Булган сумын
БНХМ-ийн
нөхөрлөлүүдийн
тэжээл
үйлдвэрлэлийн үйл
ажиллагаа



2023-2024 онд төслөөс 47 сая төгрөгний 20.2 тн овьёос болон суданы үрийг олгож, нийтдээ 65.3 сая төгрөгний “Тэжээлийн эргэлтийн сан”-тай болохын зэрэгцээ 2023-2025 онуудад 56-500 тн ногоон тэжээл тус тус бэлтгэсэн нь зах зээлийн дундаж үнээр 28-200 сая төгрөг болж байна.

“Олон малтай байвал баян биш, чанартай малтай байвал баян”



Би Булган сумынхаа Чулуут 4-р багт амьдардаг, “Баян-Эрхтийн бүрд” нөхөрлөлийн ахлагчаар хэдэн жил ажиллаж байна.

Манай нөхөрлөлийн түүхийг яривал 2017 оноос эхтэй. Тухайн үед манай суманд “Зуд, ой хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхыг бэхжүүлэх нь” төсөл хэрэгжиж манай энэ хавиар нутагладаг 17 өрх нийлж бүлэг байгуулж байлаа. Харин 2021 оноос ТНС-ийн Байгалийн хамтын менежментийн нөхөрлөл болж өргөжөөд, айл саахалтаараа нэгдэж, байгаль дэлхийгээ хамгаалахын төлөө илүү зохион байгуулалттай ажиллаж эхэлсэн.

Х.Өнөрцэцэг
Дорнод аймгийн
Булган сумын
малчин,
Баян-Эрхтийн
бүрд нөхөрлөлийн
ахлагч

Нөхөрлөл болсны ач тус их. Хавар, намартаа галын эргүүл гаргана, өндрийн харуулд зогсоно. Хадлан тэжээлээ хамт бэлтгэнэ, ямаагаа хамт самнана, хонио ноосолно, хужир шүү татна. Ажил ихтэй үед хүчээ нэгтгээд ороход дорхноо амжуулчихна. Тэр ч байтугай нийгмийн хариуцлагаа ухамсарлаад, хандив тусламж, олон нийтийн ажилд идэвхтэй оролцдог болсон. Нэг ёсондоо бид зөвхөн малаа биш, нутаг орноо хамтдаа авч явж байна.

Сүүлийн жилүүдэд бэлчээрийн ургамлын гарц муудаж, төрөл зүйл нь цөөрч байгааг бид бүгд мэдэрч байна. Зөвхөн байгалийн хадланд найдах нь эрсдэлтэй болсон. Тиймээс Дорнод хээрийн төслөөс зохион байгуулсан ногоон тэжээл тариалах, дарш бэлтгэх сургалтад гурван удаа хамрагдсан. Сурсан зүйлээ зүгээр орхиогүй, бодитоор хэрэгжүүлсэн. Одоо бид гар доорх халгай, лууль, шарилжаа ашиглаад нэг өрх дунджаар 400 кг дарш бэлтгэдэг болсон. Нэмэлт тэжээл гэдэг чинь малчдын хувьд ашиг орлогоо хамгаалах хамгийн чухал гарц юм байна гэдгийг ойлгосон доо.

2023 оны хавар Дорнод монголын хуурай хээрийн ландшафт, биологийн олон янз байдлыг хамгаалах төслөөс 18.3 сая төгрөгийн үнэ бүхий 9.4 тонн хурганы тэжээл авч, төлийг тэжээснээр манай “Тэжээлийн эргэлтийн сан”-гийн суурь тавигдсан. Тэр жилдээ Цагаан-Өндөр, Цагаан нуур, Бадрах нөхөрлөлийн 169 малчин гишүүн, орон нутгийн хоёр компанитай хамтарч сумын Засаг дарга, ИТХ-д хүсэлт гарган 104 га тариалангийн талбай авч чадсан. Шинэ ажил эхлүүлэхэд хөрөнгө мөнгө, туршлага гээд бэрхшээл их байсан ч дөрвөн нөхөрлөлийн гишүүд нийлж 10 гаруй сая төгрөг босгож, 100 гаруй малчин ердөө хоёрхон өдрийн дотор хашаагаа барьж дуусгасан. Тэр үеийн эв нэгдлийг бодохоор одоо ч урам ордог юм.

Төслөөс чанартай үр, суулгац, мэргэжлийн зөвлөгөөгөөр дэмжсэн нь үнэхээр том тус болсон. Үүний үр дүнд 2024 оны зудыг бид хорогдол багатай давж гарсан. Одоо манайх 65.3 сая төгрөгийн “Тэжээлийн эргэлтийн сан”-тай, 80 сая төгрөгийн техник хэрэгсэлтэй, ХХААХҮ-ийн сайдаас бэлгэнд авсан 85 морины хүчтэй трактортой болсон. Анх хэдхэн айлын нэгдэл байсан бол одоо нэлээд том айл шиг л болсон доо.

Төслийн санаачлагаар 60 га тариалангийн газарт ганд тэсвэртэй, нэг наст тэжээлийн ургамлыг хэдэн нөхөрлөл хоёр жил дараалан амжилттай тариалсан. Судан өвс маш тэжээллэг бөгөөд сүү ч сайн оруулж байна. Манайхан өмнө нь 11-р сард үнээ аль хэдийн ширгэчихдэг бол сүүлийн хоёр жилд үнээнүүд сүү ороод их орой ширгэх болсон, сүү саальтай байх хугацаа уртасаад сайхан л байна.

Бид бас “Олон малтай байвал баян” гэдэг хуучин ойлголтоо өөрчилсөн. Чанарт анхаардаг болсон. 2022-2023 онд 17 мянга гаруй малтай байсан бол 2025 оны жилийн эцсийн тооллогоор 31 өрх 15 мянга гаруй малтай болсон. Өрхийн тоо нэмэгдсэн хэрнээ малын тоо цөөрсөн нь малчид маань цөөн малаас илүү ашиг шим авах сэтгэлгээтэй болсны илрэл гэж би боддог.

2025 оны наймдугаар сард манай нөхөрлөлийн 20 гаруй айл 1800 гаруй хургаа “Дорнод мах маркет” компанид шууд нийлүүлсэн. Хурганы гулуузны жин дунджаар 17.8-19.3 кг татаж байсан нь чамлахааргүй үзүүлэлт. Арванхоёрдугаар сард зарим шилмэл хургаа маань төлөгний жинд хүрч, нэг бүрийг нь 200 мянган төгрөгөөр борлуулсан малчин ч бий. Энэ бүхэн бол хамтын хөдөлмөрийн үр шим.

Манай нөхөрлөл улирал бүр хуралдаж, тайлангаа ярилцаж, цаашдын ажлаа төлөвлөдөг. 2025 оны зургаадугаар сараас хуримтлалын сан байгуулж, өрх бүр жилдээ 500 мянган төгрөг төвлөрүүлдэг болсон. Одоогоор 9 сая төгрөг хуримтлуулчихаад, гишүүддээ 2 хувийн хүүтэй зээлж, мөнгөө эргэлдүүлж байна. Тэжээлийн эргэлтийн сандаа ч айл бүр жилдээ 100 мянган төгрөг төвлөрүүлж, дараа жилийнхээ тэжээлийн үр, шаардлагатай тоног төхөөрөмжийг бэлтгэдэг тогтолцоонд орсон.

Цаашид хийх ажил их байна. Хашаа хороогоо сайжруулж, малаа тэжээх битүү хашаатай болох, тариалангийн талбайгаа нэмэгдүүлэх, судан өвс, ногоон тэжээлээс гадна эрдэнэшиш, холимог тариалалт туршиж үзэхээр судалж байна.

Малчид бид эвтэй байж, бие биенээ дэмжиж чадвал ямар их үр дүнд хүрдгийг үнэхээр мэдэрч байна. Төслийнхэн маань асааж өгсөн тэр гал бөхөх биш, улам бадраад, нутаг орноо өөд нь татах их ажил үргэлжилнэ гэдэгт итгэлтэй байгаа шүү.

Зураг 28.

Булган сумын
Баян-Эрхтийн
бүрд нөхөрлөлийн
ногоон тэжээл
үйлдвэрлэл



- 2023-2024 оны зуднаар нийт мал сүргийн 70 хувийг алдсан Сүхбаатар аймгийн Сүхбаатар суманд сүүний үхрийн фермийн аж ахуй эрхлэх, нэгдэж хорших сонирхол нэмэгдсэнээр тус сумын 9 сүүний хоршоо хамтран дундын хоршоо байгуулсан. Уг дундын хоршоо нь Төр ба хувийн хэвшлийн түншлэл болон НҮБ-ын ХХААБ-ын хэрэгжүүлж буй "Хөдөө аж ахуйн амьжиргаа, хүнсний аюулгүй байдлыг хамгаалах урьдчилан сэргийлэх арга хэмжээг өргөжүүлэх II" төслийн дэмжлэгтэй байгуулсан хоногт 1000 л сүү боловсруулах хүчин чадалтай сүүний үйлдвэрт сүүгээ нийлүүлж, 2025 оны 9-р сараас Баруун-Урт сумын дунд сургуулийн 7-оос дээш ангийн 2400 сурагчдад өдөр бүр шинэ сүү, тараг өгч эхэлсэн.
- Дээрх сүү үйлдвэрлэлийн түншлэлийг дэмжих зорилгоор төслөөс 2.4 тэрбум төгрөгний төсөвт өртөг бүхий, 6 жилийн хугацаанд үе шаттай хэрэгжүүлэх "Эрчимжсэн сүүний үхрийн фермийн аж ахуйн цогцолбор байгуулах" ТЭЗҮ-г боловсруулсны дагуу төслийн эхний шатны санхүүжилт болох 300 сая төгрөгийг Сүхбаатар аймаг 2026 оны төсөвтөө суулгав.
- Хамтарсан санхүүжилтээр Хэнтий аймгийн Баян-Адарга, Норовлин сум, Сүхбаатар аймгийн Сүхбаатар, Баруун-Урт сумдад хөгжүүлж буй сүүний нэмүү өртгийн сүлжээний цаашдын тогтвортой байдлыг хангах шаардлагын улмаас малын тэжээл, ялангуяа дарш үйлдвэрлэл нэмэгдэж байна.
- Хэнтий аймгийн Баян-Адарга, Норовлин суманд малчид ба хоршоо хамтран нийт 134 тн дарш үйлдвэрлэсэн, 2022 онтой харьцуулахад дарш үйлдвэрлэл 600 дахин нэмэгдсэн.

ЗАГВАР III:

Орон нутагт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйд түшиглэн "Захиалгат тариалан" хөгжүүлэх ажлын хүрээнд таван газар тариалангийн компанид 2024 онд 49.8 тн овьёос, судан өвсний үрийг "Эргэлтийн сан" байгуулах нөхцөлтэй нийлүүлж 468 га талбайд 2024-2025 онуудад тариалж нийлбэр дүнгээр 3,569 тн ногоон тэжээлийг тээврийн зардал ороогүй орон нутгийн зах зээлийн ханшаар борлуулсан.

- Дээрх компаниуд нь сумын Засаг дарга, эсвэл аймгийн ХХААГ-тай байгуулсан гэрээндээ тэжээлийг орон нутгийн ханшаар малчдад борлуулах, урьдчилсан захиалга авдаг болох, ургацын орлогоос "Үрийн эргэлтийн сан"-даа тогтмол хуримтлал үүсгэж, тэжээл тариалах талбайгаа бууруулахгүй байх үүрэг хүлээсний дагуу тус компаниуд 98.6 сая төгрөгний "Үрийн эргэлтийн сан"-г байгуулж, 2025 онд энэ хөрөнгийн эх үүсвэрээр тэжээлийн таримлын үр авч тариалсан.

Зураг 29.

Сүхбаатар аймгийн
Сүхбаатар сум,
Дорнын шим агро
ХХК-ны тариан
талбай



Сүхбаатар сумын малчид фермерүүд газар тариалангийн компани хооронд сүүлийн хоёр жилд захиалгат тариалангийн түншлэл бий болж улмаар сүүний дундын хоршооны гишүүн "Баянмөнх Ундрах" хоршоонд явуулын бага оврын даршны тоног төхөөрөмж нийлүүлсэн. 2025 онд 17.5 тн дарш үйлдвэрлэсэн. Цаашид тус компанийн талбайд түрээсээр тариалж, дарш үйлдвэрлэж бусад хоршоо, малчдад нийлүүлж байх хэлцлийг хийж тус хоршоо болон аймгийн ХХААГ-тай гэрээ байгуулсан. Ингэснээр Сүхбаатар, Баруун-Урт сумдад сүүний өртгийн сүлжээний тогтвортой байдлыг хангах тэжээл үйлдвэрлэлийн өртгийн сүлжээний загварыг бий болгож нутагшуулсан.

Зураг 30.
Бага оврын даршны тоног төхөөрөмж, Сүхбаатар аймаг



МАЛЫН ТЭЖЭЭЛ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ГУРВАН ЗАГВАРЫГ ТАНИЛЦУУЛСНЫ ҮР ДҮН:

- Төслийн үндсэн зорилго, зорилтын хүрээнд бэлчээрийн газрын доройтлыг бууруулах менежментийг үр дүнтэй хэрэгжүүлэх, малчдын амьжиргааны гол эх үүсвэр болох малын өсөлтийг хязгаарлах, байгаль цаг уурын хүндрэлийг даван туулах чадварыг нэмэгдүүлэх шинэ орлого ба ажлын байрыг бий болгоход бодит дэмжлэг үзүүлэв.
- Зөвхөн бэлчээрийн гарцад тулгуурласан байдлаас гарч бэлчээрийн дарамтыг бууруулах таримал тэжээлийн шинэ нөөцийг бий болгох, өвөл-хаврын улиралд малаа тэжээх тэжээлийн хямд эх үүсвэртэй болж, МАА-н эрсдлийг бууруулах боломжтойг харуулав.
- Өвөлжөө, хаваржаанд ихээр хуримтлагдсан бууцыг дулааны улиралд ногоон бүрхүүлтэй байлгаж, шимт бодисыг ногоон масс болгоход ашиглах, бороо чийгтэй үед ялзарч хүлэмжийн хий үүсэлтийг бууруулахад малчдын ногоон тэжээл тариалалт ач холболтой байх нь дамжиггүй. Малчдын нөхөрлөлүүд материаллаг боломж нөхцөлөө өөрсдийн хүчээр бий болгож гишүүдийн тэжээлийн хэрэгцээг бүрэн хангах, байгалийн бэлчээрт үзүүлэх малын дарамтыг бууруулах, малын тэжээлийн шинэ эх үүсвэрийг бий болгох замаар байгаль цаг уурын хүндрэлийг даван туулах, дасан зохицох чадавх бий болж байна.
- Тэжээлийн нэр төрөл, хүртээмж нэмэгдсэнээр зарим төрлийн малаа өвөл-хавар тэжээх, мах ба сүү үйлдвэрлэлийг улирлаас хамааралгүй эрхлэх, орлогоо нэмэгдүүлэх боломжтой болов.
- “Захиалгат тариалан” нэвтрүүлснээр малчид ба тариаланчдын хоорондын зөрчлийг арилган эдийн засгийн хувьд бие биенээ дэмжсэн, эрсдлээ бууруулсан, газрын доройтлыг тэглэхэд хувь нэмэр оруулсан түншлэл, хамтын ажиллагааны загвар бий болох боломжтой болохыг харуулав.

МАЛ АЖ АХУЙН ЭРСДЛИЙГ БУУРУУЛАХ, ДАВАН ТУУЛАХ ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ ЗАГВАРЫГ БИЙ БОЛГОВ

Тогтвортой мал аж ахуйн хөгжлийг дэмжих зорилгоор тал хээрийн бүсэд хурганы мах, сүүний фермийн хосолсон загвар аж ахуйг Сүхбаатар аймгийн Сүхбаатар суманд “Найрамдлын жигүүрт хүлгүүд” хоршооны хамтарсан санхүүжилтээр байгуулав. Ингэхдээ гал түймэрт тэсвэртэй, бат бөх материалаар, цасан болон шороон шуурганаас хамгаалах, малчдын хөдөлмөр хөнгөвчлөх, малын тавлаг байдлын хангах, аж ахуйн зардлыг хэмнэх олон шинэлэг шийдэл бүхий нийт 500-600 бог, 60-70 сүүний үхэр өсгөн үржүүлэх загвар аж ахуйн хашаа саравчийг барьснаас гадна хийцлэл, төсөвт өртөг, техникийн зураг төслийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, орон нутгийн удирдлагаар дамжуулан малчдын дунд түгээн сурталчилсан.


Зураг 31.
Тал хээрийн бүсэд хосолмол зорилгоор ашиглах саравч, хашааны загвар



- Хэнтий аймгийн NomadTech - Мал аж ахуйн тоног төхөөрөмж ХХК-ны барьсан Тал хээрийн бүсэд тохиромжтой саравч хашааны загварын дагуу одоогийн байдлаар Сүхбаатар аймгийн 3 малчин хашаа саравч захиалан бариулснаас гадна уг загвараас санаа авч говийн бүст тохирсон хашааны загварыг НҮБ-ын ХХААБ-ын нэг төсөл бариулсан. Хэнтий аймгийн хүсэлт, хамтарсан санхүүжилтээр хэрэгжүүлэх Монгол орны ойт хээрийн бүсэд тохиромжтой Исланд загварын 800 хонины өвөлжөө барих барилгын зураг, төсвийн тооцоог хийсэн зэрэг төслийн сайн туршлага, мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх, цаашдын тогтвортой байдлыг хангахад эерэг нөлөө үзүүлэх бодит, шинэлэг үйл ажиллагаа болов. Өвөлжөөг энэ оны IV сараас Хэнтий аймаг, Исландын хамтарсан санхүүжилтээр барихаас гадна малчдын хүүхдүүдэд гэрийн боловсрол олгох, малчдын залгамж халааг бэлтгэх, байгалийн нөөцийн зохистой менежментэд суурилсан тогтвортой, үр ашигтай хонины аж ахуйн бизнесийн шинэ загварыг бий болгоход хувь нэмэр оруулах юм.

Зураг 32.

Ойт хээрийн бүсэд зориулсан эрчимжсэн хонины аж ахуйн саравч, хашаны загвар



- НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын хэрэгжүүлж буй төслүүд хоорондын ажлын уялдааг ханган мал аж ахуйн салбарын үндэсний онцгой байдлын удирдамжид нийцүүлэн SMART аргачлалаар зудын гамшгийн менежментийн төлөвлөгөө боловсруулах чадавхыг бэхжүүлж улмаар Сүхбаатар аймгийн Мөнххаан, Сүхбаатар, Түмэнцогт сумын ажлын хэсгүүд 2025 оны сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг SMART аргачлалыг ашиглан боловсруулсны үр дүнд Сүхбаатар болон Мөнххаан сумууд Баянцагааны тал БНГ-т цагаан зээрийн гол үржлийн бүсэд бэлчээрийг өнжөөх, сэлгэн ашиглах арга хэмжээ төлөвлөснийг Мөнххаан суманд хэрэгжилтийн бүрэн хангаж ажилласан.

Сүүний фермийн аж ахуйг эрхлэн хамтын хүчээр эрсдлийг давах боломж байна



Г.Батсуурь
Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Найрамдлын жигүүрт хүлгүүд” хоршооны дарга

Би хувиараа бизнес эрхэлж, мал мах худалдан авч борлуулдаг байлаа. Гэвч дан ганц худалдаа хийхээс илүүтэйгээр тогтвортой үйлдвэрлэл эрхлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн бий болгох нь чухал гэдгийг ойлгосон.

Сүхбаатар аймагт хувь хүн, хоршоодууд саалийн үхрийн фермийн чиглэлээр үйл ажиллагаа тус тусдаа явуулдаг байсан. Гэвч сүүлийн жилүүдэд манай суманд тохиолдсон байгаль цаг уурын хүндрэл, гамшгийн улмаас тус тусдаа үйл ажиллагаа явуулах боломж улам хязгаарлагдан, хөрөнгө, зах зээл, аж ахуй эрхлэх мэдлэг мэдээллийн хувьд олон бэрхшээл тулгарч байсныг нуух аргагүй.

Төслүүдээс ч энэ чиглэлээр нэлээд нөлөөлсөн.

Тиймээс 2025 оны 1-р сард үхрийн фермерийн чиглэлээр ажилладаг 9 хоршоо нэгдэн “Мандах наран сүүн далай” хэмээх дундын хоршоо байгуулсан нь бидний хувьд маш том алхам болсон. Хоршоод нэгдсэнээр хоорондын уялдаа холбоо сайжирч, хамтын хүч, хамтын шийдвэрийн үнэ цэнийг илүү ойлгож эхэлсэн. Ингэснээр хоорондоо арга туршлага солилцохоос гадна зах зээлд нэгдсэн байдлаар, нэг стандартаар сүүгээ нийлүүлэх, үнийн нэгдсэн бодлого баримтлах томоохон зорилт тавьж хамтын хөдөлмөрийн давуу талыг ашиглан хөгжиж дэвжих боломж нээгдсэн.

Дорнод хээрийн төслийн дэмжлэгтэйгээр 2025 онд бэлчээрийн болон хагас суурин маллагаатай хонь, үхрийн аж ахуй эрхлэхэд тохиромжтой, тал хээрийн бүсэд зориулсан загвар хашаа, саравчтай болсон. Энэхүү саравч нь бидний хувьд эрчимжсэн мал аж ахуйн суурь болсон гэж хэлж болно. Одоогоор бид саалийн үнээний фермийн чиглэлээр ажиллаж, 10 үнээ сааж, Сүхбаатар аймгийн “Нутгийн сүү” сүүний үйлдвэрт тогтмол нийлүүлж, сургуулийн хүүхдүүдэд өдөр бүр сүү, тараг уулгах аймгийнхаа хөтөлбөрийн хэрэгжилтэнд хувь нэмрээ оруулж байгаа.

Анх удаа фермерийн зарчмаар, тогтсон цагийн хуваарьтай сааль, ариун цэврийн дэглэм, тэжээлийн зохистой хэрэглээ зэргийг баримтлан ажиллахад бидэнд эхэндээ мэдэхгүй, чадахгүй зүйлс их байсан. Гэхдээ төслийн зүгээс зохион байгуулсан саалийн үнээний фермтэй айлд байрлан дадлагажих сургалтанд хамрагдсанаар бид алдаагаа засаж, зөв арга барилд аажмаар шилжиж чадсан. Өөрөөр

хэлбэл, “харж сурсан, сонсож мэдсэн”-ээ бодит ажил дээр хэрэгжүүлэх боломж олдсон юм.

Төслөөс барьж өгсөн саравчаа бүрэн ашиглахын тулд хашаажуулах, гүний худаг гаргах ажлыг шат дараатай хийх бодолтой. Мөн бяруу худалдан авч, богино хугацаанд шахаж бордоод зах зээлд нийлүүлэх, ингэснээр эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлэх зорилт тавьж байна.

Манай зорилго бол бүрэн эрчимжсэн гэхээсээ илүүтэй нутгийн онцлогт тохирсон хагас эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх юм. Ингэснээр байгальд ээлтэй, зардал багатай атлаа зах зээлийн шаардлагад нийцсэн үйлдвэрлэл явуулах боломжтой гэж үзэж байна.

Нэгдэж хамтарсны үр дүнд манай Дундын хоршоо Сүхбаатар аймгийн иргэдийн сүүний хэрэгцээг хангах том зорилтыг тавьж ажиллаж байна. Энэ ажлыг маань дэмжиж төслөөс 100 саалийн үнээтэй аж ахуй байгуулах ТЭЗҮ боловсруулж, бидний зорилтыг маш тодорхой болгож өгсөн. Аймгийн удирдлагууд ч биднийг дэмжиж 2026 оны төсөвт маш том дэмжлэг болохуйц хөрөнгийг тусгасан байгаа.

Цаашлаад, 2027 оноос эхлэн хурга бордох ажлыг туршиж, богино хугацаанд зах зээлд нийлүүлэх төлөвлөгөөтэй байна. Энэ нь нэг талаас орлогын эх үүсвэрийг төрөлжүүлэх, нөгөө талаас малчдын хөдөлмөрийг хөнгөвчлөх, эдийн засгийн эргэлтийг хурдасгах ач холбогдолтой гэж харж байна.

Өнөөдөр бидний хийж буй энэ ажил бол ганц нэг хүний хүчээр биш, хамтын ажиллагаа, итгэлцэл дээр суурилсан бүтээн байгуулалт юм. Хоршоод нэгдэж, төслийн дэмжлэгтэйгээр суралцаж, туршлага хуримтлуулж байж л манай сум, аймгийн байгалийн нөхцөлд тохирсон эрчимжсэн мал аж ахуй руу бодитой алхам хийж болдгийг бид өөрсдийн замналаар ойлгож байна. Цаашид ч бид энэ чиглэлээрээ тууштай ажиллаж, орон нутагтаа жишиг болохуйц фермерийн аж ахуйг бий болгох зорилготой байна.

ТАРИАЛАНГИЙН ГАЗРЫН ХӨРСНИЙ ДОРЙТЛЫГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ:

- Төсөл болон Монголын тариаланчдын үндэсний холбооны санаачилгаар Хэнтий аймгийн Хэнтийн тариалан ХХК-ийн амжилттай нэвтрүүлсэн нөхөн сэргээх газар тариалангийн 5 зарчим, түүний салшгүй хэсэг болсон холимог тариалангийн аргыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн газар тариаланчдыг хамруулсан “Зүүн бүсийн залуу тариаланчдын менторшип хөтөлбөр”-ийг 2023-2025 онд амжилттай хэрэгжүүлэв.

НӨХӨН СЭРГЭЭХ ГАЗАР ТАРИАЛАН-ТАВАН ЗАРЧИМ Эрүүл хөрс-эрүүл баталгаат хүнс-тогтвортой үйлдвэрлэл



- Уг хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан сургалт, хэлэлцүүлэг, зөвлөлдөх уулзалт, талбайн өдөрлөгт Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Булган, Хөвсгөл, Увс, Архангай аймгийн тариаланчид, яам, орон нутгийн мэргэжилтнүүд, судлаачид зэрэг нийт 327 оролцогч хамрагдан нөхөн сэргээх газар тариалангийн 5 зарчмыг тариалангийн үйлдвэрлэлд нэвтрүүлснээр хөрсний үржил шим богино хугацаанд нэмэгдэх, химийн бодисын хэрэглээ, зардал буурах, таримлын ургац, тариаланчдын ашиг орлого нэмэгдэхэд үзүүлж буй эерэг нөлөөллийн талаарх мэдлэг, мэдээлэл, сайн туршлагыг хуваалцсан.

Зураг 33.
Талбайн өдөрлөг



- Менторшип хөтөлбөрийн хүрээнд төслийн зүгээс холимоогоор тарих үнэ цэнтэй таримал болох вандуй, маалинга, шар гич, шар

будaa, судан өвс зэрэг таримлын үр, дээж авах, ургамлын чанарыг хянах багажуудыг нийлүүлсэн.

Зураг 34.
Ургамлын бриксийн үзүүлэлтийг хэмжиж байгаа нь



- Вандуй, Өвөлжих хөх тариа, Маалинга, Сэвэг зарам, Шар буурцгийн үрийг, Улаан буудай+Маалинга, Улаан буудай+Овьёос, Судан+Маалинга+Вандуй, Вандуй+Шар гич, Арвай+Маалинга, Шар будaa+Гурвалжин будaa гэсэн холимгоор тариалав. (Хэнтийн Тариалан ХХК)

Хүснэгт 2.
Тариалсан холимогийн мэдээлэл

№	Холимог тарьсан таримал	Га-норм	Талбайн хэмжээ /га/	Хураасан ургац /тонн/
1	Улаан буудай + Маалинга	40 кг/га+3 кг/га	665	1115
2	Судан + Маалинга	25 кг/га+15кг/га	60	600
3	Вандуй + Шар гич	60 кг/га+3 кг/га	260	153
4	Улаан буудай + Овьёос	30 кг/га+20 кг/га	55	71
5	Судан + Маалинга + Вандуй	25 кг/га+15кг/га	52	300
6	Шар будaa + Гурвалжин будaa	15 кг/га+25 кг/га	48	72
7	Маалинга+Шар гич	5 кг/га+3 кг/га	70	80
8	Хөх тариа	60 кг/га	80	
9	Улаанбуудай + Вандуй шар + Хөх тариа + Шар буурцаг + Агчвандуй + Шар гич + Овьёос+ Судан + Арвай + Гиш + Маалинга + Шар будaa + Гурвалжин + Сорго + Эрдэнэшиш	бүрхүүл	40	

Менторшип хөтөлбөрийн хүрээнд Хэнтийн тариалан компанийн холимог тарьсан талбай хооронд шавжийн харьцуулсан судалгааг Биологийн хүрээлэнгийн судлаач хийхэд холимог талбайд шавжийн биологийн олон янз байдал баялаг байсан. Мөн өмнө нь 16 төрлийн холимог тарьсан талбайд тариалсан улаан буудай пестицид огт хэрэглээгүй. Эдгээр жишээ нь холимог тариалангийн үед хөрсний ашигт бичил биетийн үзүүлэлтүүд эрс нэмэгдэж, таримал ургамлын

өвчин ба хортон шавьжид нэрвэгдэх нь мэдэгдэхүйц багассанаар пестицидийн хэрэглээг бууруулах, экосистем дэх биологийн төрөл зүйлийн олон янз байдал сэргэж, хөрсний бичил биетний чанар ба тоон үзүүлэлт нэмэгдэж, хөрс эрүүлжих, нөхөн сэргэх процесс идэвхжиж улмаар хүлэмжийн хийг шингээх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулдаг тухай олон улсын мета судалгааны үр дүнтэй дүйцэж байна. Өмнөх жил нь вандуй тариалсан талбайд улаан буудай тарихад чанар сайжирч, цавуулаг нэмэгдэн, хортон шавьжид тэсвэрлэх байдал нь сайжирснаар химийн бодисын хэрэглээ буурав.

Дадал буудай ХХК-ний холимог тарьсан талбайн хөрснөөс дээж авч Хөдөө аж ахуйн нэгдсэн лабораториор агрохимийн шинжилгээ хийлгэсэн. Буурцагт ургамлын холимог хөрсний ялзмагийг богино хугацаанд буюу хоёр жилийн дотор үлэмж хэмжээгээр нэмэгдүүлдэг болохыг уг шинжилгээний дүнгээр нотолсон.

Зураг 35.
Өмнөгч нь 16 төрлийн ургамлын холимог. Улаан буудай моно тариалан. Үрийн норм 40кг/га. 4-р сарын дундуур үрлэгдсэн. Ургамал хамгааллын бодис болон бордоо хэрэглээгүй. Хэнтийн аймаг



БАГА ҮРИЙН НОРМООР УЛААНБУУДАЙ ТАРИАЛАХ ТУРШИЛТ



- Холимог тариалангийн бас нэг дэвшилтэд арга нь **бага үрийн норм, эртийн тарилт** бөгөөд холимог тариаланд үндсэн нормоос бага хэмжээний үрийг ашигладаг бол харин эртийн тариаланг таримлын төрөл, хур тунадас, хөрс зэрэг олон зүйлээс хамаарч хугацааг сонгодог.
- Ялангуяа ус чийгийн дутагдалтай үед өндөр үрийн норм нь зүйл доторх өрсөлдөөнийг бий болгох өндөр магадлалтай болохыг харгалзан энэхүү сайн туршлагыг менторшип хөтөлбөрийн хүрээнд Хэнтийн Дадал, Өлзийт, Хэрлэн суманд тус тус туршсан.
- Залуу тариаланч А.Лувсандагва, Хэнтийн аймгийн агрономч Э.Оюун-Эрдэнэ нарын өөрсдийн магистрын зэрэг горилсон судалгааны ажлын хүрээнд хийсэн улаан буудайн бага үрийн нормын туршилтаар Дадал сум буюу ойт хээрийн бүсэд 80 кг/га, Өлзийт сум буюу хуурай хээрийн бүсэд 1 сая га буюу 40-50 кг/га хамгийн үр дүнтэй болох нь харагдсан.

- Нөхөн сэргээх тариалангийн хөрсөнд үзүүлэх "механикийн болон химийн дарамтыг аль болох багасгах" гэдэг зарчмыг хэрэгжүүлэхийн тулд устгахад төвөгтэй байдаг. Өвөлжих болон эртийн хог ургамлыг амжилттай дарангуйлдаг аллелопат шинж чанар өндөртэй хөх тариаг 2024 он анх 80 га талбайд тариалсан. Үүний үр дүнд намар, өвөл, хаврын туршид хөрсийг амьд үндэстэй байлган хөрсийг тэжээж, хөрсний механик, химийн дарамтыг бууруулснаас гадна хөрсийг салхины элэгдлээс хамгаалж, цасан хунгар үүсгэн, нүүрсхүчлийн хийн шингээлтийг сайжруулсан өндөр ач холбогдолтой туршилт болов.
- Хэнтий аймгийн Өлзийт, Хэрлэн суманд гурав дахь жилдээ тариалсан гич-вандуйн холимгийн үндсэнд ихээхэн хэмжээний азотын булцуу үүссэн (Зураг 36). Ийм хэмжээний булцуу нь 34 %-ийн агууламжтай аммонийн бордоог нэг га талбайд 300 кг хэрэглэсэнтэй тэнцүү хэмжээний агаарын азотыг нийлэгжүүлэх тул зардлыг тэр хэмжээгээр хэмнэхээс гадна хөрсний үржил шим, эрүүл байдал сайжирна гэсэн үг.

Зураг 36.
Вандуй-шар гичийн холимгийн үндсэнд агаарын азот нийлэгжсэн байгаа нь




Нөхөн сэргээх тариалангийн "хөрсөнд үзүүлэх механикийн болон химийн дарамтыг аль болох багасгах", нөхөн сэргээх тариалангийн чухал зарчмыг хэрэгжүүлэхийн тулд устгахад төвөгтэй байдаг өвөлжих болон эртийн хог ургамлыг амжилттай дарангуйлдаг аллелопат шинж чанар өндөртэй хөх тариаг 2024 онд анх 80 га талбайд "бүрхүүл ургамал" байдлаар тариалсан. Үүний үр дүнд намар, өвөл, хаврын туршид хөрсийг амьд үндэстэй байлган хөрсийг тэжээж, хөрсний механик, химийн дарамтыг бууруулснаас гадна хөрсийг салхины элэгдлээс хамгаалж,

цасан хунгар үүсгэн, нүүрсхүчлийн хийн шингээлтийг сайжруулсан өндөр ач холбогдолтой туршилт болов.

Зураг 37.
Тетра короткая сортын өвөлжих хөх тариа. Хэнтий аймаг, Өлзийт. 2024.10.12
Үрийн норм: 75кг/га, Үрлэгдсэн хугацаа: 2024.09.03.



Зураг 38.
Өвөлжих хөх тариа - ургац



Хэнтий аймгийн Хэрлэн сум дах Хэнтийн тариалан компанийн холимог тариаланд дараах эерэг нөлөө тус тус ажиглагдсан. Үүнд:

- **Ажиглалт 1:** Судан өвс-Маалинга-Вандуй гурван ургамлаас тогтох уг холимог 5-р сарын 12-нд үрлэгдэж, 20-нд цухуйлт жигдэрсэн байсан. 5-р сарын 30-нд хийсэн ажиглалтаар Судан өвс 15 см өндөртэй ургалт хэвийн явагдаж байсан. 2025 оны 5-р сарын 29-30-ны шилжих шөнө хөрсөн дээр -6...-8°C цочир хүйтрэл бий болсон. Хүйтрэлт арвай-вандуй болон улаан буудай- вандуйны холимог тариалангийн вандуйнд мэдэгдэхүйц нөлөөлж нийт ургамлын 50-иас дээш хувь нь үхсэн. Харин Судан өвс- Маалинга-Вандуй гурван ургамлаас тогтох холимог тариалангийн Судан өвс болон вандуй нь хүйтрэлийг амжилттай давсан ба нүдэн ажиглалтаар өчүүхэн төдий хүйтэнд нэрвэгдсэн шинж тэмдэг илрээгүй. Дулаан улирлын ургамал болох Судан өвс хүйтрэлийг давж, цаашид амжилттай ургаж чадсан нь сонирхол татам байв. Үүнийг зарим судлаачид ургамал хоорондын синерги харилцаатай холбон тайлбарладаг. Уг холимог тариалангийн нөгөө 2 ургамал болох вандуй болон маалинга нь сэрүүн улирлын ургамлууд бөгөөд өөрсдийн хүйтэн тэсвэрлэх чадвараас Судан өвстэй үл мэдэгдэх механизмаар хуваалцсан байж болох юм. Мөн эдгээр ургамлууд бүгд микориз мөөгтэй симбиоз харилцаанд ордог ургамлууд учир микориз мөөг нь хүйтэн тэсвэрлэх сингал ба/ эсвэл бодисуудын дамжуулагч байж болох юм.


- **Ажиглалт 2.** 2024, 2025 онд тариалагдсан Арвай-Вандуй, Улаан буудай-Вандуйны холимог тариалангийн хувилбарууд нь манай нөхцөлд (хуурай хээрийн) тохиромжгүй холимог болох нь ажиглагдсан. Эдгээр холимог тариалангийн



үед вандуй нь дарангуйлагдаж байгаа нь илт байв. Харьцуулсан ажиглалтаар ижил орчинд тариалагдсан Судан өвс-Маалинга-Вандуй гурван холимог тариалан дахь вандуй нь ямар нэг стрессийн шинжгүй мөн дурдсан хоёр холимог хожим үрлэгдсэн ч ногоон массын хувьд 2 дахин их байв. Анх дурьдсан хоёр холимог тариаланг хийхээр төлөвлөж байхдаа буурцагт ургамалтай тариалагдсан арвай болон улаан буудайн уургийн агууламж өндөр байх тухай таамаглаж байсан нь зөвхөн вандуйны хувьд биелсэн. 2025 оны Арвай-Вандуй, Улаан буудай-Вандуйны холимог тариалангийн үетэний ургацын ГХӨ 1 байсан бол вандуйных 0.1-ээс бага байгаагаас вандуй ямар хэмжээнд дарангуйлагдсан болохыг ойлгож болох юм.

- **Ажиглалт 3.** Өмнөх намар нь өвөлжих хөх тариа тариалаад дараах хавар нь улаан буудай тариалсан талбайд хог ургамал ургаагүй бөгөөд пестицид огт хэрэглээгүй нь мөн анхаарал татсан ажиглалт болсон. Зарим судлаачид хүйтний улиралд хөрсний бичил биетний харьцаанд мөөг тал нь давамгайлдаг тухай дурдсан байдаг. Хөх тариа ба улаан буудай аль аль нь хөрсний микориз мөөгтэй симбиоз харилцаанд ордог ургамлууд. Иймд намар, өвөл, хаврын хүйтэн сэрүүн үед хөх тариатай харилцаанд орж ажиллагаатай байсан микориз мөөг залган улаан буудайтай харилцаанд орж улмаар бактерилаг хөрсөнд ургадаг хог ургамлуудыг дарангуйлсан байж болох юм.
- Холимог тарьсан талбай болон уламжлалт тариалан эрхлэж буй хяналтын талбайг хооронд харьцуулан шавжийн судалгааг хийхэд холимог талбайд шавжийн биологийн олон янз байдал баялаг байсан (Өлзий, 2025). Энэ нь холимог тариалангийн арга технологийг ашигласнаар экосистем дэх биологийн төрөл зүйлийн олон янз байдал сэргэж, хөрсний бичил биетний чанар ба тоон үзүүлэлт нэмэгдэж, хөрс эрүүлжих, нөхөн сэргэх процесс идэвхждэг тухай олон улсын судалгааны үр дүнг баталгаажуулсан.

Зураг 39.
Нөхөн сэргээх тариалангийн байгаль орчин, эдийн засгийн давуу тал



**УХААЛАГ ГАЗАР
ТАРИАЛАНГИЙН
ТЕХНОЛОГИ
НЭВТРҮҮЛЭХ
ЗАМААР ГАЗРЫН
ӨГӨӨЖИЙГ
НЭМЭГДҮҮЛЭВ.**



- Хэнтий аймгийн Баян-Овоо сумын иргэдийн санаачилгаар төсөл, сум, орон нутгийн иргэдийн хамтарсан санхүүжилтээр нийт 15 айл өрхийг хамруулсан "Эко гудамж" бий болсон. Эко гудамжны өрхүүд жил бүрийн аймаг, сумын ургацын баярт идэвхтэй оролцож Баян-Овоо сумын тэргүүлэх тариаланч, сургагч багш нар амжилттай оролцон "Шилдэг бүтээгдэхүүн" шагналыг тогтмол авахын зэрэгцээ шинэхэн ногоогоо жуулчны баазуудад нийлүүлж, ногоочдын орлого, үйлдвэрлэл эрс нэмэгдсэн.
- Баян-Овоо суманд эхлүүлсэн "Эко гудамж" санаачилга өргөжин төслийн сургалт, дэмжлэгийн үр дүнд Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын 10 өрх айл, Хэнтий аймгийн Норовлин суманд 14 залуу хос нэгдэн гудамжаа ногоон болгох, жимсний, чимэглэлийн төрөл бүрийн мод, хүнсний ногоо тариалж байна
- Төслийн зорилтот таван сумын эко клубын хүүхэд, сургууль, цэцэрлэгийн багш, тогооч нарыг сургалтад хамруулан үр, хүлэмжийн дэмжлэг үзүүлсний үр дүнд сургууль, цэцэрлэгүүд өөрсдийн тарьсан ногоогоор хийсэн тэжээллэг хоолоор хүүхдүүдийг хангадаг болсон.

Зураг 40.
Эко гудамж



🔍 ҮР ДҮН

- Энэ санаачилга нь амьжиргааны түвшин доогуур өрхүүд болон сумын төвийн малчдад шинэ орлогын эх үүсвэр бий болгохоос гадна сумын иргэдийн ногоо, мод тарих, хүлэмжийн аж ахуй эрхлэх зэрэг байгальд ээлтэй үйл ажиллагааг эрхлэх сонирхол нэмэгдсэнийг төслийн хүрээнд явуулсан мэдлэг, хандлага, дадлын судалгаа нотолсон.
- Иргэдийн хашаандаа тав тухтай амьдрах, сумын төвийн цөөн малтай иргэд орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлэх, орон нутгийн зах зээлд хүнсний ногоо нийлүүлэх, улмаар хамтын хөдөлмөрийн үр шимийг хүртэх боломжийг бусдад харуулсан энэхүү санаачилгын үр дүн Хэнтий аймгийн Баян-Овоо суманд хүнсний ногоо, мод тариалах айлуудын сонирхол нэмэгдэн төсөл эхлэхэд 5 айл хүлэмжинд ногоо тарьдаг байсан бол 2025 онд 114 айл болж өргөжсөн.
- Төслийн хугацаанд хүнсний ногооны үйлдвэрлэл нэмэгдэн 78.3 тонн хүрсэн бөгөөд үүний 46% нь хүлэмжийн ногоо байна.



“Хөрс шороогоо хайрлаж, хүн амаа эрүүл хүнсээр хангах нь миний зорилго”



Би Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын уугуул. 2000 оноос хойш нөхрийнхөө хамт мал маллаж, 200–300 толгой малтай аж төрж ирсэн. Мал аж ахуй бидний амьдралын үндэс байсан ч цаг хугацаа өнгөрөхийн хэрээр амьдралын өөр зам, шинэ боломжийг эрэлхийлэх хэрэгцээ аяндаа болсон юм.

2012 онд бид 9 өрхийн 36 гишүүнтэйгээр “Баянзулгэрэл” хоршоог байгуулсан. Хоршоо байгуулагдсаны дараа нөхөр маань гэрийн хаалга, тооно, сандал ширээ зэрэг төрөл бүрийн модон эдлэл урлаж борлуулдаг болов. Тэр үед хөдөөгийн багахан газрыг хүрэээр хагалж, анх удаа төмс тарьж үзсэн нь миний ногоочин болох эхлэл байлаа.

Ц.Гэрэлмаа
Сүхбаатар аймгийн
Сүхбаатар сумын
“Баянзулгэрэл”
хоршооны дарга

2014 оноос хоршооны гишүүдтэйгээ хамтран 0.5 га талбайд шар манжин, төмс, луван, цагаан луван тарьж эхэлсэн. Тухайн үед их ашиг олох зорилго тавиагүй, харин өөрсдийн хэрэгцээг хангах ногоо тарих байв. Гэсэн ч тарих тусам, мэдэх тусам ургамал соёолж, ургаж байгааг харах ямар их жаргалтай, мөн энэ ажлын сайхныг мэдэрч эхэлсэн.

2022 оноос Дорнод хээрийн төслийн сургалтад хамрагдсанаар би ногоо тарих талаар илүү их мэдлэгтэй бож, өргөн хэрэглээний ногооноос гадна нарийн ногоо тарьж эхэлсэн. Алдаа оноотой ч жинхэнэ ногоочны жаргалыг тэр үеэс илүүтэй мэдэрсэн гэж хэлж болох юм. Хүмүүс бэлчээрийн даац хэтэрлээ, газрын доройтол нэмэгдэж байна гэж ярьдаг. Харин ногоочид бид хөрсөө эрүүлжүүлж, нөхөн сэргээхэд хувь нэмрээ оруулдаг буянтай ажил хийдэг боддог. Хүн амаа эрүүл хүнсээр хангах ажилд илүү төвлөрөхийн тулд мал аж ахуйгаа хүүдээ өвлүүсэн.

Дорнод хээрийн төсөлд би чин сэтгэлээсээ талархаж явдаг. Энэ төсөл миний амьдралд шинэ зорилго, урам зориг, тэмүүлэл нэмсэн. Сургалтуудаас юугаар ч үнэлэшгүй мэдлэг олж авсан. Түүнчлэн үр хүүхэд, ач зээ нар минь хөдөлмөрт дурлаж, газар шороотой харьцаж байгааг харах хамгийн сайхан. Өнгөрсөн жил аймгийн төвд амьдардаг хүүхдүүдийнхээ хашаанд улаан лоолийн үрсэлгээ суулгаж өгсөн. Намар нь амт чанар сайтай ургац хураан авахыг хараад хүүхдүүд маань өөрсдөө ногоогоо тарьж ургуулах урам зоригтой болсон. Миний тарьсан ногооноос урам авч, ногоочин болохоор шийдсэн хүн ч цөөнгүй бий.

Өнгөрсөн жил төслийн зөвлөмжийн дагуу манай аймагт төдийлөн тарьдаггүй ч борлуулалт сайтай улаан лооль, тарвас зэргийг туршиж тарьсан. Ялангуяа Сүхбаатар аймагт ховор тарьдаг тарвасыг амжилттай ургуулж бусдад “болдог юм байна” гэдгийг харуулсан. Мэдээж анхны жил учраас алдаа оноо байсан ч энэ жил хуримтлуулсан туршлагадаа тулгуурлан илүү сайн ургац авч, Сүхбаатар аймгийн брэнд тарвас бий болгох зорилго тавин ажиллаж байна.

ЗОРИЛТ

БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, ГАЗАР НУТГИЙН НЭГДМЭЛ БАЙДЛЫГ ХАНГАХ

ЦАГААН ЗЭЭРИЙН СУДАЛГАА, АМЬДРАХ ОРЧНЫ ХАМГААЛАЛ



Дорнод Монголын хялганат хээрийн шүхэр зүйл болох цагаан зээр (*Procapra gutturosa*)-ийн цөм амьдрах орчин, нүүдлийн холбоос нутгийг судалгааны мэдээ, баримтад тулгуурлан шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлж, үр дүнд үндэслэн цагаан зээрийн амьдрах орчны хамгаалалд өндөр ач холбогдолтой газруудыг тогтоов. Судалгааны үр дүнгээс үзэхэд Монгол орны зүүн бүс нутагт цагаан зээрийн 65 цөм амьдрах орчин, тэдгээрийг холбосон 157 холбоос нутаг, мөн одоогийн тусгай хамгаалалттай газар нутгуудын хооронд цагаан зээр дамжин өнгөрөх боломжтой 62 холбоос нутаг байгаа нь цагаан зээрийн амьдрах орчны хамгаалал, нүүдлийн хэв маягыг тасархайтуулахгүй байхад анхаарал хандуулах өндөр ач холбогдолтой газрууд болох нь илэрхий байна (Зураг 1).

2024 онд судалгааны болон байгаль хамгааллын байгууллагуудтай хамтран Дорнод Монголын тал хээр, төв, говийн бүсийг хамруулан хийсэн судалгаагаар цагаан зээрийн нийт популяцийн хэмжээг 2,122,700 бодгаль гэж үнэлсэн бөгөөд энэ нь 2020 оны судалгааны дүн болох 1,991,300 бодгалиас 6.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Гэсэн хэдий ч популяцийн бодит өсөлтийг баталгаатай дүгнэхэд шаардлагатай жил бүрийн өсөлт, үхэл хорогдлын мэдээлэл болон газар ашиглалтаас үүдэлтэй амьдрах орчны хомсдолын мэдээлэл хангалтгүй байна. Судалгааны явцад 665 сэг зэм бүртгэгдсэн бөгөөд популяцийн өсөлтийг загварчлан тооцсон тооцооллоор 2024 онд хүрэх боломжтой байсан 2,775,975 бодгальтай харьцуулахад бодит үнэлгээ 653,275 бодгалиар бага гарсан нь 2023–2024 оны зудын нөхцөл байдал популяцид сөргөөр нөлөөлснийг илтгэж байна.

Бүс нутгийн хэмжээнд нэгдсэн аргагүйгээр хийсэн дээрх судалгааны үр дүнгүүдийг Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, төслийн зорилтот 9 сумын нутаг дэвсгэрийн


хөгжлийн төлөвлөгөө, зүүн бүсийн ТХГН-уудын менежментийн төлөвлөгөөнд суурь мэдээлэл болгон ашигласнаар биологийн олон янз байдлыг харгалзсан, хоорондоо уялдаа бүхий газрын нэгдсэн менежментийн төлөвлөлтийн сайн туршлагыг бий болголоо. Мөн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, журам болон бусад орон зайн төлөвлөлтийн баримт бичигт нүүдлийн зэрлэг амьтдын хэрэгцээг уялдуулах боломжийг бүрдүүлсэн нь газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах боломжийг бүрдүүлж байна.

Түүнчлэн одоо байгаа болон ирээдүйд төлөвлөж буй төмөр зам, авто зам зэрэг шугаман дэд бүтэц нь цөм амьдрах орчин, холбоос нутгийг дайран өнгөрөх замаар цагаан зээрийн нүүдлийг тасалдуулах, амьдрах орчныг тасархайтуулах эрсдэлтэй болохыг харгалзан үзэж шугаман дэд бүтцийн бүтээн байгуулалтад зэрлэг амьтанд зориулсан гарц, гарам байгуулах шаардлагатай цэгүүдийг тогтоосон нь зэрлэг амьтанд ээлтэй дэд бүтцийн шийдэл, хамгаалалт ба ашиглалтыг уялдуулсан ландшафтын түвшний төлөвлөлтийн суурь мэдээлэл болж байна (Зураг 2).

Түүнчлэн, авто зам болон газрын мэргэжлийн байгууллагуудын холбооны гишүүн 40 компанийн 44 ажилтан хамрагдаж, зэрлэг амьтанд ээлтэй шугаман дэд бүтцийн төлөвлөлт, нөлөөллийг бууруулах арга хэмжээ, хууль эрх зүйн үндэслэлийн талаар суурь мэдлэг, ур чадвар олгох эзэмшлээ. Сургалтын өмнөх ба дараах үнэлгээний дүнгээс харахад оролцогчдын мэдлэг мэдэгдэхүйц сайжирч, шугаман дэд бүтцийн төлөвлөлтөд амьтны шилжилт хөдөлгөөн, амьдрах орчны холбоос, хамгааллын шаардлагыг тусгах ойлголт нэмэгдсэн байна. Энэ нь дэд бүтцийн салбарын мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлж, байгальд ээлтэй төлөвлөлт, хэрэгжилтийг дэмжих чухал үр дүн боллоо.



Зураг 41.
Цагаан зээрийн
(*Procapra gutturosa*)
цөм амьдрах орчин,
нүүдлийн холбоос
нутаг




ЦЭН ТОГОРУУНЫ СУДАЛГАА, АМЬДРАХ ОРЧНЫ ХАМГААЛАЛ



Судалгааны үр дүнд цэн тогорууны чухал амьдрах орчныг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлж, нэн тэргүүнд хамгаалах шаардлагатай 14 ус намгархаг газрыг тогтоосон. Мөн эдгээр амьдрах орчинд нөлөөлж буй сөрөг хүчин зүйл, эрсдэлийг тодорхойлон, ойр орчмын хүн амын суурьшил, малчин өрхийн байршил, малын нөлөөллийг харгалзсан хамгааллын менежментийн арга барил, шийдлүүдийг гаргасан. Үүний үр дүнд цэн тогорууны амьдрах орчны талаарх мэдлэг, мэдээллийн суурь бэхжиж, хамгааллын арга хэмжээг тохиолдлын шинжтэй бус, зорилтот, нотолгоонд суурилсан байдлаар хэрэгжүүлэх нөхцөл бүрдэв.

Зураг 42.
Санал болгож
буй гарц, гармын
байршил



Мөн авто зам болон газрын мэргэжлийн байгууллагуудын 44 төлөөлөгчийг сургалтад хамруулж, зэрлэг амьтанд ээлтэй шугаман дэд бүтцийн төлөвлөлт, нөлөөллийг бууруулах арга хэмжээ, холбогдох хууль эрх зүйн зохицуулалтын талаар суурь мэдлэг, ур чадвар олгов. Энэ нь дэд бүтцийн салбарын мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлж, байгальд ээлтэй төлөвлөлт, хэрэгжилтийг дэмжихэд чухал хувь нэмэр оруулсан алхам боллоо.

Төслийн хүрээнд нутгийн иргэд болон сумдын Засаг даргын Тамгын газартай хамтран 4 газарт нийт 12.1 га ус намгархаг газрыг хашиж хамгаалав. Ингэхдээ цэвдэгтэй, хөдөлгөөнт орчинд тогтвортой байрших, зөөвөрлөн байршлыг өөрчлөх боломжтой, бат бөх, үер, усны урсгалд саад учруулахгүй, хөрс, усыг бохирдуулахгүй, шувууны үржлийн үед стресс үүсгэхгүй, мал болон бусад зэрлэг амьтанд ээлтэй, гэмтэл учруулахгүй, тэлж өргөтгөх боломжтой зэрэг шаардлагыг харгалзан тухайн ус намгархаг газар бүрийн онцлогт тохирсон хэмжээ, хашааны загварыг гаргаж ашигласан. Энэ нь ус намгархаг газрын хамгаалалд цаашид нэвтрүүлэх боломжтой сайн туршлага болов.

Хамгааллын ажлын үр нөлөө нь мониторингийн дүнгээр мөн баталгаажиж байна. 2021–2025 онд сонгосон 14 газарт хийсэн судалгаагаар цэн тогорууны үржлийн амжилт 63–80 хувийн түвшинд хадгалагдаж, 2025 онд 79.1 хувьд хүрсэн. Үүний зэрэгцээ үржлийн хосын эзлэх хувь 2021 онд 38.5 хувь байсан бол 2024 онд 65.7 хувь хүртэл өссөн нь хамгаалалтын арга хэмжээ, амьдрах орчин тайван болж нөхцөл байдал сайжирсантай холбоотой эерэг өөрчлөлт гэж үзэх үндэслэлтэй байна.


Түүнчлэн цэн тогорууны хамгааллыг зөвхөн зүйл төвтэй хандлагаар бус, амьдрах орчны хамгаалал, орон нутгийн иргэдийн оролцоо, менежментийн оновчтой шийдэлтэй уялдуулан хэрэгжүүлэх загвар бүрдсэн нь төслийн чухал үр дүнгийн нэг боллоо.

Зураг 43.
Хэнтий аймгийн
Норовлин сумын
Тогоруут нуур



2022 онд үржлийн 2 хос байсан ба үржлийн амжилт 75%, 2025 онд үржлийн 4 хос бүртгэгдэж, үржлийн амжилт 62.5% байв.

Зураг 44.
Хэнтий аймгийн
Баян-Овоо сум,
Хулст нуур, шувуу
ажиглах цамхаг



2022 онд хашааг өргөтгөсөн бөгөөд нуурын усны түвшин, усны шувуудын зүйлийн тоо нэмэгдсэн. Энд цэн тогорууны үржлийн нэг хос байх бөгөөд 2021-2022 онд үржлийн амжилт 50% байсан бол 2023-2025 онд 100% байлаа.

Сүүлийн жилүүдэд шувуу ажиглагчдын тоо нэмэгдэж, үүнтэй уялдан Хар ямаатын БНГ-ын менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу 2025 онд Хэнтий аймгийн Байгаль орчны газрын санаачилга, Баян-Овоо сумын ЗДТГ-ын санхүүжилтээр шувуу ажиглах цамхаг байгууллаа.

Зураг 45.
Дорнод аймгийн
Булган сум,
Энхзуслан



Улз голын эх байгалийн нөөц газрын хүлэрт намгийн эмзэг экосистем хамгаалах зорилгоор Улз голын дөрвөн эхэн булгийг хашаажуулж, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэв. Энэ ажлыг Онон-Улз голын сав газрын захиргаа, Хэнтий аймгийн Байгаль орчны газар, Норовлин сумын удирдлага, нутгийн малчидтай хамтран хэрэгжүүлсэн. Хашааг хүлэрт намгархаг хөрсний онцлогт нийцүүлэн, хөрсийг гэмтээхгүй, улирлын хөлдөлт, гэсэлтэд тохирсон, буриад зоны уламжлалт арга технологид тулгуурласан шийдлээр нийсэн нь хамгааллын арга хэмжээг экосистемийн онцлогт нийцүүлэн, уламжлалт арга технологийг ашиглан хэрэгжүүлсэн сайн туршлага болов.

Улз голын эхэн булгийг хашиж, хамгаалсан байдал



БАЙГАЛИЙН НӨӨЦ ГАЗРЫН МЕНЕЖМЕНТ

Хуулийн дагуу байгалийн нөөц газар, дурсгалт газрын хамгааллын менежментийг орон нутгийн удирдлага хариуцдаг боловч санхүүжилт, хүний нөөц, аймаг хоорондын зохицуулалтын сул байдлаас шалтгаалан хэрэгжилт олон газарт хангалтгүй хэвээр байв. Төслийн хүрээнд энэ асуудалд бодит шийдлийн хувилбар боловсруулж, байгалийн нөөц газар (БНГ)-ын менежментийг орон нутгийн удирдлага манлайлан, олон талын оролцоонд тулгуурлан хэрэгжүүлэх загварыг бүрдүүллээ. Ингэснээр өмнө нь эрх зүйн статустай боловч газар дээрх менежмент сул байсан БНГ-уудыг илүү нэгдсэн зохион байгуулалт, хариуцлага, хэрэгжилттэй хамгаалалтын тогтолцоонд шилжүүлэх суурь тавигдав.

Үүний хүрээнд хоёр аймаг дамнан орших БНГ-уудын нэгдсэн удирдлагын механизмыг бий болгож, менежментийн хариуцлагыг тодорхой болгосон нь чухал үр дүн болов. Тухайлбал, Харямаатын БНГ-ын хувьд Хэнтий, Сүхбаатар аймгуудын Засаг дарга нар болон Байгаль орчны газар (БОГ)-уудын хооронд байгуулсан хамтын ажиллагааны гэрээний дагуу нэгдсэн удирдлагыг Хэнтий аймгийн БОГ хариуцахаар зохицуулж, тус газрын дэргэд Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн хэлтэс байгуулан хүний нөөцийг бүрдүүлсэн. Харин Тосонхулстайн БНГ-ын хувьд Дорнод, Хэнтий аймгийн удирдлагуудын тохиролцоогоор Дорнод аймагт байрлах Байгаль хамгаалалтын захиргаа (2020 онд байгуулагдсан) ерөнхий зохицуулалтыг хариуцахаар шийдвэрлэснээр засаг захиргааны нэгжээс шалтгаалсан салангид менежментийг нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хэрэгжүүлэх суурь бүрдэв. Мөн Хэнтий аймагт байгуулагдсан хэлтэс болон Дорнод аймаг дахь Байгаль хамгаалалтын захиргааны чиг үүрэг тодорхой болсноор байгалийн нөөц газар, дурсгалт газар, орон нутгийн хамгаалалттай газрын менежментийг аймгийн түвшинд илүү нэгдмэл, тогтвортой зохион байгуулах боломж бүрдэж байна.

Мөн орон нутгийн түвшинд БНГ-ын менежментийг санхүүжүүлэх, хэрэгжүүлэх бодит боломж нээгдсэн нь энэхүү загварын чухал үр дүн байлаа. Төслийн хүрээнд 2025-2034 онд хэрэгжих БНГ-уудын менежментийн төлөвлөгөөг холбогдох талуудтай хамтран боловсруулж, батлуулан хэрэгжүүлж эхэлснээр менежментийг бодлогын болон хэрэгжилтийн түвшинд баталгаажуулав. Үүний зэрэгцээ аймаг, сумын орон нутгийн төсөв, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого, байгаль хамгаалах сан, түнш байгууллагын дэмжлэгийг менежментийн төлөвлөгөөний хэрэгжилттэй уялдуулснаар байгаль хамгаалагчдыг томилж ажиллуулах, нөхөн

сэргээлт хийх, шувуу ажиглах цамхаг байгуулах, тарвага сэргээн нутагшуулах, аяллын маршрутын дагуух отог, түр байрлах цэгийг тохижуулах зэрэг тодорхой арга хэмжээг хэрэгжүүлж эхлээд байна. Мөн БНГ дахь бэлчээр болон бусад байгалийн нөөцийн ашиглалтыг БНГ-уудын болон сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөө, бэлчээр ашиглалтыг зохицуулах журам, БНГ-ын хамгаалалтын горимтой уялдуулан гаргаж сумдын Засаг даргын Тамгын газар, нутгийн иргэдийн оролцоотой хэрэгжүүлж байна. Ийнхүү орон нутагт байгаль орчны бодлогыг зангидаж буй байгууллага менежментийг хариуцсанаар судалгааны байгууллага, их, дээд сургууль, байгаль хамгааллын байгууллага, төрийн байгууллага, орон нутгийн засаг захиргаа, нутгийн иргэд, хувийн хэвшлийн оролцоог илүү үр дүнтэй уялдуулах боломжтой байгаа бөгөөд шинжлэх ухаанд суурилсан төлөвлөлт, хамтын шийдвэр гаргалт, бодит хэрэгжилтийн тогтолцоог бий болгох нөхцөл бүрдсэн. Ингэснээр БНГ-ын менежментийг зөвхөн төслийн санхүүжилтээс хамаарах бус, орон нутгийн эх үүсвэр, талуудын хамтын ажиллагаанд тулгуурлан тогтвортой үргэлжлүүлэх боломжтойг харууллаа. Орон нутгийн удирдлагаар манлайлуулсан энэхүү хамтын менежментийн загвар нь БНГ-уудыг менежмент сул статусаас бодитоор удирддаг, санхүүждэг, хэрэгждэг хамгаалалтын тогтолцоо болгон хөгжүүлэх боломжтойг нотолсон чухал үр дүн болов.

**ТУСГАЙ
ХАМГААЛАЛТАЙ
ГАЗАР НУТГИЙН
МЕНЕЖМЕНТИЙН
АРГА, АРГАЧЛАЛ**



Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн үр ашигт байдлын үнэлгээний арга зүйг шинэчлэх, туршихажлыг холбогдох төрийн болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран хийлээ. Энэ хүрээнд 2018 оны аргачлалыг олон улсын түвшинд хийгдсэн шинэчлэл, Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний хөгжлийн хэрэгцээ, эрх зүйн орчин, менежментийн өнөөгийн нөхцөлтэй уялдуулан боловсронгуй болгосон. Шинэчилсэн аргачлалыг экосистемийн онцлог болон хамгааллын дэглэмээрээ ялгаатай тусгай хамгаалалттай газар нутгуудад туршин, үндэсний хэмжээнд хэрэгжих боломжийг баталгаажуулсан бөгөөд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн А/469 тоот тушаалаар батлагдсан ба үндэсний хэмжээнд албан ёсоор ашиглаж эхлээд байна. Мөн төслийн хүрээнд хөгжүүлсэн цахим мэдээллийн сан нь үнэлгээний үр дүнг нэгтгэх, өөрчлөлтийг хянах, харьцуулсан дүн шинжилгээ хийх, улмаар бодлого, төлөвлөлт, менежментийн шийдвэрийг нотолгоонд суурилан гаргахад дэмжлэг үзүүлэх юм.

Биологийн олон янз байдлын мониторинг, судалгааны мэдээллийг илүү үр дүнтэй цуглуулах, нэгтгэн боловсруулах, ашиглах боломжийг сайжруулах зорилгоор “БИОСАН” үндэсний мэдээллийн сангийн вебсайт болон гар утасны аппликейшны шинэчлэгдсэн хувилбарыг хөгжүүлж, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд хүлээлгэн өглөө. Шинэ хувилбар нь байгаль хамгаалагч, мэргэжилтнүүдийн судалгааны ажлыг хөнгөвчилж, мониторингийн мэдээллийн чанар, хүртээмжийг сайжруулснаараа онцлог юм. Системд автомат камерын

мониторингийн арга зүйг нэмж хөгжүүлснээр зэрлэг амьтдын тоо толгой, тархалт, шилжилт хөдөлгөөний талаар илүү нарийвчилсан мэдээлэл цуглуулах боломж бүрдсэн. Түүнчлэн, байгаль хамгаалагчид судалгааны мэдээллээ талбай дээрээс гар утасны аппликейшнаас шууд илгээх, байршлын мэдээллээ дамжуулах, ажлын явцыг хянах боломжтой болсон нь ажлын үр дүн төдийгүй, байгаль хамгаалагчийн аюулгүй байдлыг хангахад чухал дэмжлэг болж байна.

**ЧАДАВХ
БЭХЖҮҮЛЭХ АРГА
ХЭМЖЭЭ**



Арга аргачлал боловсруулах, сайжруулахын зэрэгцээ тэдгээрийг ашиглах чадавхийг бэхжүүлэх зорилгоор шат дараалсан сургалтуудыг зохион байгууллаа. Үүний хүрээнд биологийн олон янз байдлын судалгааны арга зүй, БИОСАН, хяналт-шалгалтын төлөвлөлт, хэрэгжилт (SMART), мэдээлэл, сурталчилгааны арга зүй, хээрийн аюулгүй ажиллагаа, ёс зүйн чиглэлээр тусгай хамгаалалттай газар нутгийн болон аймаг, сумдын байгаль хамгаалагч, мэргэжилтнүүдэд зориулсан нийт 44 удаагийн сургалтаар давхардсан тоогоор 600-аад хүнийг сургалтад хамруулж чадавхжууллаа. Мөн цаашдын тогтвортой байдлыг хангах зорилгоор байгаль хамгааллын төлөвлөлтийн арга зүйн сургагч багшаар 18, SMART - хяналт-мониторингийн арга зүйн сургагч багшаар 10 хүнийг сургаж чадавхжуулсан.



“Байгалиа хамгаална гэдэг миний амьдралын утга учир болсон”



З.Гэрэлчимэг
Сүхбаатар
аймгийн
Мөнххаан сумын
ЗДТГ-ын Байгаль
орчны хяналтын
улсын байцаагч

Би Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын унаган хүн. Миний үндсэн мэргэжил газар зохион байгуулалтын инженер. Анх сургуулиа төгсөөд нутагтаа ирэхэд миний мэргэжлийн орон тоо байгаагүй. Тэгээд сул байсан байгаль хамгаалагчийн орон тоон дээр орж байлаа. Ажилд орохдоо байгаль хамгаалагч гэж ямар ажил хийдгийг, ажлынхаа үндсэн чиг үүргээ юу ч мэдэхгүй орж байсан. Ердөө удалгүй л түймрийн дуудлага авч, шууд хөдөө явж билээ. Ер нь манай мэргэжлийн нэг онцлог бол хөдөө маш их явдаг. Надад итгэл хүлээлгээд ажилд авсан учир ямар ч байсан энэ ажлаа хийж сурахын төлөө хичээж явсаар нэг мэдсэн 13 жил болж. Одоо бол энэ ажилдаа хайртай. Илүү их суралцаж, мэргэшихийн төлөө ажиллаж байна.

Миний хариуцдаг нутаг дэвсгэр 741 мянга гаруй га талбайтай. Аймгийнхаа хэмжээнд нэлээд том нутагт тооцогддог. Ийм өргөн уудам газарт хяналт тавина гэдэг дан ганц явж харахаас илүү нарийн төлөвлөлт, мэдээлэл шаарддаг. Би газар зохион байгуулалтын инженер мэргэжилтэй учраас хөдөөнөөс авсан координат мэдээллийг газрын зураг дээр буулгаж, тарвага, аргаль хонь, цагаан зээр хаана байна, уул уурхайн үйл ажиллагаа хаагуур явагдаж байгаа зэрэг бүх мэдээллийг цэгэн зураглал болгон тэмдэглэдэг. Хүн асуухад аль цэгт ямар амьтан байна, аль бүсэд ямар асуудал үүсэж байгааг газрын зураг дээрээс шууд харуулж тайлбарлах боломжтой байдаг нь миний давуу тал гэж боддог.

Би 2011 онд Хөдөө аж ахуйн их сургуулийг Газрын зохион байгуулалтын инженер мэргэжлээр, 2017 онд “Хүрээлэн буй орчин судлал”-ын магистр зэрэгтэй төгссөн. Сурсан мэдсэнээ зүгээр нэг онол болгож үлдээх биш, нутагтаа хэрэгжүүлж ажиллахыг үргэлж хичээж ирсэн. Энэ хугацаанд аргаль хонинд биотехникийн арга хэмжээ авах, ховор ургамал, амьтдын судалгаа хийх, хууль бус ашигт малтмалын хайгуул, байгальд халтай үйл ажиллагааг таслан зогсоох гээд олон ажилд гар бие оролцсон.

Дорнод хээрийн төсөлтэй хамтарч нэлээд олон ажлыг хийсэн. Үүнээс хамгийн сэтгэлд үлдсэн нь ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор засмал зам дагуух ойн зурваст 1000 ширхэг улиас мод тарьж, 100 хувь ургуулж чадсан явдал. Мөн цагаан зээр, бөхөнгийн судалгааны сургалтуудад хамрагдаж, бүс нутаг хоорондын туршлагаас суралцсан нь миний ажлын арга барилд их тус болсон.

Сүүлийн жилүүдэд Баянцагаан талын байгалийн нөөц газарт отрын айлууд зөвшөөрөлгүй олноор нутаглаж, бэлчээр доройтож, цагаан зээрийн амьдрах орчин багассан нь сэтгэл өвтгөсөн асуудал байлаа. Ойрын таван жилд цагаан зээр бараг орж ирээгүй. Энэ асуудлыг зүгээр хараад суух боломжгүй байсан учраас иргэдтэй ярилцаж, хамгаалалтын горим тогтоох сонсох ажиллагааг Дорнод хээрийн төслийн нэгжтэй хамтран зохион байгуулсан. Иргэд маань ч ойлгож, дэмжиж хамтарч ажилласан. Үүний үр дүнд 2026 онд Баянцагаан талын байгалийн нөөц газрын хамгаалалтын горим, дотоод бүсчлэл Сүхбаатар аймгийн ИТХ-ын ээлжит 10 дугаар хуралдаанаар албан ёсоор батлагдсан сайхан мэдээг дуулгах боломж бүрдсэн.

Бэлчээрийн менежментийг сайжруулах зорилгоор өнжөөж сэлгэх, ашиглалтаас чөлөөлөх, хортон мэрэгчидтэй тэмцэх арга хэмжээг сумын Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгуулан хэрэгжүүлж байна. Газрын доройтлыг бууруулахын тулд орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрөөр нийт зургаан булаг, шандын эхийг хашиж хамгаалсан. Мөн байгалийн нөөц газар, хадлан тэжээл, отрын зориулалтаар нийт 10 гаруй байршилд 290 мянга гаруй га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авах суурь судалгааг хийж, сумын ИТХ-ын тогтоолоор батлуулан ашигт малтмал газрын тосны кадастрт бүртгүүлсэн нь бэлчээрийн тогтвортой ашиглалтыг хангах бодит алхам болсон юм.

Байгаль орчны ажлыг зөвхөн хяналт шалгалт гэж ойлгодог хүмүүс бий. Миний хувьд энэ ажил бол иргэдийн ойлголт, хандлагыг өөрчлөх, хамтдаа хамгаалж сурах урт хугацааны үйл явц гэж боддог. Тиймээс Дэлхийн ой, Усны өдөр, Биологийн төрөл зүйлийг хамгаалах өдөр зэрэг тэмдэглэлт өдрүүдийг сүүлийн жилүүдэд цахимаар зохион байгуулж, олон нийтэд экологийн боловсрол олгоход анхаарч байна. Байгаль хамгаалагчийн ажил заримдаа ганцаардмал, заримдаа хүндхэн санагддаг. Гэхдээ хамгаалалтын горим батлагдаж, амьтан ургамал эргэн нутагшиж байгааг харах мөч бүхнийг мартуулдаг. Байгалиа хамгаална гэдэг миний хувьд зүгээр нэг ажил биш, амьдралын минь утга учир юм.

БАЙГАЛИЙН НӨӨЦ ГАЗАРТ ТҮШИГЛЭСЭН ЗӨГИЙН БАЛНЫ ӨРТГИЙН СҮЛЖЭЭ

Сүхбаатар аймгийн Түмэнцогт, Хэнтий аймгийн Баян-Овоо сумын 4-5 өрх Хар ямаатын ТХГН-т тус бүр 5-20 зөгийн бүлтэй, бага хэмжээний бал өрхийн хэмжээнд үйлдвэрлэж, орон нутагтаа борлуулж байсан. Зөгийн бүл цөөн, материаллаг бааз (өвөлжөө, бэлчээрлэх талбай), арчилгаа маллагааны чадавх сул байсан.

Төслөөс зарласан Эко-бизнесийн грант-уралдаанд шалгарч Түмэнцогт, Баян-Овоо сумын зөгийчид шалгарч дэмжлэг авч Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын залуу зөгийчин Түвшинбаярын удирдсан ТББ зөгий аж ахуйн сургалтын төвийг байгуулсан. Төслийн дэмжлэгтэйгээр Зөгийн маллагаа, технологиор мэргэшсэн зөвлөхөөр тус хоршооны гишүүдэд танхим, дадлага хосолсон сургалт зохион байгуулсан.

Сургалт, дадлагын төвүүд нь төслийн үр дүнг тогтвортой хадгалж, байгаль хамгааллын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, нөхөн сэргээгдэх хөдөө аж ахуйн арга практикийг өргөжүүлэх, нүүрстөрөгч болон ногоон санхүүжилтэд хандах боломжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ “Хар ямаат” брэндийн зөгийн балны нэр хүндийг өргөжүүлэхэд чиглэж байна.

Зураг 46.

Хар ямаатын зөгийн аж ахуйн үйл ажиллагаа



Зөгийн үүрний тавцанг өндөрсгөх, талбайн аюулгүй байдлыг сайжруулах, хяналт мониторинг хийх зэрэг арга хэмжээнүүд нь зөгийн бүлийн эрүүл мэнд, бүтээмжийг дээшлүүлсэн.

Төслөөс стандарт сав баглаа боодол, шошгололтыг нэвтрүүлснээр бүтээгдэхүүний чанар, зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлсэн. Хар ямаатын зөгийчид ТББ-ын үйл ажиллагааг нийтэд сурталчлах видео танилцуулгыг бэлтгэн, түгээх ажил хийгдсэн.

2025 онд “Хар ямаат” зөгийн бал Сүхбаатар аймгийн үзэсгэлэнд импорт орлох бүтээгдэхүүнээр шалгарсан. 2025 оны арваннэгдүгээр сард зохион байгуулагдсан “Монголын зөгийн бал экспортын кластер”-ын зөвлөлдөх уулзалтад тус хоршоо Зүүн бүсийг төлөөлөн оролцож, Зүүн бүсийн зөгийчдийн сургалтын төвөөр томилогдсон. 2026 онд “Хар

ямаат” БНГ-т үндэсний зөгийчдийн кластерын уулзалт, сургалтын аяллыг зохион байгуулах үүрэг хүлээсэн.

Эхний үйлдвэрлэлийн мөчлөгт нийт 125 кг зөгийн бал хураан авч, 3.75 сая төгрөгийн борлуулалтын орлого олсон нь экосистемд суурилсан зөгий аж ахуй орлогын өндөр боломжтойг баталсан.

“Хар ямаат”-ын туршлага нь төслийн дэмжлэг хэрхэн шинэ орлого бий болгож, тогтвортой байдлыг нэмэгдүүлж, байгальд суурилсан амьжиргааг дэмжих боломжтойг харуулсан **загвар** болж байна.

Зураг 47.
Хар ямаатын зөгийн балны шошго, савлагаа



Хэрэглэгчид “Хар ямаат” гэсэн шошгыг хараад гарал үүсэл, чанарт нь итгэдэг болсон



Э.Түвшинбаяр
Сүхбаатар аймаг, Түмэнцогт сум, Хар ямаат зөгийчдийн холбооны тэргүүн

Бидний ажлыг сонирхож, амжилтын түүхийг маань хуваалцах боломж олгож байгаад баярлалаа. Манай холбоо 2021 онд албан ёсоор байгуулагдсан ч үүнээс өмнө зөгийчид маань өрхийн хэмжээнд, дор бүрнээ хөдөлмөрлөж ирсэн. Хичээл зүтгэл их байсан ч нэгдсэн зохион байгуулалт, стандарт, зах зээлийн бодлого дутмаг учраас жинхэнэ утгаараа хөгжих боломж хязгаарлагдмал байлаа.

Харин “Дорнод монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янз байдлыг хамгаалах” төсөлтэй хамтарснаар бидний хувьд бодит өөрчлөлт, бодит ахиц гарч эхэлсэн. Энэ төслийн дэмжлэг зөвхөн санхүүжилт биш, харин чиглэл, итгэл, хамтын ажиллагааны соёлыг авчирсан гэж би хэлнэ.

Төслөөс нийт 39 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлснээр бид зөгий өвөлжүүлэх зоорио бүрэн засварлаж, сургалтын танхимаа иж бүрэн тохижуулсан. Ингэснээр зөгийчид маань жилийн дөрвөн улиралд тогтвортой ажиллах, мэдлэгээ дээшлүүлэх, туршлага солилцох орчин бүрдсэн. Өмнө нь улирлын чанартай, тархай бутархай ажилладаг байсан бол одоо тогтолцоотой, төлөвлөгөөтэй ажилладаг болсон.

Төслийн хүрээнд бид зөгийн бүлийнхээ тоог нэмэгдүүлж 60 бүл зөгийтэй болсон нь үйлдвэрлэлийн хэмжээг бодитоор өсгөсөн. Үүнээс ч илүү чухал нь бид сав баглаа боодлын нэгдсэн стандартад шилжсэн. Өмнө нь хүн бүр өөр өөр савлагаатай, шошгогүй борлуулалт хийдэг байсан бол одоо “Хар ямаат” брэнд жигд өнгө төрхтэй, баталгаатай бүтээгдэхүүн болж чадсан. Энэ өөрчлөлт л биднийг дараагийн шатанд гаргасан.

Өмнө нь Сүхбаатар аймгийн зөгийн бал чанартай ч зах зээлд танигдаагүй, томоохон дэлгүүрийн лангуунд гарах боломжгүй байсан. Харин одоо хэрэглэгчид “Хар ямаат” гэсэн шошгыг хараад гарал үүсэл, чанарт нь итгэдэг болсон. Энэ бол төслийн хүрээнд бий болсон бодит үр дүн.

2025 онд Сүхбаатар аймагт зохион байгуулагдсан “Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдаанд оролцож “Импортыг орлох бүтээгдэхүүн” номинацын шилдгээр шалгарсан. Энэ амжилт бол төслийн дэмжлэгээр бий болсон стандарт, чанар, хамтын

ажиллагааны үр дүн гэдгийг онцлон хэлмээр байна. Өрхийн аж ахуйгаас холбоо, холбооноос брэнд, брэндээс зах зээлийн өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн болсон замнал маань тус төслийн үр шимтэй шууд холбоотой.

Мөн төслийн хүрээнд бид зөвхөн үйлдвэрлэлээ нэмэгдүүлээд зогсохгүй, ирээдүйн хөгжлийн сууриа тавьж чадсан. Жижиглэнгийн болон нэг удаагийн савлагаа нэвтрүүлэх, аялал жуулчлал, зочид буудал, зоогийн салбарт нийлүүлэх бэлтгэл ажлууд эхэлсэн. Энэ бол зах зээлийн шинэ шат, шинэ эргэлт.

Цаашлаад бид Зүүн бүсийн кластер болох зорилт тавин ажиллаж байна. Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн зөгийчдийг нэгтгэж, бүсийн хэмжээнд нэгдсэн сүлжээ бий болгох нь төслийн маань хөгжлийн дараагийн шат юм. Зүүн бүс нутаг бол өвөрмөц ургамалтай, зөгийн аж ахуй хөгжих асар их нөөцтэй. Бид хүчээ нэгтгэж байж л экспортод гарах, дотоодын зах зээлээ бүрэн хангах боломжтой болно.

Мөн бид Монголд анх удаа 2026 онд “Хар ямаат зөгийн фестиваль”-ийг зохион байгуулахаар төлөвлөж байгаа нь төслийн хүрээнд бий болсон чадавх, зохион байгуулалтын үр дүн гэж хэлж болно. Энэ нь зөгийн аж ахуйн ач холбогдлыг сурталчлах, эко аялал жуулчлалыг хөгжүүлэх, бүс нутгийн эдийн засагт хувь нэмэр оруулах томоохон алхам болно.

Өнөөдөр бид амжилттай, тогтвортой ажиллаж байгаагаа бардам хэлж чадна. Учир нь бид зүгээр нэг бал үйлдвэрлэдэг биш — стандарттай, нэгдсэн зохион байгуулалттай, цаашдын тодорхой зорилготой хамт олон болсон. Төслийн хүрээнд авсан дэмжлэгийг бид зөв ашиглаж, бодит үр дүнд хүргэж чадсан нь бидний хамгийн том ололт юм.

Бидний дараагийн зорилго бол Сүхбаатар аймгаас хальж, Монголын зөгийн балыг олон улсад таниулахад оршиж байна. Төслийн эхлүүлсэн энэ амжилтын замналыг бид улам бататгаж, илүү том түвшинд гаргахын төлөө тууштай ажиллах болно.

УРГАМАЛЖЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН



Төслийн хүрээнд 2022-2025 онд Дорнод Монголын хээрийн бүсэд орших Баянцагааны тал, Жаран тогооны тал, Тосон хулстай, Хар ямаат, Мэнэнгийн цагаан хоолой зэрэг БНГ-т ургамалжлын судалгааг МУИС, ХААИС, МУБИС, МУИС-ын Баруун бүсийн сургууль, ХААИС-ийн Дархан уул аймаг дахь Агроэкологи бизнесийн сургууль ШУА-ын Биологийн хүрээлэнгийн судлаачидтай хамтран хийлээ. Судалгааны ажлын зорилго нь хээрийн экосистемийн төлөв байдал, ургамлын олон янз байдал, бэлчээрийн даац, доройтлын өөрчлөлтийг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоож, хамгаалалт, зохистой ашиглалтын шийдвэр гаргах суурь мэдээлэл бүрдүүлэхэд чиглэв.

Судалгааны хугацаанд нийт 271 ургамалжлын бичиглэл, 1200 орчим ургамлын биомассын дээж, 1000 гаруй гэрэл зураг, 400 гаруй ургамлын хатаадас цуглуулж, хээрийн экосистемийн төлөв байдлыг илэрхийлэх өргөн хэмжээний мэдээллийн сан бүрдүүлсэн. Судалгааны үр дүнд нийт 42 овгийн 160 төрөлд хамаарах 273 зүйл гуурст ургамал бүртгэгдсэн байна. Үүнээс хамгийн олон зүйлтэй овогт Нийлмэл цэцэгтэн (48 зүйл), Буурцагтан (28 зүйл), Үетэн (26 зүйл), Сарнайтан (24 зүйл) багтаж, эдгээр нь нийт бүртгэгдсэн ургамлын 58.9 хувийг бүрдүүлжээ. Мөн Монгол орны хэмжээнд хамгааллын ач холбогдолтой 7 зүйл ургамал бүртгэгдсэн бөгөөд үүнд устаж болзошгүй 1 зүйл, эмзэг 2 зүйл, ховордож болзошгүй 4 зүйл багтаж байна.

Судалгааны талбайнуудад 100 м² талбайд дунджаар 20–41 зүйл ургамал, ургамлын нийт бүрхэц 57–77%, ургамлын биомасс 43–170 г/м² хооронд хэлбэлзэж байгааг тогтоосон. Энэ нь зарим бүс нутагт хээрийн ургамалжил, бэлчээрийн нөөц харьцангуй тогтвортой байгааг харуулж байгаа боловч зарим талбайд доройтлын шинж мөн ажиглагдсан.



Судалгааны гол ач холбогдол нь үр дүнг бодит шийдвэр гаргалтад ашиглагдаж эхэлсэн явдал юм. Судалгааны үр дүнг хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө боловсруулах, мөн бэлчээр ашиглах хуваарь гаргах суурь мэдээлэл болгон ашигласнаар байгаль хамгаалал, газрын зохистой ашиглалтын арга хэмжээг судалгаанд тулгуурлан төлөвлөх боломж бүрдэв.

Төсөл нь хүний нөөц бэлтгэх, орон нутгийн оролцоог нэмэгдүүлэхэд мөн чухал хувь нэмэр оруулсан. Судалгааны 4 жилд давхардсан тоогоор доктор, магистр, бакалаврын түвшний 60 гаруй оюутан, 20-иод багш, судлаачид хээрийн судалгаанд оролцсоны дотроос 1 доктор, 15 магистр, 11 оюутан бакалаврын зэргээ амжилттай хамгаалсан байна. Үүний зэрэгцээ “судлаач сурагч”, “судлаач оюутан” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр хүүхэд, залуус байгаль орчноо танин мэдэх, судалгааны арга барилд суралцах, байгаль хамгааллын ач холбогдлыг илүү гүнзгий ойлгох боломж бүрдсэн. Үүнээс гадна нутгийн иргэд, байгаль хамгаалагчид, тусгай хамгаалалттай газар нутгийн ажилтнуудыг хамруулсан сургалт, чадавхжуулах ажлыг зохион байгуулж, нийт 100 гаруй хүнийг сургаж чадавхжуулсан. Ингэснээр орон нутагт байгаль хамгааллын мэдлэг нэмэгдэж, хээрийн ажиглалт, судалгааны мэдээллийг ашиглах чадвар бэхэжсэн байна.

Төслийн хүрээнд хэрэгжүүлсэн судалгааны ажил нь Дорнод Монголын хээрийн экосистемийн талаарх суурь мэдээллийг баяжуулаад зогсохгүй, тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент, бэлчээрийн зохистой ашиглалт, хүний нөөцийн чадавх, орон нутгийн оролцоог бэхжүүлсэн үр дүнтэй ажил болжээ.



БАЙГАЛЬ ХАМГААЛЛЫН БОЛОВСРОЛ – МЭДЛЭГЭЭС ҮЙЛДЭЛД

Байгаль хамгааллын бодит үр дүн нь дан ганц хамгаалалтын арга хэмжээ, дэд бүтэц, зохицуулалтаар хязгаарлагдахгүй бөгөөд түүний урт хугацааны үр нөлөө нь хүмүүсийн мэдлэг, хандлага, өдөр тутмын дадалтай шууд холбоотой. Иймээс төслийн хүрээнд олон нийтийн байгаль орчны мэдлэг, боловсролыг нэмэгдүүлэх, оролцоог дэмжих, байгаль хамгаалах сэдлийг төлөвшүүлэхэд онцгой анхаарч ажиллав. Энэ хүрээнд сургалт, мэдээллийн үйл ажиллагааг сургуулийн сурагчид, мэргэжлийн чиглэлээр суралцаж буй оюутнууд, нутгийн иргэд, иргэдийн бүлэг, нөхөрлөл, төр захиргааны байгууллагын ажилтнууд зэрэг олон талт зорилтот бүлгүүдэд чиглүүлэн үе шаттай хэрэгжүүлээ. Ингэснээр ялангуяа, нүүдлийн зүйл амьтад, тэдгээрийн амьдрах орчин, биологийн олон янз байдлын үнэ цэнийг таниулахаас гадна байгаль хамгааллыг хамтын оролцоо, хариуцлагад тулгуурлан хэрэгжүүлэх нийтлэг ойлголтыг бэхжүүлэхийг зорьсон.

Байгаль орчны мэдлэгийг түгээх, сургалт зохион байгуулах, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх боломжийг сайжруулах зорилгоор аймгийн байгаль орчны газар, ерөнхий боловсролын сургуулийн биологийн танхим, Хар ямаатын байгалийн нөөц газрын мэдээллийн төв, Хэнтий аймгийн Баян-Адарга сум дахь "Нүүдлийн өв соёл, экологийн сургалтын төв"-ийн тохижилтод дэмжлэг үзүүлсэн. Ингэснээр байгаль орчны боловсрол, мэдээлэл түгээх, дадал олгох сургалтыг тогтмол зохион байгуулах нөхцөл бүрдэж, зүүн бүсийн хэмжээнд харилцан уялдаа бүхий хамтын ажиллагааны сүлжээ төлөвшин бэхжихэд хувь нэмэр оруулав.



➤ Төслийн зорилтот сумдын ерөнхий боловсролын сургуулиудад экобулан байгуулахад дэмжлэг үзүүлсэн. Үүний үр дүнд 7-12 дугаар ангийн сурагчид байгаль орчин, биологи, экологийн суурь мэдлэгээ нэмэгдүүлэх илүү таатай орчинтой болж, тогтмол авч, мэдлэгээ баяжуулах боломжтой болсон. Түүнчлэн сурагчдын идэвх санаачилгад тулгуурласан байгаль орчны сэдэвт арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэнээр сургуулийн орчин дахь байгаль орчны боловсролын хүртээмж сайжирч, тогтвортой үргэлжлэх суурь бэхэжлээ.

Зураг 48.
Баян-Адарга,
Хөлөнбуйр сумын
экобулан



Зураг 49.
Түмэнцогт сумын
биологийн тэнхим,
Матад сумын
экобулан



➤ Цагаан зээрийн гол төллөх нутаг, нүүдлийн зам, холбоос нутгууд болох улсын тусгай хамгаалалттай 6 байгалийн нөөц газрын менежментийг сайжруулах, тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд орон нутгийн хамгаалалтын захиргаатай хамтран ажиллах, тэдний цаашдын тогтвортой үйл ажиллагааг дэмжих нэг ажил нь мэдээллийн төвийг тохижуулах ажил байлаа. БОГ-ууд мэдээллийн төвийн чанар хүртээмж сайжирснаар зөвхөн сургалтын үйл ажиллагааны чанар хүртээмж сайжирснаас гадна тогтмол хэрэгжих, сургалтуудын тоо, төрөл нэмэгдсэн. Дорнод аймгийн жишээгээр 2025 онд 70 Гаруй төрлийн сургалтад 1000 гаруй хүн мэдээллийн төвөөр үйлчлүүлсэн байна. Мөн Хар ямаатын БНГ-ын мэдээллийн төвийг тохижуулснаар орон нутагт ажиллаж буй байгаль хамгаалагчид төдийгүй орон нутгийн иргэд тогтмол байгаль орчны мэдээллээр хангагдах, сургалт, дадал олгох үйл ажиллагаа зохион байгуулах нөхцөл бүрдсэн.

Зураг 50.
Хар ямаатын
БНГ-ын
мэдээллийн төв



- ▶ Байгалийн нөөц газрын менежментийг сайжруулах зорилгоор Хэнтий аймгийн Байгаль орчны газар, Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газартай хамтран Хар ямаатын байгалийн нөөц газрын мэдээллийн төвийг тохижуулсан. Ингэснээр мэдээллийн төвийн чанар, хүртээмж сайжирч, сургалт, сурталчилгааны ажлын чанар дээшлэхийн зэрэгцээ тогтмол зохион байгуулагдах сургалтын тоо, төрөл нэмэгдэх нөхцөл бүрдсэн. Мөн байгаль хамгаалагчид болон орон нутгийн иргэд байгаль орчны мэдээллийг байнга авах, сургалт, дадал олгох үйл ажиллагаанд хамрагдах боломж нэмэгдлээ.
- ▶ Хэнтий аймгийн Баян-Адрага суманд хувийн хэвшлийн санаачилгаар байгуулагдсан “Нүүдлийн өв соёл, экологийн сургалтын төв”-ийн тохижилтод дэмжлэг үзүүлэв. Ингэснээр уламжлалт мэдлэг, байгаль хамгаалах өвийг ирээдүй хойч үед өвлүүлэхэд чиглэсэн орон нутгийн иргэдийн санаачилга тогтвортой хэрэгжих нөхцөл бүрдсэн.



БАЙГАЛЬ ХАМГААЛАЛД ХҮҮХДИЙН ОРОЛЦОО

СУДЛААЧ СУРАГЧ



Төсөл нь зүүн бүсийн хэмжээнд хамгааллын үнэ цэнтэй нүүдлийн зүйлүүд болох цагаан зээр, цэн тогоруу болон БНГ-уудыг түшиглэн сургуулийн сурагчдын байгаль хамгаалах мэдлэгийг тэлж, санаачилгыг дэмжиж, тэдний үгийг орон нутгийн удирдлагад нь хүргэх зорилготой судлаач сурагч үйл ажиллагааг 2021 оноос дэмжиж ажилласан. Хар ямаатын БНГ түшиглэн орон нутгийн 9 сумын сургуулийн байгаль хамгаалах чиглэлд сонирхолтой хүүхдүүдэд биологи, экологийн хээрийн судалгааны суурь аргагүйг эзэмшүүлэхээр 8-р сард тогтмол зохион байгуулдаг.

МУИС-ын Биологийн тэнхимийн багш, оюутнуудтай хамтарч ургамал, шавж, жижиг хөхтөн амьтны судалгааны үндсэн аргуудаас хүүхдүүдэд зааж, дадлага хийлгэдэг. Мөн 2025 оны судлаач сурагчаар “байгальд амьд гарах” аргыг хөтөлбөрт нэмж оруулсан. Өнгөрсөн хугацаанд нийт 147 хүүхэд орон нутгаас оролцсон. Эдгээр хүүхдүүдээс ирээдүйд энэ чиглэлээр суралцахаар зорилгоо тодорхойлсон хүүхдүүд цөөнгүй гарсан. Мөн сумын сургуулийн “Эко клуб”-ын үйл ажиллагааг бодитоор дэмжиж, сургуулийн орчинд “байгаль хамгаалал” гэх ойлголтыг нэг удаагийн сургалт бус, тогтмол дадал болгох үндэс тавигдсан. Хар ямаатын байгалийн нөөц газрын түшиглэн орон нутгийн хүүхдүүдийн байгальд хандах хандлага, түүнийг хайрлан хамгаалах сэдлийг төрүүлсэн олон үйл ажиллагаа хэрэгжүүлж байна.

ӨСВӨРИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧ

Өсвөрийн байгаль хамгаалагч арга хэмжээгээр Эко-клубын сурагчид Хар ямаатын БНГ-ыг түшиглэн амьтан, ургамлын онцлогийг танин мэдэж, хээрийн судалгааны арга зүйн анхан шатны мэдлэгтэй болж, судалгааны багаж дуран, байршил тогтоогч ашиглан автомат камерын бичлэг авах зэрэг олон төрлийн чадварт суралцдаг. Төслийн зүгээс мэргэжлийн биологич, байгаль хамгаалагчдаар дамжуулан хүүхдүүдийн байгаль хамгаалах оролцоо, идэвх санаачилгыг нэмэгдүүлэх зорилготой.

ЯНЗАГАН ХҮРЭЭГ ХАЙРЛААРАЙ



Цагаан зээрийн популяцид тулгарч буй үндсэн аюул занал нь хууль бус агнуур, халдварт өвчин, амьдрах орчны доройтол болон тасархайтал юм. Иймд цагаан зээрийн шилжилт хөдөлгөөний холбоос нутгийг тодорхойлж (2022) амьдрах орчныг хамгаалах ажлуудыг талуудтай хамтран шат дараатай зохион байгуулсан. Иймд Зүүн аймгуудын хэмжээнд эко клубуудын хүүхдүүдийг хамруулсан “Янзаган хүрээг хайрлаарай” чуулга уулзалтыг 2021-2023 онд зохион байгуулж бүсийн хэмжээнд хэрэгжүүлэх “Тунхаг бичиг” гарган баталсан. Уг чуулга уулзалтад Зүүн бүсийн хэмжээнд 700 гаруй хүүхэд багачууд, бусад төрийн байгууллагууд оролцож, цагаан зээрийг хамгаалах аянд нэгдэцгээсэн юм.



ТОГОРУУ ШУВУУГАА УГТАЯ, УДЬЕ



Эко клубын хүүхдүүдээр дамжуулан тогоруу шувуу, түүний амьдрах орчин болсон ус намгархаг газрыг хайрлан хамгаалах, учирч буй аюул дарамтыг орон нутгийн удирдлага, иргэд малчдад ойлгуулахаар жил бүрийн хавар, намар энэхүү үйл ажиллагааг зохион байгуулсан. Цэн тогорууны амьдрах орчны орчмын айлуудтай хамтран малыг хариулгатай маллах, нохойг тодорхой хугацаанд тогтмол уяж хэвших, Эко клубын сурагчид, дэгдээхэй хамгаалагч хүүхдүүдээр дамжуулан олон нийтэд цэн тогоруу, хонин тоодог шувуудын хамгааллын үнэ цэн, ач холбогдлыг ойлгуулах чухал ажил болсон.

ТОМ АХЫН АЯЛАЛ



МҮОНТ-ийн Хүүхэд, танин мэдэхүйн нэвтрүүлгийн редакцтай хамтран "Том ахын аялал" байгаль экологийн танин мэдэхүйн цуврал нэвтрүүлгийг Хэнтий, Дорнод аймгийн арван сумаар аялан нийт 240 минутын 8 цуврал нэвтрүүлэг бэлтгэсэн. МҮОНТ-ийн 1-р суваг, MNB Гэр бүл сувгаар тус тус 2-3 удаагийн давтамжтайгаар үзэгч хүүхдүүдэд хүрэхдээ цэн тогоруу, нарсан ойн ач холбогдол, усны ач холбогдол ба булгийн эхийг хамгаалах, Хар ямаат, Тосон хулстай, Баянцагааны тал БНГ-уудын онцлог, ач холбогдол, Халх голын түүх соёлын дурсгалт газруудын талаар сонирхолтой, ач холбогдолтой мэдээллийг түгээв.

ТАТМЫН ОЙН ӨДӨРЛӨГ



Татмын ой гэж юу вэ, түүний экосистем, ач холбогдол, үнэ цэнийн талаар экоклубын сурагчдад таниулан ойлгуулах зорилготой "Татмын ойн өдөрлөг"-т Дорнод аймгийн Булган, Хөлөнбуйр, Сүхбаатар аймгийн Түмэнцогт, Хэнтий аймгийн Баян-Овоо, Баян-Адрага сумын экоклубын 100 гаруй сурагч хамрагдаж, мэдлэг мэдээллээ дээшлүүллээ. Сургалтыг танхимын болон дадлагын хэлбэрээр хамтад нь явуулсан бөгөөд хүүхдүүд татмын ойн экосистем, түүний ач холбогдлын талаар танин мэдэж, цаашлаад багаар ажиллан мэдсэн сурснаа түгээн дэлгэрүүлэх уриалга дэвшүүлж, найз нөхөд, гэр бүлийнхэндээ сурталчлан таниулахаар болсон юм.

Судлаач сурагчийн түүх Нэг зун, нэг тэмдэглэл: "Хээрийн судалгаа хүүхдийн мөрөөдлийг асаав"



Ө.Баярсайхан
МУИС-ын
Биологийн
тэнхимийн
Доктор, дэд проф.

Миний хувьд байгаль хамгааллын үйл ажиллагаа амжилттай үр дүнд хүрэх нэг нөхцөл нь тухайн нутгийн иргэдийн оролцоог хангах замаар тэдний дэмжлэгийг авах явдал гэж боддог. Энэ нь сонсох, төлөвлөхөд хэдий амархан ч хэрэгжүүлэх нь туйлын ярвигтай зүйл байдгийг байгаль хамгааллын салбарт ажиллаж байгаа хэн бүхэн мэднэ. Хэрвээ дэмжлэг авч чадвал, тухай газар нутаг дахь үйл ажиллагаа амжилттай өрнөх чухал суурь нь болдог.

Нутгийн иргэдийг шууд оролцуулахаас илүүтэйгээр ерөнхий боловсролын сурагчдыг оролцуулах нөлөөллийн хувьд илүү үр дүнтэй байдаг. Учир нь хүүхэд, залуусыг байгалийн шинжлэх ухаанд дуртай болгох, цаашлаад мэргэжлээ сонгоход нь зөвлөх, нөлөөлөх боломжтой. Мөн сумын сургуулийн "Эко клуб"-ын үйл ажиллагааг бодитоор дэмжиж, сургуулийн орчинд "Байгаль хамгаалал" гэх ойлголтыг нэг удаагийн сургалт бус, тогтмол дадал болгох үндэс тавина. Эцэст нь хүүхдийн хэлсэн үг эцэг эхэд нь бидний хэлснээс илүү үнэ цэнтэй байдгийг хожим нутгийн иргэдтэй уулзахдаа олонтоо сонссон нь бидний ажлын хамгийн чухал үнэлгээний нэг байлаа.

ДБХС-ын санаачилга, дэмжлэгээр Хар ямаатын БНГ-ийн зуны хээрийн судалгаанд бид 2017 оны зунаас эхлэн сумын ерөнхий боловсролын сургуулийн "Эко клуб"-ын гишүүн сурагчдыг оролцуулж эхэлсэн. Анхны жил Түмэнцогт, Баян-Овоо сумын 6 сурагч удирдагч багшийн хамт манай багтай нийлж, хээрийн судалгаанд оролцсон юм. Судалгааны багийн оюутнууд, залуу судлаачид сурагчдад ургамлын төрөл зүйлийн тооллого, трансектын арга, шувууг дурангаар ажиглах, булаг шандын мониторинг хийх зэрэг ажил дээр GPS ашиглах, ажиглалтаа системтэй тэмдэглэх, зүйл таних энгийн аргуудыг зааж өгдөг байв.

Хээрийн судалгаанд оролцох нь зөвхөн арга зүй сурна гэсэн үг биш. Сурагчид маань өөр хоорондоо танилцаж, өдрийн болон оройн хоолоо хамтран хийх, оюутнуудаас ирээдүйн оюутны амьдралын талаар асуулт асууж хариулт авах зэргээр "талбар дээрх жижиг нийгэм"-д баг болон ажиллаж сурдаг. Хамгийн гол нь тэд "яагаад байгаль хамгаалах ёстой вэ?" гэсэн асуултынхаа хариуг өөр өөрсдийнхөөрөө бодож олдог байлаа.

“Судлаач оюутан: Нэг санаачилгаас эхэлсэн есөн жилийн түүх...”



Ө.Баярсайхан
МУИС-ын
Биологийн
тэнхимийн
Доктор, дэд проф.

“МУИС-ийн ШУС-ийн БУС-ийн Биологийн тэнхим, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн санаачилгаар, “Дорнод Монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янз байдлын хамгаалал” (GEF7) төслийн дэмжлэгтэйгээр их, дээд сургуулиудын Биологи, Экологи, Байгаль хамгааллын чиглэлээр суралцаж буй оюутнуудын дунд “Судлаач оюутан – 2025” эрдэм шинжилгээний бага хурлыг 9 дэх жилдээ 2025 оны 12 дугаар сарын 6-ны өдөр амжилттай зохион байгууллаа.”

Ийм мэдээний тэргүүн мөрийг бид ес дэх удаагаа бичиж сууна. Харин энэ хэдхэн өгүүлбэрийн цаана олон хүний

итгэл, хөдөлмөр, бас нэгэн жижигхэн атлаа чухал санаачилга хэрхэн бүтэн үеийн залуу судлаачдыг урамшуулсан түүх нуугдаж байдаг.

Энэ түүх 2016 оны хавар эхэлсэн юм. Тэр үед бид WWF-ийн хамт олонтой ярилцаж суухдаа байгаль хамгааллын салбарт ажиллаж буй залуу судлаачид, ялангуяа биологи, экологи, байгаль хамгааллын чиглэлээр суралцаж буй оюутнуудад дэмжлэг хангалтгүй байгааг анзаарсан. Хээрийн судалгаанд оролцсон оюутнуудын зуны хөдөлмөрийг үнэлэх, хооронд нь танилцуулах, туршлага солилцуулах, хийсэн судалгааны ажлыг нь олон нийтэд хүргэх боломж цөөн байлаа. Судалгаа гэдэг тэвчээр, уйгагүй хөдөлмөр шаардсан урт зам. Тэр зам дээр залуу үеэ тогтоон үлдээхгүй бол байгаль хамгааллын салбарын ирээдүй өөрөө эмзэг болж мэдэхээр байсан.

Ингээд бид нэг зүйл дээр санал нэгдсэн. Энэ цаг үед хийх хамгийн чухал ажлын нэг нь салбартаа дуртай, энэ мэргэжлээр суралцаж буй залууст урам өгөх, хүсэл тэмүүллийг нь асаах, хадгалж үлдэх явдал байв. Тэр бодлоос “Судлаач оюутан” эрдэм шинжилгээний бага хурал төрсөн. Анхнаасаа энэ хурал зөвхөн хээрийн судалгаанд оролцдог, өөрийн цуглуулсан бодит материал, ажиглалт, үр дүн дээрээ тулгуурлан илтгэл хэлэлцдэг байхаар онцлогтой байхаар шийдсэн. Шагналын санг ч тухайн үедээ нэлээд өндөр тогтоож, оюутнуудын хөдөлмөрийг үнэлэхийг зорьсон. Тэр өндөр шалгуур, тэр үнэ цэнэ одоо ч хадгалагдсаар ирсэн нь нууц биш.

Анхны хурлаа бид 2017 онд “Судлаач оюутан: Хүмүүний оршихуй нь байгаль эхтэй харилцах бидний зохиролт үйлээс хамаатай...” уриан дор зохион байгуулж байлаа. Өнөөдөр эргээд харахад тэр хурлыг “амжилттай болсон” гэж хэлэх хамгийн том шалтгаан нь тухайн

үед индэр дээрээс илтгэл тавьж байсан оюутнууд өнөөдөр байгаль хамгааллын салбарын шинэ үеийн манлайлагчид болон ажиллаж буй явдал юм. Тухайлбал, Б.Билгүүн WWF-ийн төсөлд биологийн олон янз байдлын мэргэжилтнээр, Б.Чойдогжамц “Ирвэс хамгаалах сан”-д, Б.Долгор TNC-д, Н.Жавхлан GIZ-д, Ц.Батзаяа Хустайн БЦГ-т ажиллаж байна. Бусад оролцогчдын олонх нь судалгааны байгууллага, хүрээлэнгүүдэд мэргэжлээрээ ажиллаж, зарим нь бүр эрдмийн зэрэг хамгаалж эхэлжээ. Энэ бол нэг өдрийн хурал биш, ирээдүйн судлаачдын замд асаасан гэрэл байсны илрэл юм.

Цаг хугацаа өнгөрөх тусам “Судлаач оюутан” хурал ч тэлж, илүү өргөн хүрээтэй болж эхэлсэн. “Дорнод Монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янз байдлын хамгаалал” төслийн дэмжлэгтэйгээр бид зөвхөн биологи, экологи, байгаль хамгааллын чиглэлийн сургуулиудаар хязгаарлагдахгүй болж, байгаль хамгааллын эрх зүй, санхүүжилт, бодлого зэрэг энэ салбарт улам бүр чухал болж буй чиглэлүүдийн оюутнуудыг хамруулах болсон. Ингэснээр ДХИС, СЭЗИС, ШУТИС зэрэг сургуулийн оюутнууд ч энэ тайзнаа гарч, байгаль хамгааллыг өөр өөрийн өнцгөөс харах, оролцох боломжтой болсон юм.

Мөн бид зөвхөн илтгэлээр хязгаарлагдахыг хүсээгүй. “Шилдэг нийтлэл”, “Байгалийн гэрэл зураг” зэрэг уралдааныг хурлынхаа хүрээнд зохион байгуулж эхэлснээр оюутнуудын оролцоо, сонирхол улам бүр нэмэгдсэн. Судалгаа бол зөвхөн тоо баримт, хүснэгт, график биш; харин байгальтай харьцах мэдрэмж, харж ойлгох нүд, түүнийгээ бусдад хүргэх чадвар гэдгийг энэ бүхэн бидэнд дахин сануулсан.

Өнөөдөр “Судлаач оюутан” бол зүгээр нэг эрдэм шинжилгээний бага хурал биш болжээ. Энэ бол хээрийн судалгаанд анх удаа гарч буй оюутны догдлол, олон хоногийн ажлынхаа үр дүнг тайзан дээрээс хамгаалж буй зориг, өөртэй нь ижил хүсэл мөрөөдөлтэй хүмүүсийг олж уулзсан баяр, цааш явах итгэл юм. Есөн жилийн өмнө бидний дотроо ярилцаж эхэлсэн “залуу судлаачдаа дэмжье” гэсэн санаа өнөөдөр олон хүний мэргэжлийн замналын нэг хэсэг болж, үр жимсээ өгсөөр байна.

Магадгүй энэ хурлын хамгийн том үнэ цэнэ нь шагнал, өргөмжлөлдөө биш. Харин нэг оюутанд “чи энэ салбарт хэрэгтэй хүн шүү” гэж мэдрүүлдэгт нь оршдог байх. Тэр мэдрэмжээс л ирээдүйн судлаач, хамгаалагч, манлайлагчид төрдөг.

БАЙГАЛЬ ХАМГААЛАЛД НУТГИЙН ИРГЭДИЙН ОРОЛЦОО

Байгаль хамгаалах үйлсэд нутгийн иргэд мэдлэг түгээх, байгаль орчны хяналт тавих, орон нутгийн шийдвэр гаргалт болон байгаль хамгаалах санаачлагуудад оролцож хэрэгжүүлэх, бэлчээр нутгаа өнжөөж сэлгээх төлөвлөгөө гарган түүнийгээ хэрэгжүүлэх, орон нутгаа сурталчлах, орон нутгийн байгалийн нөөцийг зүй зохистой ашиглах зэрэг үнэтэй хувь нэмрийг оруулдаг. Иймд төслөөс орон нутгийн иргэд рүү байгаль хамгаалал, хөдөө аж ахуй, тогтвортой амьжиргаа дэмжих олон хөтөлбөр үйл ажиллагаа хэрэгжүүлсний нэг чухал хэсэг нь байгаль хамгааллын чиглэлээр үнэн зөв мэдээллээр хангах, чадавхийг нэмэгдүүлэх, шинийг санааслах урам зориг өгсөн сургалт, нөлөөллийн хөтөлбөрүүдийг тогтмол хэрэгжүүлж ирсэн.

- **Буйлс цэцэглэх цагаар** арга хэмжээ нь Хэнтий аймгийн Баян-Овоо, Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумдын залуучуудын холбоотой хамтран Хар ямаатын БНГ-ын үнэ цэн ач холбогдлыг орон нутгийн иргэдэд сурталчлан таниулах зорилготой. Мөн нутгийн иргэдийн байгаль хамгааллын манлайллыг идэвхжүүлэх, байгальд ээлтэй үйл ажиллагаанд оролцуулах (хог түүх, мэдлэг түгээх), нутгийн иргэдийн нөхөрлөлийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг. 2022 оноос хойш хэрэгжиж байгаа энэ үйл ажиллагаа нутгийн иргэдийн уламжлалт үйл ажиллагаа болсоор байна.
- **Тал нутгийн хангай** нь Хар ямаатын БНГ-ын үнэт зүйл, онцлог, хамгааллын ажлыг сурталчлан таниулах хайрлан хамгаалах зорилготой Байгалийн нөөцийн хамтын менежментийн 12 нөхөрлөлүүд, малчид, идэвхтэн байгаль хамгаалагчдын дунд тогтмол зохион байгуулагддаг мэдлэг түгээх, нөхөрлөл бэхжүүлэх, хамтран ажиллах арга хэмжээ юм. Уг үйл ажиллагаа нь Хар ямаатын Орчны бүсийн иргэд нөхөрлөлийн хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах, ингэснээр Хар ямаатын БНГ-ын хамтын менежментийн үр дүнтэй хэрэгжүүлэх томоохон



БҮС НУТГИЙН ТУРШЛАГА СОЛИЛЦОХ УУЛЗАЛТ

Даян дэлхийн байгаль орчны сан (GEF)-гийн долоо дахь удаагийн санхүүжилтээр Дэлхийн хуурай хээрийн бүсэд хамаарагдах дэлхийн 11 орны хамруулан “Хуурай газрын тогтвортой ландшафтын” нөлөөллийн хөтөлбөр (DSL-IP) хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Уг хөтөлбөрийн хүрээнд “Бэлчээрийн тогтвортой менежмент” дэд сэдвийн дор Төв Азид хэрэгжиж байгаа төслүүдийн үр дүнд бий болсон сайн туршлага, мэдлэгийг хуваалцах хоёр удаагийн арга хэмжээг 2024, 2025 онуудад зохион байгуулсан. Анхны удаа Монгол, Казакстан, Киргизстан, Туркменистан, Узбекистан, Тажикстан гэсэн зургаан орон Казахстаны Алма-Ата хотод зохион байгуулагдсан хуралд оролцож газрын доройтлыг бууруулах туршлагаа хуваалцсан.


Хоёр дахь удаад Монгол улсад хэрэгжиж буй төслийн үр дүнтэй танилцах зорилгоор төслийг хэрэгжүүлэгч НҮБ-ын ХХААБ, ДБХС (WWF-US), Олон улсын байгаль хамгаалах холбоо (IUCN), Дэлхийн газрын тогтвортой менежментийн олон улсын сүлжээ (WOCAT), Казахстан, Киргизстан улсын төлөөлөл зэрэг нийт 20 гаруй гадаадын төлөөлөгчид 2025 оны 08 дугаар сарын 18-24-ний өдрүүдэд Монгол Улсад зохион байгуулагдах семинар болон танилцах аялалд оролцлоо. Уг аялалаар Монгол Улсаас газрын доройтлыг бууруулах, тогтвортой байдлыг дэмжихэд оруулж буй сайн туршлага, гол үр дүнгүүдээс танилцууллаа.

САЙН ТУРШЛАГАА ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцийн албан ёсны түнш байгууллага болох Газрын менежментийн даян дэлхийн сүлжээ (ГМДДС, www.wocat.net)-ээр дамжуулан төслийн хүрээнд гарсан сайн туршлага, амжилтын түүхээ хуваалцаж байна. Төслийн хүрээнд цэн тогорууны амьдрах орчныг хамгаалах арга барил; булгийн эхүүдийг хаших технологиуд; Газар зохион байгуулалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу бэлчээр өнжөөсөн туршлага; уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон малын хашаа, саравчны технологи; хүлэмжийн аж ахуй, ногоон байгууламж, хүнсний үйлдвэрлэлд түшиглэн өрхийн газрын ашиглалт, үр өгөөж, үнэ цэнийг нэмэгдүүлэх “Эко гудамж” санаачилга; холимог тариалангийн менторшип хөтөлбөр, атаршсан газрыг сэргээж эргэлтэд оруулах хөрс хамгааллын газар тариалангийн технологи; малчин өрхүүд өвөлжөөндөө тэжээлийн ургамал тариалж, дарш бэлтгэх технологи зэрэг газрын доройтлыг бууруулах, уур

амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, хүн, мал, зэрлэг амьтдад ээлтэй олон арга барил, технологийг энэхүү сүлжээгээр дамжуулан бүс нутгийн болон олон улсын түвшинд танилцуулж байна.

Хуурай газрын тогтвортой ландшафтын нөлөөллийн хөтөлбөрийн үр дүнд (DSL Program and Land Monitoring System) Монгол улсаа төлөөлөн хувь нэмэр оруулж байгаа бөгөөд үр дүнгийн товчоон хэвлүүлсэн бөгөөд уг хөтөлбөрийн дашбоардоос үр дүнг нээлттэй харах боломжтой.



Зураг. Нөлөөллийн хөтөлбөрийн бүртгүүлсэн үр дүн

МЭДЛЭГ, МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГААНЫ БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД

Ном, гарын авлагын жагсаалт

1. Дорнод Монголын цагаан зээрийн (*Procarpa gutturosa*) холбоос нутгийг тодорхойлох нь. Судалгааны тайлан 2022 (Монгол-Англи)
2. Хар ямаатын байгалийн нөөц газрын танилцуулга 2023
3. Хонин тоодогийн нууцлаг амьдрал
4. Цэн тогоруу, хонин тоодогийн мониторингийн дэвтэр 2025
5. Тогорууны амьдрал 2026
6. Амьтны ул мөр таних гарын авлага 2026
7. Нөхөн сэргээх газар тариалан 2023, 2026
8. Тариалангийн талбайг мал, зэрлэг амьтдад хал багатай байдлаар хашаажуулах 2025
9. Бэлчээрийг зохистой ашиглах, хянах гарын авлага 2026
10. Монгол орны бэлчээрийн түлхүүр зүйл ургамлын зурагт лавлах 2026
11. Сүү, сүүн бүтээгдэхүүний технологийн лавлах 2023
12. Хурганы мах үйлдвэрлэл 2023

Танилцуулга материал

13. Тал нутгийн хангай-Хар ямаатын байгалийн нөөц газар 2023
14. Тосон-Хулстайн байгалийн нөөц газар 2025
15. Баянцагааны тал Байгалийн нөөц газар 2026
16. Улз голын эх байгалийн нөөц газар 2026

Сургалтын хөтөлбөр, эмхэтгэл

17. Өсвөрийн байгаль хамгаалагч. Хар ямаатын байгалийн нөөц газар, Өвлийн хөтөлбөр
18. Янзган хүрээг хайрлаарай 1-3. Багш нарт зориулсан сургалтын хөтөлбөрийн эмхэтгэл
19. Татмын ойн өдөрлөг. Сургалтын гарын авлага 2023
20. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн үр ашигт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам 2025
21. Газар зохион байгуулалт, төлөвлөлтийн журам, аргачлалын эмхэтгэл 2026
22. Газрын мониторингийн журам, аргачлалын эмхэтгэл 2026
23. Зээрийн янзага. Зурагт ном 2025
24. Хялганат хээрийн мэдээ Сонин 1-3 дугаар
25. Жавхлант мэдээ сонин 1 дугаар

Олон нийтэд зориулсан баримтат кино, бичлэгийн жагсаалт

1. Монголын хээр баримтат кино <https://www.youtube.com/watch?v=67ITkI8Ox4g&t=369s>
2. Монгол тарваганы амьдрал баримтат кино <https://www.youtube.com/watch?v=LKP9it996EE&t=41s>
3. Цагаан зээрийн хүзүүвчны мэдээ https://youtube.com/shorts/H3D-j3_92xzl?feature=share
4. Дэлхийд ганцхан монгол тал: Нутгаа сэлгэж, бэлчээрээ сэргээе <https://www.youtube.com/watch?v=hH0P7Ci2xFk&list=PLiiTv9HucbP3bwzIKBcz69mLYB3ufXtwM>
5. Дэлхийд ганцхан монгол тал: Аав, хүү тариаланчид https://www.youtube.com/watch?v=O-HvODf_AgM&list=PLiiTv9HucbP3bwzIKBcz69mLYB3ufXtwM&index=2
6. Дэлхийд ганцхан монгол тал: Нөхөн сэргээх газар тариалан <https://www.youtube.com/watch?v=zK26OivL5yk&list=PLiiTv9HucbP3bwzIKBcz69mLYB3ufXtwM&index=3>
7. Дэлхийд ганцхан монгол тал: Эко гудамж https://www.youtube.com/watch?v=KciM_2KZFyU&list=PLiiTv9HucbP3bwzIKBcz69mLYB3ufXtwM&index=4
8. Дэлхийд ганцхан монгол тал: Өвөлжөө, хаваржааны газартаа ногоон тэжээл тарьсан туршлага <https://www.youtube.com/watch?v=49KVCxD7Wc8&list=PLiiTv9HucbP3bwzIKBcz69mLYB3ufXtwM&index=5>
9. Дэлхийд ганцхан монгол тал: Эмэгтэйчүүдийн бүлгийн ногоочин <https://www.youtube.com/watch?v=USoNUGQ2bV4&list=PLiiTv9HucbP3bwzIKBcz69mLYB3ufXtwM&index=6>
10. Дэлхийд ганцхан монгол тал: Залуу тариаланч Лувсандагва <https://www.youtube.com/watch?v=GRfk9Ib2v8s&list=PLiiTv9HucbP3bwzIKBcz69mLYB3ufXtwM&index=7>
11. Дэлхийд ганцхан монгол тал: Технологи нэвтрүүлсэн малчдын хоршоо <https://www.youtube.com/watch?v=bbEQ1kfUzYM&list=PLiiTv9HucbP3bwzIKBcz69mLYB3ufXtwM&index=8>
12. Улз голын эхийг хашиж хамгаалсан <https://www.youtube.com/watch?v=sDRtWX320cU>
13. Судлаач хүүхдүүд <https://www.youtube.com/watch?v=p-d5ySeBLbo>
14. Дөрвөн зүйл тогоруу <https://www.youtube.com/watch?v=wV5Ij3Ch-Hf4>
15. Харандааны түүх: Хоршоо <https://www.facebook.com/reel/2365088450359004>
16. Зөгийчин <https://www.youtube.com/watch?v=OcOdVRrjWsE>